

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай
хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт
зохион байгуулах арга зүй





БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From
the People of Japan



Save the Children

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

**“Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт
хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүй”
Сургалтын модуль**

БОЛОВСРУУЛСАН:

С.УНДРАЛ /НТБҮТ-ийн мэргэжилтэн/

Л.ЭРДЭНЭЧИМЭГ /НТБҮТ-ийн мэргэжилтэн/

Б.ОЮУН-ЭРДЭНЭ /БЗД-ийн АБ-НТБТ-ийн багш/

Улаанбаатар хот

2020 он

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүнлэгийн, ашгийн бус олон улсын төрийн бус байгууллага юм.

ХИС нь Японы Гадаад Харилцааны Яамны санхүүжилтээр “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийг 2018 оны 3 дугаар сараас эхлэн 3 жилийн хугацаанд Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Өвөрхангай, Ховд аймгийн 16 сургууль, насан туршийн боловсролын 5 төвд хэрэгжүүлж байна.

Төслийн зорилтууд

1. Ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бүрдүүлэх;
2. Насан туршийн боловсролын төвийн чадавхыг сайжруулах, сургуульд хамрагдахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах;
3. Тэгш хамруулах боловсролын талаар эцэг эх/асран хамгаалагчид, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах;
4. Төслийн үр дүн, сайн туршлагад үндэслэн зөвлөмж боловсруулах замаар төрийн бодлого, зохицуулалтад нөлөөлөх;

Төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төвийн багш, ажилтнууд, эцэг эхчүүдэд зориулсан дараах 3 төрлийн сургалтын модулийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль-24 цаг (3 өдөр)
2. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүй-16 цаг (2 өдөр)
3. Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх арга зүй-16 цаг (2 өдөр)

**“ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫГ ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДҮҮДТЭЙ
ХОЛИМОГ БҮЛЭГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТЫН МОДУЛЬ**

(3 дахь хэвлэл)

Тус модулийг “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

© Хүүхдийг Ивээх Сангийн зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.



АГУУЛГА

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
БҮЛЭГ 1. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДҮҮДЭД БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ СУРГАЛТ	
1.1. Холимог бүлгийн сургалт, түүний онцлог	6
1.2. Холимог бүлгийн багш	15
БҮЛЭГ 2. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ	
2.1. Холимог бүлэгт нэг цагт нэг хичээлийг өөр өөр түвшинд заах аргачлал	35
2.2. Холимог бүлгийн сургалтын хичээлийн хөтөлбөр, төлөвлөлт	42
- анги зохион байгуулалт	
- хичээлийн хэрэглэгдэхүүн	
2.3. Холимог бүлгийн сургалтын үнэлгээ	57
- Суралцагчдын мэдлэгийн түвшинг үнэлэх, жишиг даалгавар боловсруулах арга зүй	
БҮЛЭГ 3. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРАЛЦАГЧДЫН СУРАХ, ХӨГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ АРГА	
3.1. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр дамжуулан суралцагчдыг ЕБС-д бэлтгэх үйл ажиллагаа	66
3.2. ЕБС-ийн зохих ангид шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох, суралцах чадварыг дэмжих арга хэмжээ	83
ХАВСРАЛТ	
1. Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр	127
2. Боловсрол нөхөн олгох сургалтад гэрээр сурах суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах үлгэрчилсэн гэрээ	138
3. Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх судалгааны асуулга	142
4. Ганцаарчилсан сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө	145
5. Гэрээр суралцагч хүүхдийн ахиц, өөрчлөлтийн талаарх багшийн тэмдэглэл, судалгаа	151
6. Ээлжит хичээлийн үлгэрчилсэн хөтөлбөр	160
7. Сургалтын үйл ажиллагааны хяналтын хуудас	162
8. Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас	163
ЗАРИМ ҮГСИЙН ТОВЧ ТАЙЛБАР	166
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	168



МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Модулийн бүтэц	
Сургалтын нэр	"Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүй"
Зорилтот бүлэг	Насан туршийн боловсролын төвийн багш нар
Сургалтын багц цаг	16 цаг
Модулийн зорилго	- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах арга зүй; - Боловсрол нөхөн эзэмшсэн хүүхдүүдийг сургуульд дасан зохицох, тэдний сурах, хөгжих үйл ажиллагааг дэмжих арга барилд суралцах

Модулийн агуулгын хүрээ	Арга зүй
Бүлэг 1. Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалт-5 цаг 1.1. Холимог бүлгийн сургалт, түүний онцлог 1.2. Холимог бүлгийн багш	Оролцогчдын: - идэвх, оролцоог нэмэгдүүлсэн, - бүтээлчээр сэтгэх, - хамтран ажиллах, - мэдээлэл боловсруулах, - асуудал шийдвэрлэх чадваруудыг дэмжсэн
Бүлэг 2. Холимог бүлгийн сургалтыг зохион байгуулах арга зүй - 6 цаг 2.1. Холимог бүлэгт нэг цагт нэг хичээлийг өөр өөр түвшинд заах аргачлал 2.2. Холимог бүлгийн сургалтын хичээлийн хөтөлбөр, төлөвлөлт 2.3. Холимог бүлгийн сургалтын үнэлгээ	- идэвх, оролцоог нэмэгдүүлсэн (эвлүүлгийн, лекцийн, тоглоомын, тайлбартай дасгалын) - мэдээлэл боловсруулах, - асуудал шийдвэрлэх, - бүлгээр ажиллах, - мэдлэг бүтээх чадваруудыг дэмжсэн



Бүлэг 3. Холимог бүлгийн суралцагчдын сурах, хөгжих үйл ажиллагааг дэмжих арга - 5 цаг

- 3.1. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр дамжуулан суралцагчдыг ЕБС-д бэлтгэх үйл ажиллагаа
- 3.2. ЕБС-ийн зохих ангид шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох, суралцах чадварыг дэмжих арга хэмжээ

- идэвх оролцоог нэмэгдүүлсэн,
- бүтээлчээр сэтгэх,
- хамтран ажиллах,
- мэдээлэл боловсруулах,
- асуудал шийдвэрлэх чадваруудыг дэмжсэн

Хүрэх үр дүн

- Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах арга зүйтэй болно, түүнийгээ сургалтад ашигладаг болно.
- Боловсрол нөхөн эзэмшсэн хүүхдүүдийг сургуульд дасан зохицох, тэдний сурах, хөгжих үйл ажиллагааг дэмжих арга барилд суралцсан байна.

Үнэлгээ дүгнэлт:

Сурсан зүйлсээ ажил, амьдралд хэрэглээ болгож чадаж байгаа эсэхээр өөртөө дүгнэлт өгнө.

Сургалтын хэрэглэгдэхүүн:

Тараах материал, сургалтын хэрэгсэл, үзүүлэн, дасгал даалгавар, судалгааны хүснэгт, график, кейс, техник тоног төхөөрөмж

Сургалт явуулах хэрэгцээ:

ЕБС-ийн зохих ангид шилжин суралцах, дасан зохицож үргэлжлүүлэн боловсрол эзэмшихэд онцгой хувь нэмэр оруулах болно.



БҮЛЭГ 1. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДҮҮДЭД БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ СУРГАЛТ

ДЭД СЭДЭВ 1.1. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

ЗОРИЛГО	- Холимог бүлгийн сургалт, түүний хэрэгцээ, шаардлага, сургалтын тогтолцооны талаар мэдлэгтэй болох, мэдлэгээ хэрэглэх чадвар эзэмших - Холимог бүлгийн сургалтын аргыг сургууль завсардсан болон сургуульд огт суралцаж байгаагүй тусгай хэрэгцээт хүүхдүүдэд хэрэглэх чадвар эзэмших - Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт сургалт явуулах туршлагатай болох
ХУГАЦАА	2 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Сургууль завсардсан болон сургуульд огт суралцаж байгаагүй тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах мэдлэг, чадвар эзэмшинэ.
АРГА ЗҮЙ	Оролцогчдын: • идэвх оролцоог нэмэгдүүлсэн, • бүтээлчээр сэтгэх, • хамтран ажиллах, • мэдээлэл боловсруулах, • асуудал шийдвэрлэх чадваруудыг дэмжсэн

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. Оролцогчдын мэдлэгийн түвшинг нэгтгэх зорилгоор ярилцлага зохион байгуулах

Хүрэх үр дүн: дээрх асуудлаар оролцогчид нэгдсэн ойлголттой болно.

Зарцуулах хугацаа: 20 мин

2. Шаардлагатай тоон үзүүлэлт, хүснэгт, график, зураг ашиглан шинэ мэдээлэл өгөх

Хүрэх үр дүн: Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн



сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдэд холимог бүлгээр зохион байгуулах онолын мэдлэг эзэмшинэ. Зарцуулах хугацаа: 40 мин

3. Дадлага ажил №1. Уламжлалт сургалт, холимог бүлгийн сургалтын ялгааг тодорхойлох

Хүрэх үр дүн: тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт сургалт зохион байгуулах ажлын чиглэл, зорилго, гарах үр дүнг зөв тодорхойлно.

Зарцуулах хугацаа: 20 мин

4. Дадлага ажил №2. Боловсролын үйлчилгээний гадна буй тусгай хэрэгцээт хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах боломж, арга замыг тодорхойлох

Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах арга замыг тодорхойлно.

Зарцуулах хугацаа: 35 мин

5. “Холимог бүлгийн сургалт, түүний онцлог” хичээлийн дүгнэлт–5 мин

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. Багшийн РР хэлбэрээр бэлтгэсэн илтгэл
2. Сургалтад шаардлагатай тодорхойлолтууд
3. Ярилцлагад ашиглах хүснэгт, график
4. Урьдчилан бэлтгэсэн дасгал, даалгаврууд
5. Дадлага ажлын цаас
6. Маркер
7. Өнгийн наалддаг цаас

ДААЛГАВАР №1: Оролцогчдын мэдлэгийн түвшинг нэгтгэх зорилгоор тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, боловсролыг дүйцүүлэн эзэмшүүлэх, холимог бүлгийн сургалтын арга, сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй суралцагчид, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог зэрэг асуудлаар ярилцлага зохион байгуулна. Хананд ярилцлагад хэрэг болох тодорхойлолтуудыг байрлуулсан байна.



Тодорхойлолт:

Тэгш хамруулах боловсрол-Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн тасралтгүй үйл явц.

Тусгай хэрэгцээт боловсрол-боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн-бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн согогтой нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

Дүйцсэн хөтөлбөр нь албан боловсролын агуулгатай дүйцэх боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн албан бус боловсролын боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр.

Холимог бүлгийн сургалт гэдэг нь нэг багштай, нэг ангид нас, сэтгэхүйн өөр өөр түвшний суралцагчдад нэг цагт нэг хичээл эсвэл өөр өөр хичээл судлах сургалтыг хэлнэ.


ДААЛГАВАР №2. Ярилцлагын үеэр гарсан оролцогчдын саналыг нэгтгэн дүгнэснээр багшийн РР хэлбэрээр бэлтгэсэн мэдээлэл хийгдэнэ: боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалт, түүнтэй холбоотой гарсан эрх зүйн баримт бичгүүд, холимог бүлгийн сургалтын аргын онцлог, тусгай хэрэгцээт хүүхдүүд холимог бүлгээр боловсрол нөхөн эзэмших хэрэгцээ, боломж, тулгарч буй бэрхшээл г.м. Шаардлагатай тоон үзүүлэлт, хүснэгт, график, зураг ашиглагдана.



Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, насны бүлэг, төрлөөр, 2017 он¹

Насны бүлэг	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр			
			Төрөлхийн		Олдмол	
	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь
0-14	8 835	100	6 656	75.3	2 179	24.0
15-17	2 618	100	1 759	67.1	859	32.8
18 +	92 177	100	35 969	39.0	56 208	60.9
Бүгд	103 630	100	44 384	42.8	59 246	57.1
Улаанбаатар хотод нийт	34 246	100	14 106	41.1	20 140	58.8
0-14	3 617	100	2 875	79.4	742	20.5
15-17	830	100	620	74.6	210	25.3
18 +	29 799	100	10 611	35.6	19 188	64.3

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хэлбэрээр, 2017 он²



№3. Дадлага ажил 1. Оролцогчдыг 2 баг болгон хувааж уламжлалт сургалт, холимог бүлгийн сургалтын ялгааг өгөгдсөн хүснэгтийн дагуу ярилцаж тодорхойлно.

¹ Статистикийн жилийн эмхэтгэл 2017

² Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа 2017



	Уламжлалт сургалт	Холимог бүлгийн сургалт
Сургалтын хөтөлбөр		
Багш		
Туслах багш		
Суралцагчид		
Сургалтын материал		
Мэдээллийн эх сурвалж		

№4. Дадлага ажил 2. Оролцогчдыг 3 баг болгон хувааж боловсролын үйлчилгээний гадна буй тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг тэгш хамруулахад:

- а) сэтгэл зүйн орчин
- б) боловсролын орчин
- в) эрх зүйн орчин ямар байгаа, ямар байх шаардлагатай. Түүний тулд багш юу хийх зэрэг асуудлыг ярилцан эдгээр асуудал нь сургуулийн, Холимог бүлгийн сургалт (ХБС)-тай ангийн хувьд ямар байгааг ярилцан тодруулж, асуудлыг тусган, арга замыг тодорхойлж бичсэн өнгийн цаасаа хүснэгтэд наана.

Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад холимог бүлгээр хичээллэж буй тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах асуудлыг шийдвэрлэх арга зам			
Өнөөгийн байдал	Сэтгэл зүйн орчин бүрдүүлэх	Боловсролын орчин бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдүүлэх

№5. “Холимог бүлгийн сургалт, түүний онцлог” хичээлийн дүгнэлт–5 мин

МЭДЭЭЛЭЛ 1. Холимог бүлгийн сургалт

Холимог бүлгийн сургалт зохион байгуулах нь эртний уламжлалтай. “Холимог бүлгийн сургалт” гэсэн нэр томъёо манай улсад сүүлийн жилүүдэд сонсогдох болсон боловч сургалтын ийм хэлбэр эрт дээр үеэс хэрэглэгдэж ирсэн байна. Зарим сурвалж бичигт өгүүлснээр монголд анх бичиг, соёл үүссэн цагаас гэрийн сургуулиар олгож байсан бичиг үсгийн сургалт болон шашны сургалтуудад насны хязгаар харгалзахгүй, цөөхөн хүүхдийн дотор шавилан сургах хэлбэрээр явуулж байсан нь



холимог бүлгийн эхлэл байсан гэж үзэж болох юм. Албан сургууль үүссэн хойно ч уг сургалтын хэлбэр оршсоор байснаар барахгүй, насанд хүрэгчдийн сургалтад ч түгээмэл хэрэглэж байсан байна. Ялангуяа, 1949 оноос эхэлсэн шинэ бичиг үсгийн кампанит ажил нь жинхэнэ холимог бүлгийн хэлбэр байсан байна. Түүнчлэн 1952 оноос эхэлсэн “Бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэх тухай” төрийн бодлогыг хэрэгжүүлэх үед анги, танхимын хүрэлцээ муу, багшийн тоо дутагдалтай байснаас үүдэн сургалтыг холимог бүлгийн аргаар явуулж байв. Энэ үед нэг танхимд ялгаатай насны суралцагчдыг хамт суулган, түвшин бүрт тохирсон сургалтыг нэг багш явуулахдаа ангийн өөр өөр хананд байрлуулсан самбар ашиглаж байсан жишээ байна.³

Холимог бүлгийн сургалтаар хичээллэж байгаа суралцагч нэг бүр өөр өөр арга барилаар, өөр өөр түвшинд суралцдаг. Энэ бүлэгт сургалт явуулж байгаа багш янз бүрийн насны суралцагчид хамтдаа сурах, харилцан туслах зэргээр гэр бүлийн халуун дулаан орчинг бүрдүүлдэг онцлогтой.

Холимог бүлгийн сургалт гэдэг нь нэг багштай, нэг ангид нас, сэтгэхүйн өөр өөр түвшний суралцагчид нэг цагт нэг хичээл эсвэл өөр өөр хичээл судлах сургалтыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, холимог бүлгийн сургалт нь цаг хугацаа болон орон зайн хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш түвшинд суралцагчид нэг танхимд хамт хичээллэх сургалтын хэлбэр бөгөөд энэ нь тусгай хэрэгцээт хүүхдэд боловсролын үйлчилгээг тэгш, тасралтгүй, чанартай олгоход багшийн хүрэлцээ, анги танхимын хомсдол, цаашлаад эдийн засгийн нөөц боломж зэрэг тулгамдаж буй олон асуудлыг шийдэхэд дэлхий нийтийн сургалтын практикт нэвтэрч буй сургалтын **шинэ арга зүй** юм.

Холимог бүлгийн сургалт нь нэг талаас дэлхий нийтээр бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад, нөгөө талаас тухайн газар орны хүн амын хэрэгцээг хангаж, янз бүрийн шалтгаанаар сургууль завсардсан тусгай хэрэгцээт суралцагчдад чанартай боловсрол эзэмшүүлэх давхар боломжийг олгодгоороо чухал **ач холбогдолтой**.

МЭДЭЭЛЭЛ 2. Холимог бүлгийн сургалтын онцлог

- Нэг түвшний ангид суралцаж байгаа хэдий ч суралцагчдын ур чадвар, нас, биеийн болон оюуны хөгжил адил байдаггүй. Иймд

³ Монголын боловсролын түүхэн товчоон. Ш.Шагдар



суралцагч бүрийн хөгжлийн түвшин, сонирхол, хэрэгцээг хангах уян хатан сургалтын арга барил шаардлагатай;

- Багшийн заасан зүйлийг хүлээж авах, ойлгох, сурах нь жирийн сургалтын хэлбэртэй харьцуулахад ялгаатай;
- Хүүхэд хүүхдээсээ харилцан суралцах боломж өргөн. Ялангуяа нэг гэр бүлийн, нэг ангийн, нэг сургуулийн хүүхдүүд нэг нь нөгөөдөө зааж сургах боломж илүү;
- Суралцагчид тэгш хамрагдах боломжийг бүрдүүлдэг. Хүүхдийн тоо бага байдаг нь суралцагч нэг бүрийн биеийн болон оюуны хөгжлийн онцлогийг харгалзан тулж ажиллах нөхцөлийг бий болгодог;
- Багш, суралцагчийн харилцаа харьцангуй ойр дотно, багшийн анхаарал халамж суралцагчдад мэдрэгддэг;
- Хүүхдүүд харилцан бие биедээ туслах, хамтран сурах зарчимд суурилан сургалт явагддаг тул нийгэмших, бие биеэ хүндлэх, бусдын талаар эерэг хандлага төрүүлэхэд туслах орчин бүрдэж байдаг. Ялангуяа хүүхэд бүрийн онцлог чанарыг харгалзан эерэг уур амьсгал бүрдүүлэх талаар багш анхаарах аваас сургуулийн орчин таатай болдог;
- Холимог бүлгийн сургалтын арга нь хүүхэд бүрийн хөгжлийн түвшин, сонирхол, хэрэгцээг хангах уян хатан хэлбэрийг ашиглах боломж олгодог;
- Суралцагч бүрт тохирсон сурах арга барил эзэмшүүлснээр өөрсдийгөө хөгжүүлэх, сурах явцад тулгарах бэрхшээлийг бусадтай хамтран даван туулах боломжтой.

Иймд тусгай хэрэгцээт хүүхдүүдийг холимог бүлгээр сургах нь:

1. Сургуульд огт хамрагдаж байгаагүй болон сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй, гандан хийдэд шавилан суудаг г.м. хүүхдүүдийг сургах өртөг багатай арга
2. Амьдралын янз бүрийн түвшний хүүхдүүдийг үе тэнгийнхнийхээ тусламжтайгаар суралцах, хоорондоо ойртон нягтрах, хамтран ажиллах, эрүүлээр өрсөлдөхөд тус дөхөм болохын сацуу тэдний нийгэмших болон харилцааны чадварыг хөгжүүлэх эерэг хандлагыг төлөвшүүлэх сайн талтай
3. Холимог бүлгийн багшийн хувьд ажлаа илүү сайн төлөвлөж, цагаа үр дүнтэй ашиглахад тустай
4. Суралцагчдын танин мэдэхүйн хөгжилд холимог бүлгийн сургалтын олон аргыг ашиглах нь ахиц гаргах сайн талтай гэж үздэг.



Холимог бүлгийн сургалт	
Давуу тал	Сөрөг тал
- Хамгийн уян хатан хэлбэрийн сургалт - Багаар ажиллах, бүлгээр хичээллэх боломжтой - Бие биеэсээ харилцан, хамтарч суралцах орчин бүрддэг - Сургалтын орчин-суралцагч төвтэй	- Хичээлийн киррикулим холимог бүлгээр сургалт явуулахад төдийлэн зохицдоггүй - Насны хувьд, мэдлэгийн хувьд, эрүүл мэндийн хувьд ялгаатай хүүхдүүдэд нэг хичээл заахад хэцүү
- Үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээт боловсрол шаардагддаг хүүхдүүдэд тохиромжтой - Хүүхдэд ээлтэй, суралцахад ээлтэй орчин бүрддэг - Гэр бүлд илүү ойртсон бүлээн, дулаан уур амьсгал бүрддэг - Оролцооны дээд түвшинд сургалт явагддаг - Суралцагчдын ганцаарчлан болон бие даан ажиллах ур чадварыг сайн хөгжүүлдэг - Шинэлэг зүйл, өөрчлөлтийг цаг тухай бүрт нь сургалтын агуулгад тусгах боломжтой - Эдийн засаг, хүний нөөцийн хувьд хэмнэлттэй	- Багшийн бэлтгэл ажил цаг их авдаг - Сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг ялгавартай бэлтгэх, хэрэглэхэд цаг их зарцуулдаг - Багш нэг цагт, нэг ангид өөр өөр түвшний хүүхдүүдэд хичээл заахад хүндрэлтэй - Зохион байгуулалт муу байвал сургалтын цагийг дэмий үрэх аюултай

МЭДЭЭЛЭЛ 3. Уламжлалт болон холимог бүлгийн сургалтын ялгаа

	Уламжлалт сургалт	Холимог бүлгийн сургалт
Сургалтын хөтөлбөр	Тогтсон стандарт	Уян хатан, олон хувилбартай
Багш	Мэдлэг түгээгч	Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах арга барил эзэмшсэн: - Зөвлөгч, чиглүүлэгч - Мэдлэгийг хамтран бүтээгч анд нөхөр
Туслах багш	Шаардлагагүй	Байх ёстой



<i>Суралцагчид</i>	Нас, сэтгэхүйн түвшин адил Сурагчдын тоо их Хамтран ажиллах, харилцан суралцах нь бага	Нас, мэдлэг, чадвар, бие болон эрүүл мэндийн хувьд ялгаатай Ангид хичээллэх хүүхдийн тоо цөөн Нэг гэр бүлийн ах дүү, айл саахалтынхан, найз нөхөд нэг ангид суралцдаг Суралцагчид бие биедээ туслах, хамтран ажиллах, бие даан дадлага ажил хийх цаг ихтэй Хичээлийн хуваарь, хөтөлбөр уян хатан, өвөрмөц, хөдөлгөөнтэй
<i>Сургалтын материал</i>	Стандартад тохирсон тогтсон сурах бичиг	Тусгай хэрэгцээний онцлогт тохирсон сурах бичиг, модуль, дүйцсэн хөтөлбөрийн сурах бичиг
<i>Мэдээллийн эх сурвалж</i>	Багш	Суралцагч Сургалтын орчин Нийгмийн орчин Бусад туслах багш нар



ДЭД СЭДЭВ 1.2. ХОЛИМОГ БҮЛГИЙН БАГШ

ЗОРИЛГО	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах багшийн ажлын онцлог, үүрэгтэй танилцах
ХУГАЦАА	3 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах холимог бүлгийн багшийн үүрэг, ажлын онцлогийн талаар мэдлэгтэй болно. Боловсрол нөхөн олгох сургалтыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулах мэдлэг, арга барилтай болно. Өөрийн ажилд хэрэглэнэ.
АРГА ЗҮЙ	• оролцоог идэвхжүүлэх, • чиглүүлэх, • бүтээлчээр сэтгэх, • хамтран ажиллах, • мэдээлэл боловсруулах, • асуудал шийдвэрлэх чадваруудыг дэмжсэн

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч боловсрох эрх албан болон албан бус боловсролын хүрээнд хэрхэн хангагдаж буй талаар ярилцлага өрнүүлэх

Хүрэх үр дүн: дээрх асуудлаар оролцогчид нэгдсэн ойлголттой болно, зарим асуудлыг өөрсдийн хүчээр шийдвэрлэх гарцыг олно, ажил амьдралд хэрэгжүүлнэ.

Зарцуулах хугацаа: 15 мин

2. Дадлага ажил №1. Сургуулийн гадна буй хүүхдүүдийг илрүүлэх судалгааны асуулга боловсруулах

Хүрэх үр дүн: тодорхой асуудлаар судалгааны асуулга боловсруулж дүгнэлт хийдэг болно.

Зарцуулах хугацаа: 30 мин



3. Дадлага ажил №2. Өгөгдсөн кейс дээр ажиллаж дүгнэлт хийх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох

Хүрэх үр дүн: тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн сургалтын явцад багшид тулгарах асуудлуудыг шийдвэрлэх гарцтай, бэлтгэлтэй болно.

Зарцуулах хугацаа: 30 мин

4. Дадлага ажил №3. Өгөгдсөн тодорхойлолтыг үндэслэн багшийн хийх нөлөөллийн ажлын төлөвлөгөөг гаргах

Хүрэх үр дүн: тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн багшийн орон нутаг, олон нийт, сургууль, эцэг эхийн дунд зохион байгуулах нөлөөллийн ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулагдана.

Зарцуулах хугацаа: 30 мин

5. Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах холимог бүлгийн багшийн үүрэг, ажлын онцлог, стратегийн талаар мэдээлэл өгөх Шаардлагатай тоон үзүүлэлт, хүснэгт, график, зураг ашиглагдана.

Хүрэх үр дүн: Олсон мэдлэгээ өдөр тутмын сургалтад хэрэглэх чадвартай болно.

Зарцуулах хугацаа: 15 мин

6. Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөр, түүний онцлог, ач холбогдолын талаар ярилцлага зохион байгуулах.

Хүрэх үр дүн: бага, суурь, бүрэн дунд боловсролыг дүйцүүлэн эзэмшүүлэх хөтөлбөр, арга зүйн талаар нэгдсэн ойлголттой болно.

Зарцуулах хугацаа: 20 мин

7. Дадлага ажил №4. Өгөгдсөн бага боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг судлан аргачлалын дагуу суурь болон бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсруулах.



Хүрэх үр дүн: бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө боловсруулах чадвартай болно.

Зарцуулах хугацаа: 25 мин

8. Дадлага ажил №5. Хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн онцлог бүхий хүүхдэд гэрээр бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулахад оролцох талуудын (байгууллага, хувь хүн) үүргийг тодорхойлох.

Хүрэх үр дүн: боловсрол нөхөн олгох сургалтыг гэрээр зохион байгуулахад багштай хамтран ажиллах бусад байгууллага, баг хамт олон, хувь хүмүүсийн үүрэг, ажлын чиглэл толдорхой болно.

Зарцуулах хугацаа: 15 мин

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. Багшийн РР хэлбэрээр бэлтгэсэн илтгэл
2. Урьдчилан бэлтгэсэн дасгал, даалгаврууд
3. Дадлага ажлын цаас
4. Маркер
5. Өнгийн наалддаг цаас
6. Скоч

ДААЛГАВАР

№1. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурч боловсрох эрх албан болон албан бус боловсролын хүрээнд хэрхэн хангагдаж буй талаар ярилцлага өрнүүлснээр сурах эрх нь зөрчигдөөд байгаа шалтгааныг тодруулан өнгөт цаасан дээр бичиж самбарт наана. Эдгээр шалтгааныг арилгах ямар боломж, арга зам холимог бүлгээр сургалт зохион байгуулж буй багшид байгааг мөн бичиж харалдаа байршуулна.

№2. Дадлага ажил 1. Оролцогчдыг 3 баг болгон хувааж, баг тус бүр дараах даалгаврыг гүйцэтгэнэ:

- а. Сургуулийн гадна буй хүүхдүүдийг илрүүлэх судалгааны асуулга боловсруулах (судалгааны зорилго, хүрэх үр дүнг



тооцох)

- b. Судалгааг хамтран авах багийн гишүүдийг тодруулах (ямар байгууллагын, ямар албан тушаалтнуудтай, ямар зорилгоор, яаж ажиллах г.м.)
- c. Судалгааны асуулгыг үндэслэн нэгдсэн дүгнэлтийг хийх (юуг мэдэх гэж, ямар асуулт тавьсан)

Баг тус бүр өөрсдийн боловсруулсан судалгааны асуулга, хүрэх үр дүн, гарах дүгнэлтийг танилцуулна. 3 багийн хийсэн судалгааны асуулга, дүгнэлтийг ярилцан санал солилцоно.

№3. Дадлага ажил 2. Оролцогчдыг 2 баг болгон хувааж тарааж өгөх кейс дээр ажиллуулах, дүгнэлт хийлгэх, тухайн кейс-д тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжуудын талаарх өөрийн саналыг танилцуулна.

Хүүхдэд тулгамдаж буй бэрхшээл	Шийдвэрлэх арга зам		
	улсаас	сургуулиас	багшаас



Кейс 1.

15 настай О-ийн ээж: "Миний хүү хөдлөх эрхтний бэрхшээлээс болоод таягтай явдаг. Татаж унадаг, хавсарсан бэрхшээлтэй. Оюун ухааны тогтоолт муу. Зан төлөв сайн. Сонсгол сайн. Миний хүү цэцэрлэгт ер явж байгаагүй. Сургуулийн нас хүрэхэд нэгдүгээр ангид хагас явсан. Эмнэлэгт байн байн хэвтдэг болохоор сургууль завсардсан. Өрхийн орлого бага, дээр нь хүүхдийн сурах чадвар үе тэнгийн хүүхдүүдээсээ нэлээд хоцрогдолтой, сул байсан. Одоо хэр нь бичиг үсэг мэдэхгүй. Үе тэнгийнхэн нь шоолдог, ялгаварлан гадуурхдаг. Үүнд нь ээжийн хувьд эмзэглэж явдаг. Хүүхэд маань өөрөө сурах сонирхолтой боловч ердийн сургууль авах дургүй, сургуулийн удирдлага, багш нарын хандлага сөрөг байдаг. Сургуульд заадаг хичээл нь манай хүүд хүндэдсэн. Өөрөө хөл муутай болохоор сургуульд ирж очих нь хүндрэлтэй байдаг байсан."



Кейс 2.

15 настай Н-ийн аав: “Миний хүү унаж татдаг, таталтаас хоёрдогчоор үүсэлтэй оюун ухааны хомсдолтой, хөдлөх эрхтний ямар нэгэн бэрхшээл үгүй. Үе тэнгийн хүүхдүүдээс хөгжлөөр сул, хоцрогдмол. Манай хүү цэцэрлэгт явж байгаагүй. Ерөнхий боловсролын сургуульд хэд хоног л явж үзсэн. Бичиг үсэг мэдэхгүй. Уншиж, бичиж чаддаггүй. Ердийн сургуульд хамруулахыг хүссэн боловч багш нар нь хүлээж авах сонирхолгүй байсан. Харин өөрөө бол үе тэнгийнхэнтэйгээ сургуульд явах их сонирхолтой байдаг. Харамсалтай нь багш, удирдлага нь ойлгоогүйгээс хүү минь сургууль завсардсан. Нийгэм ийм хүүхдүүдийг ойлгодог, нийгэмшихэд нь, эргэн тойрондоо дасан зохицоход нь ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхдаггүй байвал сайн байна.”



Кейс 3.

12 настай А-ийн ээж: “Хүү маань сонсгол, хэл ярианы дунд зэргийн бэрхшээлтэй. Өөртөө үйлчлэх чадвар дунд зэрэг. Цэцэрлэгт гурван жил, сургуульд гурван жил явсан. Сургуулийн гадаад болон дотоод аюулгүй байдал маш муу. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сурах цэцэрлэг, сургууль алга. Тэднийг сурах чадваргүй гэдэг ч шаардлага хангасан дохионы хэлний багш байхгүй. Сурах бичиг хангалтгүй. Хүүхдийг үнэлэх үнэлгээ муу. Үе тэнгийнхний харилцаа муу.”



Кейс 4.

12 настай Г-ийн ээж: “Охин маань хөнгөн хэлбэрийн саажилттай, баруун хөл, зүүн гар илүү саажилттай, оюун ухаан хэвийн, хэл ярианы бэрхшээлтэй, өөрөө юм хэлж, өгүүлбэрээр илэрхийлж чадахгүй. Юм хэлэхэд ойлгодог. Сургуульд байнга явж чаддаггүй. Долоон хоногт нэг, хоёр удаа явдаг. Багшийн заасныг үсэг үсгээр л хуулан бичнэ. Ойлгож уншихгүй. Заасан юм ойлгохгүй болохоор тоо бодож чадахгүй. Гараараа юм барихдаа муу. Бал, үзэг барьж чаддаггүй. Багш гучин хүүхдэд нэг зэрэг хичээл орохоор



охин маань гүйцэж ойлгож ухаарч амждаггүй. Тусгайлан, бүр болбол ганцааранд нь заавал илүү дээр санагддаг. Эрүүл хүүхдүүдтэй харьцуулаад дүн тавиад байдаг нь буруу байх. Би хүүхдийн сурах эрх хангагдаагүй байна гэж боддог. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалт явуулж чадах багштай болж, эдгээр хүүхдэд зориулсан тусгай сургууль байх шаардлагатай байна."



Кейс 5.

14 настай Г-ийн ээж: "Хүү маань оюун ухааны хомсдолтой, уналт таталт, саажилттай, хэл ярианы бэрхшээл, тулах эрхтний бэрхшээлтэй. Мөлхөж явдаг. Унаж татдаг болохоор цэцэрлэг авахаас дургүйцдэг байсан. Хүүхдээ цэцэрлэгт ч юм уу өгвөл би өөрөө ажил хиймээр л байна. Өөрийн машинаар такси хийж гэртээ орлого олмоор байдаг. Хүүхдэдээ юм зааж сургамаар л байна. Яаж сургах учраа би олохгүй байна. Олон хүүхэдтэй хамтдаа байхдаа их дуртай, хүүхэд нийгэмшдэг, их өөр болдог юм. Албан бус сургалтын төвүүдэд хүртэл хандаж үзсэн, болоогүй. Нөхөн сэргээх төв л манай хүүхдийн очих ганц газар болоод байна."



Кейс 6.

11 настай Х-ийн ээж: "Охин маань саажилтын улмаас тулах, хөдлөх эрхтний бэрхшээлтэй, ярихгүй. Гараар юм сайн барихгүй. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй. Толгойгоо даана. Бие дааж суухгүй. Байнгын асаргаанд байдаг. Ярьсан юмыг бага зэрэг ойлгоно. Сонсгол сайн. Байнгын асаргаанд байдаг хүүхдийг цэцэрлэг, сургууль хүлээн авдаггүй. Хэдий хүнд хэлбэрийн бэрхшээлтэй ч би хүүхдээ өөрт нь тохирсон юмыг сурах чадвартай гэж боддог. Өнгө, дүрс ялгах зэрэгт сургаж болно. Мэргэжлийн багшийн туслалцаа надад хэрэгтэй байна. Зурган харилцаанд хүүхэд минь нүдээрээ харилцаад сурчихвал сайн байна. Ялгаварлан гадуурхалт их байдаг: гудамжинд хүүхдүүд элий балай, долир гэх мэтээр хэлж байдаг. Миний хүүхдийн сурах боломж ер бүрдээгүй. Миний охин шиг хүүхдүүд тусгай сургуульд сурдаг баймаар санагддаг. Тусгай сургуулийг би: Хүүхэдтэй харилцах



чадвартай, сэтгэлтэй, ажилдаа дуртай багштай; Сурах орчин нь хүнд хэлбэрийн бэрхшээлтэй гэлтгүй бүх хүүхдэд тохирсон; Тэргэнцэр явдаг замтай; Нойл нь хөгжлийн бүх бэрхшээлтэй хүүхдүүдэд тохирсон; Хүүхдүүдийг гэрээс тээвэрлэх зориулалтын унаатай байвал сайхан гэж мөрөөддөг.”⁴

№4. Дадлага ажил 3. Оролцогчдыг 2 баг болгон хуваана:

1-р баг:

“Тэгш хамруулан сургах нь хүүхдийг боловсролд тохируулах бус, харин боловсролыг хүүхдийн онцлог хэрэгцээнд тохируулж шинэчлэн өөрчлөхийг шаарддаг.”⁵

2-р баг:

“Сургуулиуд бүх хүүхдийг сургах ёстой. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн болон сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцөл байдлаас үл хамааруулан сургана.”⁶

Өөрийн багт оногдсон тодорхойлолтын утгыг ярилцаж өнөөдрийн байдал, нөхцөлийг маргаашийн хийгдэх шинэчлэлтэй жишиж багшийн хувьд хийж болох нөлөөллийн ажлын төлөвлөгөөг гаргана.

Хийгдэх ажил	Хамтран ажиллах байгууллага, хувь хүн					
	Орон нутгийн засаг, захиргаа	Төрийн болон ТББ	Иргэд	Сургууль	Эмнэлэг	Эцэг эх, гэр бүлийн гишүүд

№5. Дадлага ажлын үеэр гарсан оролцогчдын саналыг нэгтгэн дүгнэснээр шинэ мэдээлэл хүргэнэ: тусгай хэрэгцээт хүүхдүүдэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах холимог бүлгийн багшийн үүрэг, ажлын онцлог, стратеги г.м.

⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга ба дүн шинжилгээ. Судалгаа, 2011 он

⁵ Тэгш хамруулах боловсрол. Д.Одгэрэл нар. 2016

⁶ ЮНЕСКО-ийн гишүүн орнуудын Тусгай боловсролын хурлаас батлагдсан Саламанкагийн тунхаглал. 3-р бүлэг



№6. Сургагч багшийн чиглүүлсэн асуултын дагуу боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн талаар ярилцлага өрнүүлнэ. Оролцогчдын хариултад гарах алдаа, зөрүү ойлголтыг засч залруулна. Асуудлыг нэгтгэн дүгнэхдээ дүйцсэн хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүргэнэ: дүйцсэн хөтөлбөрийн онцлог, давуу тал, түүнд тавигдах шаардлага, дүйцсэн хөтөлбөрийн сургалтын агуулга, сургалтын модуль, түүний онцлог г.м.

№7. Дадлага ажил 4. Оролцогчдыг 2 баг болгон хуваана. Өгөгдсөн бага боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг судлан

1-р баг: аргачлалын дагуу суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсруулна.

2-р баг: аргачлалын дагуу бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсруулна

Багууд боловсруулсан төлөвлөгөөг тус бүр 3 минутанд танилцуулна. Хананд байршуулсан үлгэрчилсэн төлөвлөгөөг үндэслэн багууд интеграцчилж болох хичээлүүдийн талаар санал солилцоно.

№8. Дадлага ажил 5. Оролцогчдыг 3 багт хуваана. Хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн онцлог бүхий хүүхдийг гэрээр сургахад сургалтад оролцох, хамтран ажиллах:

1. байгууллагууд
2. баг, хамт олон
3. хувь хүмүүсийн төлөөллийг тодорхойлно.

Оролцогч талуудын үүрэг, ажлын чиглэлийг тодорхойлсноор хамтран ажиллах боломжтой байгууллага, хамт олон, хувь хүмүүс тодорхой болно.



МЭДЭЭЛЭЛ 1. Холимог бүлгийн багшийн үүрэг

Холимог бүлгийн сургалт нь түүнд оролцогч бүрийн хамтын хөдөлмөр бөгөөд ялангуяа багш бэлтгэх асуудал дээр, тусдаа сургалтын хөтөлбөр, орон нутаг болон төрөөс тодорхой хэмжээний дэмжлэг шаардагдсан сургалтын хэлбэр юм.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн сургалтын гол нөөц бол арга зүй сайтай, хичээлийн бэлтгэл сайн хангадаг, тухайн орон нутгийн талаар мэдлэгтэй, мэргэжлийн багш байна.

Холимог бүлгээр сургалт зохион байгуулж буй багшид мэргэжлийн ур чадвар, мэдлэгээс гадна заах арга, технологи, суралцагчидтай ажиллах арга барил их үүрэгтэй.

Холимог бүлгийн багшийн үүрэг:

- Суралцагчдад мэдлэг түгээх
- Суралцагчдын ур чадварыг хөгжүүлэх
- Тэдний үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх
- Мэдлэг, чадварын түвшнээр өөр хоорондоо ялгаатай байдлыг үл харгалзан ангийн бүх суралцагчдад хичээлийг үр дүнтэй хүргэх стратегийг ашиглах

Иймд холимог бүлгийн багшид жирийн сургуулийн багшаас илүү өндөр хариуцлага, үүрэг ногдох бөгөөд эдгээрийг дараах байдлаар тодорхойлж болно:

- Идэвхжүүлэгч
- Олон нийтийг холбогч
- Нийгмийн ажилтан / зөвлөх
- Төлөвлөгч
- Үнэлэгч
- Сургалтын материал боловсруулагч, зохиогч
- Туслах багш нарыг бэлтгэгч
- Төрийн бодлогыг хүргэгч
- Үйл явцыг судлаач
- Чанар шалгагч
- Эцэг эхийг орлогч
- Санхүүч /менежер
- Соёл, шашин, улс төрийн ажилтан

Эдгээр үүрэг тус бүрийг дэлгэрэнгүй авч үзвэл:

Багш-идэвхжүүлэгч суралцагч бүрийн хувийн онцлогийг ойлгон тэдэнд суралцах идэвх, сонирхлыг төрүүлэх, сургалтын материалтай ажиллаж,



сурахад удирдан чиглүүлэх чадвартай байж, зөвхөн мэдлэг түгээгч төдийгүй сургалтыг идэвхжүүлэгч байх ёстой.

Багш-олон нийтийг холбогч бол сургууль болон нутгийн иргэдийг холбогч болдог. Учир нь холимог бүлгийн ангийн өнгө үзэмж, материалын нөөц, сургалтын чанарыг дээшлүүлж, насан туршийн боловсролын төвийн оршин тогтнох нэг үндэс нь нутгийн иргэдийн тусламж байдаг тул хамтран ажиллах явдал чухал юм.

Багш-нийгмийн ажилтан буюу зөвлөх. Холимог бүлгийн багш нь өргөн мэдлэгтэй байж зөвхөн суралцагчдаа төдийгүй тэдний гэр бүлийн гишүүдэд, нутгийн иргэдэд нийгмийн талын аливаа асуудал дээр дотны итгэлтэй зөвлөгч болдог.

Багш-төлөвлөгч нь хичээлийн болон ажлын төлөвлөлтийг бүлэг бүрийнхээ тоогоор оновчтой хийснээр суралцагчдад юу илүү бүтээлтэй байх, ямар зүйлийг хэрхэн өгвөл суралцагчдад ойлгоход хялбар байх талыг бодолцож хичээлийн зорилгод хүрэхийн тулд дараах асуултад хариулт өгч чадахаар төлөвлөгөөг хийсэн байх ёстой:

1. Би хэнд заах вэ?
2. Юу заах вэ?
3. Хэрхэн яаж заах вэ?
4. Хэзээ заах вэ?
5. Яагаад, ямар учраас зааж байгаа вэ?

Төлөвлөлтийн гүйцэтгэлийн стратегид хичээлийн төлөвлөгөө, дасгал ажлуудыг сонгох, хичээлийн хуваарь зэрэг багтана. Энэ бүх үйл ажиллагаа үндсэн хичээлээс өмнө хийгдсэн байна.

Багш-үнэлэгч боловсролын чанарт үнэлгээ хийх үүднээс суралцагчдын сургалтын амжилт /явцад/ хяналт тавих явдал багшийн үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Үнэлгээг суралцагчдыг анх сургуульд ирэхэд, хичээлийн жилийн дундуур мөн төгсгөлд хийдэг.

Багш-сургалтын материал боловсруулагч, зохиогч. Хэдийгээр өмнө боловсруулсан хичээлийн стандарт, киррикулим, хичээлийн хөтөлбөр байлаа ч холимог бүлгийн багш өөрийн зааж буй анги, суралцагчдын онцлогт таарсан нэмэлт сургалтын материалыг бэлтгэх шаардлагатай. Эдгээр нь орон нутгийн агуулгын хүрээнд холимог бүлгийн сургалтын тодорхой өвөрмөц хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэгдсэн байна.

Багш-туслах багш бэлтгэгч. Туслах багшийн үүргийг эцэг эх, нутгийн иргэд, ах дүүс, дээд ангийн суралцагчид гүйцэтгэх боломжтой. Энэ нь хичээл заахаас өөр учир багш, түүний туслагчийн хооронд зөв харилцаа



тогтооход багшийн зүгээс бүтээлч үйл ажиллагааг шаарддаг. Тухайлбал, эцэг эх хүүхдийн гэрийн даалгавар хийхэд туслах, зөвлөх, үзсэн хичээлийг шалгах, нутгийн иргэдийг суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх, дүгнэх ажилд дайчлах, дээд түвшний суралцагчид доод түвшний хүүхдүүдийг чиглүүлэх, хөтлөх г.м.

Багш-төрийн бодлогыг хүргэгч. Иргэд зөвхөн хүүхдийнхээ боловсрол төдийгүй, тэдний эрүүл мэнд, нийгмийн халамж гэх бусад олон асуудлаар мэдээлэл, зөвлөгөө авч, санал бодлоо солилцдог. Иймд тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холбоотой асуудлаар төр, засгийн зүгээс баримталж буй бодлогыг холимог бүлгийн багшаар дамжуулж иргэдэд хүргэнэ.

Багш-үйл явцыг судлаач. Холимог бүлгийн сургалтын багш тодорхой зүйлсийн талаар илүү сайн ойлголттой, шаардлагатай мэдээллийг сайн судалж, өөрийн болгон бусдад хүргэх чадвартай байх ёстой. Тухайлбал, сургуульд хамрагдалтын хувийг өсгөж, завсардалтыг багасгахад ямар арга хэмжээ авах шаардлагатай, суралцагчдын сурлагын түвшин, чанарыг хэрхэн өсгөх г.м. Эдгээрийг судална гэдэг нь эрдэм шинжилгээний ажил хийнэ гэсэн үг биш, харин байнга эрэл, хайгуул хийж, асуултад хариулах хэрэгцээтэй мэдээллийг цуглуулах, хайх, шаардлагатай өөрчлөлтийг явцын дунд ажил хэрэг болгохыг хэлж байгаа болно. (судалгааны арга зүйн талаар мэдээлэл 2-оос дэлгэрэнгүй уншина уу).

Багш-чанар шалгагч. Бүх нийтийн боловсролын зорилго бол суралцагчдын боловсролын чанарыг дээшлүүлэх асуудал билээ. Тиймээс холимог бүлгийн багш зөвхөн боловсрол олгох нь хангалттай биш, харин явуулж буй сургалт, хичээл нь чанартай, өгөөжтэй байх ёстой. Багшийн гол үйл ажиллагааны нэг нь сургалтын чанар, үр дүнд хяналт тавих ажил юм. Чанарын хяналтад сургалтын үйл явц, ашиглаж байгаа сургалтын материал, үнэлгээ хийх журам зэрэг багтана.

Багш-эцэг эхийн орлогч. Холимог бүлгийн сургалтын үеэр суралцагчдыг анги болгон хуваадаггүй учир танхимын уур амьсгал гэр орны уур амьсгалтай илүү адил байдаг. Энэ нөхцөлд багш шавийн албан харилцаанаас илүүтэйгээр эцэг эх, суралцагчдын хоорондын харилцаанд түшиглэсэн нөхцөл бүрддэг. Багш суралцагчдад тохиолдож буй асуудлыг шийдвэрлэхэд туслах, чиглүүлэх дотны туслагч байдаг.

Багш-санхүүч/менежер. Холимог бүлгийн багш эцэг эхчүүдтэй хамтран анги танхимын засвар, тохижилт, урлаг спортын арга хэмжээ зэрэг бусад үйл ажиллагаанд хандив, мөнгө цуглуулах, үр дүнтэй зарцуулахыг



тооцож, мөнгөн санг хянаж ажилладаг.

Багш-соёл, шашин, улс төрийн ажилтан. Холимог бүлгийн багш баяр наадам, үзэсгэлэн худалдаа, олон нийтийн ажлыг зохион байгуулах, төрийн бодлогыг тайлбарлах, хууль дүрмийг мөрдөх, байгаль орчныг хамгаалах зэрэг олон ажилд манлайлах үүргийг гүйцэтгэдэг.

Холимог бүлгийн багшийн үүрэг нь тусгайлан авч үзэх зүйлийн нэг бөгөөд багш нар ажил, үүргээ зохих түвшинд явуулахын тулд мэргэшүүлэх сургалтад хамрагдах зайлшгүй шаардлагатай юм.

Харин тусгай хэрэгцээт, ялангуяа хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй хүүхдүүдтэй холимог бүлэгт мэргэжлийн багш нараас гадна дараах хүмүүсийг бэлтгэн нэмэлт хүчээр ажиллуулах хэрэгтэй:

- суралцагчдын даалгаврыг хянах **туслах багш**
- сургалтын явцад суралцагчид бие биедээ туслах **үе тэнгийн сургагч багш**
- орон нутгийн иргэд, суралцагчдын эцэг эхийн төлөөлөл **сайн дурын багш**

Анги танхимд болон цугларалтаар холимог бүлэгт хичээллэж чадахгүй хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд:

- гэрээр нь туслах **явуулын багш**
- эмч, хажуу айлын хүүхэд, залуус, насанд хүрэгч, сургууль болон нутгийн иргэдийн сайн дурын холбооны гишүүд - **гэрийн багш**
- сургуулийн сурагч - **үе тэнгийн сургагч багш**

Холимог бүлгийн сургалт гэдэг нь ангийн зохион байгуулалт, суралцагчдыг удирдах, бүлэг, суралцагч бүрт тус тусын сургалтын хөтөлбөрийг амжилттай дамжуулан хүргэхтэй холбоотой бүхнийг хэлнэ. Өөрт байгаа бүхий л боломж: орчин, нөхцөл, гар доорх материал зэргийг ашиглан бүлэг, суралцагч тус бүрийн сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлээ төлөвлөж, зохион байгуулахад **холимог бүлгийн багшийн үүрэг** оршино.

МЭДЭЭЛЭЛ 2. Судалгаа хийх арга зүй

Аливаа асуудал, үйл явцыг ажиглах, унших, дүгнэлт хийх, бусдын яриа, саналыг сонсох, мэтгэлцэх, өөрийн бодлыг илэрхийлэх, цаашдын ажлыг төлөвлөх, зохион байгуулах шаардлага, хэрэгцээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэл, дэвшүүлсэн асуудал зэрэг нь судалгаа хийх эхлэл болдог. Холимог бүлгийн багш



нь судлаачийн хувьд албан болон албан бусаар өдөр тутам судалгаа хийж байдаг ба сум, дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдийн үйл ажиллагаа ч судалгаанд үндэслэн зохион байгуулагддаг билээ. Тухайлбал, иргэдийн боловсролын түвшин тогтоох, амьжиргааны түвшин тогтоох, боловсролын хэрэгцээний судалгаа хийх, сургууль завсардсан болон огт хамрагдаж байгаагүй хүүхдүүдийг илрүүлэх, бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийг илрүүлэх г.м. Иймээс багшийн үйл ажиллагаа судалгааны ажилтай нягт холбоотой бөгөөд судалгааны арга зүйг сайтар эзэмшсэнээр ямар зорилгоор, хэнтэй хамтран, хэнийг, юуг, ямар хугацаанд, ямар аргачлалаар, яаж судлах, уг судалгааг хийснээр юуг тодруулж, ямар ажлыг, яаж зохион байгуулах зэрэг логик холбоотой асуудлуудыг зөв шийдвэрлэж чадах юм.

Тодорхой асуудалд хариулах эсвэл баримтад тулгуурлан түүнийг шийдвэрлэх зохион байгуулалттай, дэс дараатай, бүтээлч танин мэдэх үйл ажиллагааг судалгаа гэнэ.⁷ Өөрөөр хэлбэл, тухайн асуудлыг тодруулахаас эхлэн шийдвэрлэж дуусах хүртэлх явцыг бүхэлд нь судалгаа гэж ойлгоно. Иймээс судалгаа нь асууж лавлах, нотлох, дүгнэх, онол практикт (сургалт, үйл ажиллагаанд) нэвтрүүлэх явцыг багтаадаг. Явцын үр дүн нь тодорхой дэс дараатай, логик холбоотой, бодитой байх ёстой. Харин явцын үр дүн нь шинэ баримт, санаа, ойлголт, таамаглал, үзэл баримжаа, онол, хууль, загвар, шинж чанар, энгийн ба бүтээлч чадварыг багтаах бөгөөд үүнийг бүхэлд нь мэдлэг гэнэ. Харин багш мэдлэгт тулгуурлан асуудлыг шийдвэрлэж чадна.

Судалгааг зорилгоор нь:

- нээх,
- тодорхойлох,
- тайлбарлах гэж ангилдаг.

Нээх судалгаа нь асуудлыг шинээр дэвшүүлж, шинэ үр дүнд хүрэх үйл ажиллагаа байдаг бол тодорхойлох судалгаа нь судалгааны асуудлын хариултыг олж, юмс, үзэгдлийн өөрчлөлтийн мөн чанарыг бодитой, үнэн зөв тодруулах, харин судалгааны асуудлын шалтгаан, үр дагаврыг олж тогтоох үйл ажиллагааг тайлбарлах судалгаа гэнэ.

Судалгааг гарах үр дүнгээр нь тоон болон чанарын гэж хуваана. Тоон үр дүн бүхий судалгааг тооны судалгаа, харин үзэл баримжааны дүгнэлтэд хүрч буй судалгааг чанарын судалгаа гэж тодорхойлдог.

Судалгааг дараах аргуудыг ашиглан хийж болно:

⁷ Судалгааны арга зүй. Б.Жадамба, Ц.Чимэдлхам. УБ. 2001



1-р арга. Ажиглалт хийх

Ажиглалт хийх аргыг судалгааны эхний шат гэж үзэж болно. Ажиглалтын улмаас судлаачдад эргэлзээ, гайхал, шинэ сэдэл, бодол, мэдрэмж, сонирхол, хэрэгцээ төрж судалгааг эхэлдэг. Ажиглалт нь нэг талаас судлах шаардлагатай сэдэв, асуулга, асуултын анхан шатны мэдээллийг өгдөг бол, нөгөө талаас баримт цуглуулах нэг арга болдог. Иймээс ажиглалт нь судлагдахууны бодит нөхцөл дэх илрэлийг мэдрэхүйн эрхтнээр дамжуулан хүлээн авч, тэмдэглэл хөтлөн, сонирхсон мэдээллээ цуглуулж, дүн шинжилгээ, дүгнэлт хийдэг үйл ажиллагаа юм.⁸

Ажиглалтын явц нь:

1. Судлах зүйлийг зөв сонгох, өөрөөр хэлбэл, судлаач чухам юу ажиглах вэ гэдгээ тодорхойлно.
2. Зорилго, зорилтыг оновчтой тодорхойлно.
3. Хаана, ямар хугацаанд хийхийг төлөвлөнө.
4. Ажиглаж буй үзэгдэл, зүйлийг байгаа байдлаар нь тэмдэглэнэ / шаардлагатай бол бичлэг хийнэ/.
5. Ажиглалт дууссаны дараа баримт материалд боловсруулалт хийж, дүгнэлт гаргана.

Ажиглах зүйл нь:

- Ажиглаж, хэмжиж болохуйц ил харагддаг;
- Судлаач тайлбарлаж болохуйц тодорхой;
- Нөхцөл байдлаас үл хамаардаг;
- Судлах зүйлд шууд хамааралтай;
- Бүх боломжийг тооцож болохуйц;
- Тухайн зүйлийг нарийн тодорхойлохуйц;
- Бичиж тэмдэглэхэд хялбар байх шаардлагыг хангасан байна.

Ажиглалтыг зохион явуулах арга барилаар хоёр ангилж болно:

- Судлаж буй асуудлаа өөрөө, системтэй, биечлэн ажиглаж тэмдэглэл хөтлөх
- Судалгаанд хамрагдагсдын дотор орж өдөр тутмын үйл

⁸ Судалгааны арга зүй. Б.Жадамба, Ц.Чимэдлхам. УБ. 2001



ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтран ажиллаж, судалгааны хугацааны турш ажиглалт хийн баримт мэдээлэл цуглуулах

Ажиглалтын давуу тал: үндэслэл сайтай баримтыг шууд цуглуулдаг, судлаач буюу багш нар хэрэглэх боломжтой, энгийн ба судлаач өөрөө судалгааны хэрэгсэл болдог, тухайн асуудлыг байгаа байдлаар нь тэмдэглэж авснаар их хэмжээний баримт цуглуулан кодлож шууд дүн шинжилгээ хийхэд бэлэн болдог. Харин сул тал нь: судлаж буй асуудлыг өөрчлөн сайжруулахгүй, хэвээр нь үлдээдэг, нөхцөл байдлын болон үнэний магадлал багатай, хугацаа их шаарддаг, бусад мэдээллийг төлөөлөх чадвар сул байдаг байна.

2-р арга. Баримт судлах

Энэ шатанд ажиглалтын дүнд олж авсан судалгааны асуултын талаарх өөрийн мэдлэгээ хянах, илүү их зүйл мэдэж авах зорилгоор мэдээллийн эрэл, хайлт хийдэг. Тухайлбал, Насан туршийн боловсролын төв болон багшид хэрэгтэй төрөл бүрийн тоо баримт, мэдээллийг улсын хэмжээнд болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын баримт бичиг, мэдээ, тайлангаас олж болно. Эдгээр нь орон нутгийн газар зүйн онцлог, хүн ам, бичиг үсгийн байдал, эрүүл мэнд, эдийн засгийн талаарх мэдээллийг өгөхөөс гадна нөхцөл байдлын судалгаа, орон нутгийн байршил, газрын зураг зэргийг ч багтаасан байдаг.

Хэрэгцээт мэдээллийг дараах эх сурвалжийг ашиглан цуглуулж болно. Тухайлбал:

- Иргэдийн болон албаны хүмүүсийн уулзалт яриа, түүний тэмдэглэлээс;
- Байгууллагуудын бүртгэл, журналаас;
- Төрийн болон төрийн бус, сайн дурын байгууллагын тайлан бүртгэл, судалгаанаас;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээс болон ном гарын авлагаас;
- Интернет эх сурвалжаас;
- Насан туршийн Боловсрол (НТБ)-ын салбарын болон өөрийн төвийн жил бүрийн тайлан, судалгаанаас мэдээлэл авч болно. Эдгээр мэдээлэл нь туслах чанарын мэдээлэл гэдгийг мартаж болохгүй, харин таны өөрөө судалгаа хийж цуглуулах



мэдээлэл хамгийн чухал үүрэгтэйг санах хэрэгтэй.

Хийх гэж буй судалгаанаас хамаарч багш мэдээллийг цуглуулах хувь хүн, хамт олон, байгууллагыг тогтооно. Жишээлбэл, сургуулийн гадна буй сургууль завсардсан хүүхдүүдийг илрүүлэх судалгаа хийх бол тухайн зорилтот бүлэгтэй хамааралтай, туслах мэдээллийг олж болох дараах байгууллагуудтай хамтран ажиллаж болно:

- Насан туршийн боловсролын төвийн багш, ажилтан,
- Аймаг/дүүргийн боловсрол хариуцсан ажилтан,
- Статистик мэдээллийн ажилтан,
- Гэр бүлийн хөгжил, Залуучуудын Хөгжлийн Газар (ГБХЗХГ)-ын мэргэжилтэн,
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газар (ХХҮГ)-ын мэргэжилтэн,
- ЕБС-ийн сургалтын менежер/нийгмийн ажилтан,
- Хороо, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч,
- Өрхийн эмч г.м.

3-р арга. Ярилцлага хийх

Судалгааг ярилцлага байдлаар хийж болно. Үүний тулд:

1. Судалгааг эхлэхийн өмнө багийн гишүүд ажлаа зөв зохион байгуулахын тулд ямар мэдээллийг, хэрхэн, яаж цуглуулах талаар удирдамж боловсруулах нь чухал. Энэ нь багийн гишүүд ярилцлагыг нэг түвшинд авч, нэгтгэхэд чухал ач холбогдолтой байдгийг санах хэрэгтэй.
2. Удирдамж нь ярилцлагын үйл явцыг нарийвчлан, тодорхой болгоход тусална. Жишээлбэл, ярилцлагыг өөрийгөө болон баг хамт олноо танилцуулахаас эхлэх ба судалгааны зорилгыг тухайн хүнд ойлгомжтой үг, өгүүлбэр ашиглан тайлбарлана. "Та ...-нд хариулна уу?" гэхийн оронд "Танаас би ...-г асууж болох уу?" гэх мэтээр хэллэгтээ анхаарах хэрэгтэй.
3. Нээлттэй бус, шууд асуултууд нь баримт мэдээ, тоон үзүүлэлтийг цуглуулахад, харин тухайн хүний санаа бодлыг ойлгож мэдэхэд нээлттэй, шууд бус асуулт тавих нь зохимжтой, үр дүнтэй байдгийг анхаарах хэрэгтэй. Ярилцлагын агуулгыг судалгааны зорилгод



нийцэхүйц боловсруулахыг мартаж болохгүй.

4. Ярилцлагыг зорилтот бүлгийн хүнтэй урьдчилан товлож гэрт нь очих, эсвэл олон нийтийн газруудаар явж хүмүүстэй ярилцан, санаа бодлыг нь сонсох, мэдэх замаар хийж болно.
5. Ямар судалгааг, ямар онцлогтой газар хийж байгаагаас хамаарч орон нутгийн нөлөө бүхий хүмүүсийг татан оролцуулах нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, хорооны болон хэсгийн ахлагч, багийн дарга, эсвэл ижил хэлээр ярьдаг танил хүмүүс, эмч, сургуулийн ажилтан г.м.
6. Тоо баримтыг асуулгаар, санаа бодлыг ярилцлагаар авах нь тохиромжтой байдаг тул судалгааг тус аргуудыг хослуулан авах нь үр дүнтэй байдаг.

4-р арга. Асуулга боловсруулах

Асуулга нь судалгааны баримт цуглуулдаг түгээмэл аргын хувьд аливаа үзэгдэл, юмс, үйл явцын тоо, чанар, шалтгаан, үр дагаврын учир холбогдлыг тогтооход чиглэгдсэн, тодорхой агуулга, бүтэц, зохион байгуулалттай бичгийн хэлбэрээр урьдчилан бэлтгэсэн асуулт, хариултын цогц юм. Асуудлын хүрээнд сонирхох асуултуудыг тэдгээрийн хариултын бүх боломжтой хамт хүн бүрт өгч, ижил агуулгатай мэдээлэл цуглуулдаг судалгааны арга.

Асуулгын арга нь асуултыг төлөвлөх, бэлтгэх, шалгах, авах, хариултыг боловсруулах үе шатыг агуулдаг. Үе шат нь хэн, хаана, хэзээ, юуг, ямар хугацаанд, ямар бэрхшээлийг, ямар төсөвт багтаан явуулахыг тодорхойлдог тул судалгаа авах асуулгыг боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй:

1. Асуултууд энгийн, ойлгомжтой, товч бөгөөд тодорхой мэдээллийг авахад тохирсон байх. Хэрэв олон янзын хариулт шаардах асуулт байвал хэд хэдэн жижиг асуулт болгон хуваах нь зүйтэй.
2. Асуултууд нь “тийм, үгүй, хэдэн...” гэх мэт шууд, эсвэл “та энэ талаар юу гэж бодож байна вэ?” гэх мэт нээлттэй хариултуудыг санал болгосон байж болно. Тоо баримтын талаар мэдээлэл цуглуулж байгаа нөхцөлд шууд асуултуудыг хэрэглэж, тухайн хүний санаа бодлыг мэдэх шаардлагатай бол нээлттэй хариулт бүхий асуулт тавих нь хариулахад дөхөм байдаг.



3. Зарим үед жишээ хариулт оруулж өгөх нь хариултыг хялбар болгодог сайн талтай.
4. Хэн, ямар хэлбэрээр авахаас шалтгаалан асуулган дээр судалгааны зорилгыг бичих юм уу, эсвэл асуулга авч буй хүн амаар хэлэх ёстой.
5. Судалгаанд хамрагдах зорилтот бүлгийг асуулгын хуудсан дээр бичиж өгвөл түүнд шаардлагагүй хүмүүс оролцохгүй байх боломжийг хангаж өгдөг.
6. Зарим асуулт нь гэр бүл, амьжиргааны түвшин, тухайн хүний эрүүл мэндийн байдал зэрэг хувийн мэдээлэл хөндөж болох учир асуулгыг ямар зорилгоор, юунд ашиглах, ямар асуудлыг шийдвэрлэх талаар судалгааны эхэнд сайтар тайлбарлах шаардлагатай.
7. Бусад байгууллагаас ижил төстэй асуулга авсан бол түүнтэй давхардуулахгүйг хичээх хэрэгтэй.
8. Судалгааны хуудасны төгсгөлд санал асуулгад оролцсонд баярласнаа илэрхийлэхийг мартаж болохгүй (Хавсралт 3-ыг үзнэ үү).

МЭДЭЭЛЭЛ 3. Холимог бүлэгт хэрхэн үр дүнтэй багшлах вэ?

Тусгай хэрэгцээт холимог бүлэгт сургалт явуулах багш анги зохион байгуулалтыг хийхээс өмнө **одоогийн байдлаа үнэлж, цаашдын төлөвөө тогтоохын** тулд:

- Дараах асуултуудыг өөртөө тавьж шийдвэрлэнэ :
 - Танай сургууль хаана байдаг вэ? Суралцагчид хэр холоос хичээлдээ явах вэ?
 - Танай ангид суралцах хүүхдүүдийн нас болон эрүүл мэндийн байдал, мэдлэгийн түвшин ямар вэ?
 - Тусгай хэрэгцээт суралцагч тус бүрийн онцлог юу вэ? Тэдний ямар онцлогийг нь харгалзаж, хэдэн бүлэгт хувааж болох вэ? Яагаад ингэж хуваах болов?
 - Бие махбодын эсвэл оюуны хөгжлийн бэрхшээлтэй холбоотойгоор тусгай боловсрол шаардлагатай суралцагчдын хэрэгцээг хэрхэн тодорхойлох вэ? Та юу хийж чадах вэ?
 - Суралцагчдын хэд нь цэцэрлэгт хамрагдаж байсан бэ? Хамрагдаагүй хүүхдүүдэд Та юугаар, хэрхэн тусалж чадах вэ?
 - Суралцагчид гэртээ ямар хэлээр ярьдаг вэ? Тэд үндэсний




- хэлээр хэр сайн ойлгож ярьдаг вэ? Таны хичээлдээ хэрэглэдэг хэлээр сурч мэдэхийг хүссэн бүхнээ сурч мэдэж чадаж байгаа эсэхийг мэдэхийн тулд та юу хийх вэ?
- Таны суралцагчдын ар гэрийн байдал ямар вэ?
 - Тэдний эдийн засгийн байдал хэр вэ?
 - Суралцагчдын эцэг эх холимог бүлгийн сургалтыг ойлгож, дэмждэг үү? Хэрвээ үгүй бол ийм сургалт зайлшгүй шаардлагатайг хэрхэн ойлгуулах вэ?
 - Танай сургуулийн ахлах багш/хичээлийн эрхлэгч болон бусад багш нар холимог бүлгийн сургалтыг хэр ойлгодог вэ? Сургалтад ашигладаг уу?
 - Хэрвээ тэдний ойлголт хязгаарлагдмал бол Та ажилдаа дэмжлэг авахын тулд ямар ажил зохион байгуулах вэ?
- Ангийн суралцагчдын талаар ойлголт сайтай болсон бол тусгай хэрэгцээт хүүхдүүд холимог бүлгээр хичээллэх анги танхимын зохион байгуулалтад тодорхой цаг гаргах шаардлагатай. Анги танхимынхаа одоогийн байдал болон хойшид ямар байдалтай харахыг хүсч байгаа төсөөлөлдөө үнэлэлт өгнө:
 - Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй анги танхимын зохион байгуулалтыг тэдний нас, биеийн эрүүл мэндийн онцлог зэрэгт хэрхэн тохируулж хийх, хэрхэн зөв ашиглах вэ?
 - Анги танхимын болон сургуулийн орчинг сайжруулах ямар нөөц бололцоо Танд байна вэ? Та юу хийж чадах вэ?
 - Суралцагчдын ихэнх нь цэцэрлэгт хамрагдаж байгаагүй хүүхдүүд байх тул бага боловсрол эзэмших таатай, эрүүл, аюулгүй, хүүхдэд ээлтэй орчин хэрхэн бүрдүүлэх вэ?
 - Багш өөрийн төсөөллийг оюундаа бүтээсэн бол одоо хийх зүйлээ тодорхой төлөвлөн хэрэгжүүлж эхэлнэ:
 - Холимог бүтцийн ангийг үр дүнтэй төлөвлөх ажлын чухал хэсэг бол суралцагчдын онцлогийг харгалзсан хөдөлгөөнд чөлөөтэй, сургалтын үйл ажиллагаа, явцад тохиромжтой байхаар зай талбайг зөв хуваарилах асуудал юм. Багш самбарын өмнө суралцагчдын өөдөөс харж зогсдог уламжлалт хэв маягт хэд хэдэн үйл явдал нэгэн зэрэг өрнөдөг холимог бүлгээр ажиллаж буй ангид тохиромжгүй тул суралцагчдын ширээг хүссэнээрээ байрлуулж хичээлд шаардлагатай орон зайг “уян хатан” байдлаар бүрдүүлэх нь чухал.



- Сургалт эхлэхээс өмнө ангийн план зургийг гаргаснаар суудлын төлөвлөлт, тавилга, сургалтын материалуудын байршлыг тогтооно.
- Суралцагчдын тоо болон бүлгээс хамааран өгөгдсөн зай талбайд явуулах үйл ажиллагааны боломжуудыг урьдчилан тооцно. Жишээ нь, багаар ажиллахаар төлөвлөж байгаа бол бүлгийн хэлэлцүүлэг зэрэгт тохирсон талбар үүсгэх, харин "ганцаарчилсан" болон бие даасан сургалтад бага орон зай үлдээх г.м.

Бүлгээр ажиллах үеийн суудлын зохион байгуулалтын жишээ:



Багшийн гол зорилго бол сургалтын хөтөлбөрийн дагуу тусгай хэрэгцээт суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын олон төрлийн стратеги боловсруулах асуудал юм. Сургалтын үед багш хичээлийг өөрөө заах, суралцагчдыг бүлэг болгон хуваарилах, тэдэнд бие даан суралцах аргуудыг түлхүү хэрэглэн сургалтад татан оролцуулах, сургалтын явцад суралцагчид бие биедээ туслах зэрэг үйл ажиллагааг нарийн төлөвлөх ёстой.

Суралцагч бүр өөр өөрийн хувийн зан байдлын онцлог шинж чанартай байдаг бөгөөд тэдний сурах хэрэгцээ, шаардлага, ур чадвар болон нөөц боломж ч өөр гэдгийг мартаж болохгүй. Энэ нь суралцагч тус бүрийн нас, эрүүл мэндийн байдал, төлөвшил, дур сонирхол, оюуны чадамж, нөөц боломжоос хамаарсан хэрэгцээг хангах боломжийг олгох



сургалтын стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн үг юм. Суралцагч нэг бүртэй танилцахад цаг хугацааа шаардагдах боловч багш Та ажлаа холимог бүлгээр сурах анги танхим тэдэнд сурахад таатай байхаар зохион байгуулахаас эхэлж болох юм. Үүнд хэрэг болох санаануудыг дурдвал:

- **Суралцагчдыг стратегич хуваарилах.** Зарим үйл ажиллагаанд суралцагчдаа түвшин дээгүүр бүлгүүдэд хольж хуваарил. Ингэснээр өөр өөр түвшний суралцагчид бүлэг болон ажиллахдаа бие биеэ сурах үйл ажиллагаанд татан оролцуулна. Харин ур чадварын хичээлүүд дээр суралцагчдыг нас, эсвэл ангиар нь хуваан бүлэг болгож болно.
- **Сургалтад ашиглахад тохиромжтой, олон хэлбэрээр хэрэглэх материалууд боловсруулах.** Суралцагчдыг бүлгээр үр дүнтэй ажиллуулахын тулд, сургалтын материалуудыг суралцагчдын түвшин, чадварт нийцүүлж, хэрэгцээ, шаардлагад тохирохуйц олон төрөл, хэлбэрээр бэлтгэх хэрэгтэй. Тухайлбал, төрөл бүрийн ажлын хүснэгтүүд боловсруулах: багшийн заавраар ажиллах, бүлгээр ажиллахад ашиглах, ганцаарчлан судлах үед ашиглах болон суралцагчид бие биедээ зааж туслахад ашиглах г.м.
- **Бие даасан сургалтыг дэмжих.** Суралцагчдыг хамтран ажиллахад туслах, бие даан суралцах арга барилд сургах, бие даан ганцаарчлан сурах боломжийг олгох нь сургалтын болон хичээл тус бүрийн хөтөлбөрийн зорилгод хүрэхэд тустай.
- **Тусгай боловсрол шаардлагатай суралцагчдад анхаарал илүү хандуулах.** Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээтэй суралцагчдад бусадтай адил сурч, үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүл. Үүний тулд сургалтын тусгай хэрэглэгдэхүүн бэлтгэж, тэдний боловсролын хэрэгцээ, түвшнээс хамаарч ганцаарчлан ажиллах, илүү анхаарал тавих шаардлагатай болно.

Сурах идэвхийг ямар стратеги хэрэглэн өрнүүлэх вэ?

Суралцагчдын сурлагыг сайжруулах нь холимог бүлгийн багшийн гол сорилт. Идэвхтэй, шавь төвтэй сургалт суралцагчдыг мэдлэгээр нь төдийгүй нийгэм, сэтгэл зүйн хувьд хүссэн үр дүнд хүргэх хамгийн сайн арга. Иймээс багш Та заах арга барилд дараах цөөн өөрчлөлтийг хийснээр суралцагчдын сурах идэвхийг нэмэгдүүлнэ:



- Суралцагчийг анхаарлын төвд байлгаж, өөр өөрсдийнх нь сурах хурд, инерцээр өөрсдийн хэмжээнд ахиц дэвшил гаргахад туслах
- Суралцагч нэг бүрийн оролцоог сурах үйл явцад бататгахын тулд нэг ангид нас болон ангиар хольсон сургалтыг явуулах боломжийг бүрдүүлэх
- Бүлгээр ажиллахад суралцагч нэг бүрийн судлах, асуулт тавих, шинэ юм мэдэж авах хүсэл сонирхол, мөн биеэр үйлдэх, тоглох аргаар суралцахыг урамшуулах
- Бүлэгт хуваарилагдсан суралцагчдын бүрдэл болон тэдний төлөвшилд тохирсон үйл ажиллагааг сонгох замаар ангид хамтран суралцах соёлыг бий болгох
- Хамтран сурах, суралцагчид бие биедээ зааж туслах, багшаар удирдан чиглүүлэх, бие даан суралцах: унших, судлах зэрэг аргуудыг уян хатан байдлаар ашиглах
- Ангид бүлгээр зохион байгуулах үйл ажиллагаа, мэдээлэл солилцоо, номын сан болон уншлагын буланд бие даасан хэлбэрээр сургалт явагдах нөхцөлийг бүрдүүлэх
- Ангид зохиох үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөөг 7 хоног, сар, жилээр дэлгэрэнгүй төлөвлөх
- Суралцагчид сургууль дээрх болон сургалтын гадуурх үйл ажиллагаанд хэрхэн оролцож буйг ажиглах, хяналтын самбар хөтлөх
- Суралцагчдын сурсан, мэдсэн зүйлсийг чадварт суурилсан үнэлгээтэй холбох

МЭДЭЭЛЭЛ 4. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг гэрээр зохион байгуулах



Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөр

Манай улсын сургалтын практикт урьд нь хэрэглэж байгаагүй, боловсрол дүйцүүлэн эзэмшүүлэх арга зүйг 1999 оноос сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаагүй хүүхэд, залуучуудын нас, сэтгэхүйн онцлог, сонирхол, хэрэгцээнд нь тохируулан, албан боловсролын агуулгатай дүйцүүлэн багцалж боловсруулсан хөтөлбөрөөр боловсрол нөхөн эзэмшүүлдэг олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр “Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр боловсруулах стратеги”-ийг боловсруулан, түүний дагуу бага болон суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр, сурах бичгүүдийг бэлтгэн сургалтад хэрэглэж эхэлсэн билээ.



2005 онд “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр”-ийг стандартад нийцсэн агуулгатай, багц чадварыг эзэмшүүлж, цогц чадамж төлөвшүүлэхэд чиглэсэн модуль бүтэцтэйгээр боловсруулан боловсрол нөхөн олгох сургалтад ашиглаж байна. 2018 онд “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам” шинэчлэн боловсруулагдаж БСШУС-ын сайдын А/168 дугаар тушаалаар батлагдан мөрдөгдөж байна.

Дүйцсэн хөтөлбөр:



“Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр” нь ямар нэгэн шалтгаанаар сурах боломжоо алдсан хүүхэд, залууст бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад нийцсэн боловсролыг дүйцсэн сургалтын хэлбэрээр эзэмших үйл ажиллагааны үлгэрчилсэн агуулгыг тодорхойлсон удирдамж баримт бичиг юм. Иймд тухайн түвшний боловсролыг танхимын бус хэлбэрээр эзэмшихийг хүсэгч энэ хөтөлбөрөөр хичээллэж ерөнхий боловсролын сургуулийн зохих ангид шилжин суралцах боломж нээгдэж байгаагаас гадна бага, суурь, бүрэн дунд боловсролыг эзэмших, улмаар албан ба албан бус сургалтыг дүйцүүлсний үндсэн дээр боловсролын баримт бичиг авах боломж бүрдэж байгаа юм.

Дүйцсэн хөтөлбөрөөр сургах нь боловсрол нөхөн олгох гол хэлбэр бөгөөд дунд боловсролын тогтолцоогоор бүх нийтийг тэгш хамран сургахад учирч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулдагаараа онцлог юм. Дүйцсэн хөтөлбөрийн давуу тал нь:

- дунд сургуульд суралцах боломжгүй хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийг нас харгалзахгүйгээр хамруулах;
- сургалтын нэг шатнаас нөгөө шатанд шилжихэд чөлөөтэй, нээлттэй болгох;
- алдсан боломжоо богино хугацаанд нөхөн эзэмшиж ерөнхий



- боловсролын сургуулийн зохих ангид шилжин суралцах;
- суралцагчдын бие даасан үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- хүн бүрийн онцлогт тохирсон сургалтын аргыг хэрэглэх зэрэг болно.

Дүйцсэн хөтөлбөр нь суралцагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох, тэдний амьдрал, хөдөлмөр болон дараагийн шатны сургалтад бэлтгэн, бие дааж суралцах арга барил эзэмшүүлэх зорилготой. Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд:

- суралцагчдад мэдлэг, чадвар, дадал олгож, ажил хөдөлмөр эрхлэх, ахуйн амьдралаа зохион байгуулах арга барил эзэмшүүлэх;
- суралцагчдыг идэвхтэй, бие даасан, бүтээлч сурах арга барил эзэмшихэд нь арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- иргэний идэвхтэй байр суурь эзлэн, тасралтгүй суралцах хүсэл эрмэлзлэл төлөвшүүлэх;
- суралцах орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, материалаар хангах, сурах боломж бүрдүүлэх;
- хэрэгцээтэй мэдээллийг сонгон боловсруулж ашиглах, сурч мэдсэнээ хэрэглэж чаддаг болгох зэрэг болно.

Дүйцсэн хөтөлбөрт тавигдах шаардлага:

- албан боловсролын тухайн шатны агуулгатай дүйцсэн харьцаатай байх;
- суралцагчдын нас, бие, сэтгэхүй, эрүүл мэнд, ахуй амьдралын онцлог хэрэгцээ, шаардлагад тохирсон олон хувилбартай, уян хатан, хялбар дөхөм байх;
- хичээлүүдийн агуулга хоорондоо нягт уялдаатай, нэгдмэл, цогцолбор шинжтэй байх;
- сургалтын агуулгын 30-аас доошгүй хувь нь ажил, хөдөлмөрийн чадвар, дадал олгоход чиглэгдэх;
- цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлттэй байх;
- дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, нөхцөл, заах арга зүйгээр хангагдсан байх;
- суралцагчдад техник технологийн мэдлэг эзэмшүүлж, амьдрал хөдөлмөрт бэлтгэх сургалтын агуулгыг насны онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх;
- суралцагчид өөрсдийн сонирхол, хэрэгцээ, эрүүл мэндийн боломжийг харгалзан сурч, зохих мэдлэг, дадлага эзмэших боломжтой, уян хатан, нээлттэй байх шаардлагатай.



Дүйцсэн хөтөлбөр нь хичээл нэг бүрчилсэн хандлагатай биш, хичээлүүдийг интеграцчилж, тусгай багцуудад хуваасан, багц бүр нь зохих шатны боловсролын түвшинд гүнзгийрэн тэлэхээр боловсруулагдсан болно. Дүйцсэн хөтөлбөрийн арга зүйн материалын гол үзэл санаа нь хичээл хоорондын нягт холбоонд тулгуурлан, багцалж томсгон, хялбаршуулсан агуулгаар, хүн бүрийн онцлогт тохирсон аргаар сургалт явуулах, тухайн суралцагчийн өөрийнх нь чадавх бололцоог дээд зэргээр ашиглахад оршихыг санах хэрэгтэй.

Дүйцсэн хөтөлбөрийг холимог бүлгийн сургалтаас салангид ойлгох аргагүй. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын зорилго нь бага, суурь бүрэн дунд боловсролыг суралцагчдад дүйцсэн сургалтын хэлбэрээр эзэмшүүлэхэд оршино.



Дүйцсэн хөтөлбөрийн сургалт нь:

- суралцагч төвтэй
- суралцагч хэзээ, хаана, хэрхэн суралцахаа чөлөөтэй сонгох уян хатан боломжтой
- амьдрал төвтэй, өөрөөр хэлбэл сургалтыг хэрэглээ талаас нь хардаг. Суралцагч сурч буй зүйлээ амьдралдаа түргэн хэрэглэхийг хүсдэг

Бага боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сурах бичиг:



Суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сурах бичиг:





Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн модулиуд:



Дүйцсэн сургалтын хөтөлбөрийн агуулга нь суралцагчийн танин мэдэхүйн үйл ажиллагааг хөтлөн чиглүүлэх, хөгжүүлэх, төлөвшилийг хянах, оношлох, үнэлэх цогц агуулга бүхий модулийн багцаас бүрдэх ба тэдгээр нь суралцагчдад харилцах, эрдэмших, амьдрах, иргэнших арга ухааны чадамжийн хүрээнд эзэмших мэдлэг, чадварыг олгоход тусална. Модуль бүр бусад модультайгаа нийцэн уялдах агуулгатай.

Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтын агуулга нь ерөнхий боловсролын тухайн шатны агуулгын 70-аас доошгүй хувьтай дүйцэхээр төлөвлөх⁷ бөгөөд "Суралцагч танхимаас бусад хэлбэрээр суралцах гэрээ байгуулсан тохиолдолд 4.2-т заасан

7 БСШУС-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/168 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-ын заалт 4.2



төлөвлөгөөт цагийн гуравны нэгийг заавал танхимын сургалтаар судлах бөгөөд жилд хоёроос доошгүй удаа, 14 хоногоос доошгүй хугацаагаар сургалтад хамрагдана”⁸.

Хүснэгт 1. Бага боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсруулсан жишээ:

№	Хичээл	2019 оны А/491 дугаар тушаал/2018 оны А/168 дугаар тушаал							
		I анги				II анги			
		100%	70%	70%-ийн 3/1 (танхимаар)	70%-ийн 3/2(гэрээр)	100%	70%	70%-ийн 3/1 (танхимаар)	70%-ийн 3/2(гэрээр)
1	Монгол хэл	192	134	44	90	224	156	52	104
2	Математик	112	78	26	52	160	112	37	75
3									

Д/д	Хичээл/түвшин	I		II		III		IV		V		Нийт цаг
		Т	Г	Т	Г	Т	Г	Т	Г	Т	Г	
1	Бэлтгэл хөтөлбөр	14	28									42
2	Монгол хэл	44	90	52	104	52	104	52	104	52	104	758
3	Иргэний ёс зүйн боловсрол	15	29	15	29	15	29	15	29	15	29	220
4	Математик	26	52	37	75	37	75	37	75	37	75	526
5	Хүн ба орчин	15	29	15	29	15	29					132
6	Хүн ба байгаль							15	29	15	29	88
7	Хүн ба нийгэм							7	15	15	29	66
8	Дүрслэх урлаг, технологи	13	27	15	29	15	29	15	29	15	29	216
9	Хөгжим	13	27	15	29	15	29	15	29	7	15	194
10	Биеийн тамир	13	27	15	29	15	29	15	29	15	29	216
11	Эрүүл мэнд							7	15	7	15	44
12	Англи хэл									22	45	
Жилийн нийт цаг		153	309	164	324	164	324	178	354	200	399	2502

Үндэслэл:

БСШУС-ын Сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/491 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

⁸ Мөн журамын заалт 4.4



Тайлбар:

Дээрх үлгэрчилсэн төлөвлөгөөг боловсруулсан аргачлалын дагуу суурь болон бүрэн дунд боловсролыг нөхөн олгох төлөвлөгөөг багш бүр боловсруулж баталгаажуулан ажиллана. Хөгжлийн онцлог бүхий суралцагчдад боловсрол нөхөн олгоход ганцаарчилсан сургалтын хөтөлбөр чухал үүрэгтэй (ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг хавсралт 4-өөс үзнэ үү).

Хүснэгт 2. Бага боловсрол нөхөн эзэмших сургалтын хугацааны санал болгож буй үлгэрчилсэн хувилбар:

сургалт		I сургалт				II сургалт				III сургалт			
сар		X	X	XI	XII	I	I	II	III	IV	IV	V	VI
7хоног		2	X сарын III 7 хоногоос XII сарыг дуустал			3	Iсарын IV 7 хоногоос III сарыг дуустал			2	IVсарын III 7 хоногоос VIсарын II7 хоног дуустал		
Анги/түвшин	I	T	G	G	G	T	G	G	G	T	G	G	G
	II	T	G	G	G	T	G	G	G	T	G	G	G
	III	T	G	G	G	T	G	G	G	T	G	G	G
	IV	T	G	G	G	T	G	G	G	T	G	G	G
	V	T	G	G	G	T	G	G	G	T	G	G	G

Т

*Танхимын сургалт

Г

*Гэрийн сургалт

Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна. Хөгжлийн онцлог бүхий суралцагчдын эрүүл мэндийн байдлаас хамаарч 20 минут байж болно.

Гэрээр сургалт зохион байгуулах үйл явц

Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалтыг дүйцсэн хөтөлбөрөөр танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болно. Танхимын сургалтад суралцагчдын нас, сэтгэхүйн онцлог, боловсролын түвшнээс хамаарч дагнасан болон холимог бүлгийн хэлбэрийг ашигладаг бол танхимын бус сургалтын хэлбэрт:

- гэрийн сургалт
- бие даах сургалт



- түргэвчилсэн экстернат сургалт
- зайны сургалт
- шавь сургалт зэргийг оруулна.

Гэрээр сурах үеийн сургалтыг чиглүүлэх, гэрийн, бие даасан, зайны сургалтын хэлбэрийг хослуулан явуулах нь зохимжтой байдаг. Гэрээр сурах нь тусгай хэрэгцээт хүүхдүүдийн боловсрол нөхөн эзэмших сургалтын нэг хэлбэр болохоос биш манай улсын хувьд хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн боловсрол эзэмших бие даасан хэлбэр биш юм.

Гэрийн сургалтыг танхимын сургалттай хослуулан явуулах боломжтой бөгөөд хүнд, хэвтрийн хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг тойргийн ерөнхий боловсролын сургууль, эс бөгөөс дүүрэг, сумын Насан туршийн боловсролын төвд бүртгүүлэн явуулын багшийн тусламжтай зохион байгуулж болно.

Гэрийн сургалтын эерэг тал:

- Хөгжлийн онцлог бүхий хүүхдүүдэд тусгай биш, ердийн сургуульд үе тэнгийнхэнтэйгээ хамт сурах боломж олгодог;
- Урт удаан хугацааны туршид өвдсөн, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн агуулгыг богино хугацаанд нөхөн эзэмших боломжтой;
- Ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг насан туршийн боловсролын төвийн танхимын сургалттай хослуулан суралцаж ерөнхий боловсролын сургуулийн зохих ангид шилжин суралцах боломж олгодог.

Гэрийн сургалтын сөрөг тал:


- Хөгжлийн онцлог бүхий биш, ердийн, байнга өвддөг, эрүүл мэнд сул хүүхэд энэ хэлбэрээр боловсрол эзэмших, сурах боломжгүй;
- Сургалтын төлөвлөгөөнд үндсэн хичээлүүд болох математик, монгол хэл, нийгмийн ухаан, байгалийн ухаан зэрэг хичээлийн агуулга тусгагдсан байдаг тул (дүрслэх урлаг, биеийн тамир, дуу хөгжим, эрүүл мэнд зэрэг хичээлүүдийн агуулгыг бараг тусгадаггүй) хүүхэд эргэн сургуульд орох үед эдгээр хичээлүүдийг тооцуулах асуудалд хүндрэл тулгарч болзошгүй;
- Гэрээр суралцаж буй хүүхдүүдтэй ажиллах тусгай, явуулын багшийн орон тоо сургуулиуд болон насан туршийн



боловсролын төвүүдэд байдаггүй, багшийн үйл ажиллагааг дэмжих материаллаг болон санхүүгийн боломж, хөшүүрэг байдаггүй нь тус хэлбэрийн сургалтыг зохион байгуулах идэвх, сонирхлыг бууруулдаг;

- Хүүхдийн нийгэмшихүйн талын асуудал орхигддог.

Гэрийн сургалт зохион байгуулахад оролцогч талууд:



Оролцогч талуудын үүрэг, анхаарах асуудал:

1. Насан туршийн боловсролын төв

- Боловсрол нөхөн эзэмших сургалтыг дээрх санал болгож буй сургалтын хугацаа, төлөвлөгөөтэй уялдуулан эцэг эх, асран хамгаалагчид, олон нийтийн оролцоонд түшиглэн гэрээр зохион байгуулна.
- Гэрийн сургалтын хугацааг эцэг эх, асран хамгаалагчидтай зөвшилцөн хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн онцлог, сурч байгаа байдалд тохируулан уян хатан зохицуулах ба түүнийг эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гэрээнд тодорхой тусгана (хавсралт 2-оос харна уу).
- Гэр сургалтын хэлбэр, үйлчилгээ үзүүлэх хугацаа, багшийн цагийн хуваариас шалтгаалан хичээлийн хуваарийг уян хатан, өөрчлөлт оруулж болох байдлаар хийнэ.
- Гэр сургалтыг үр дүнтэй явуулахад сургалтын төлөвлөгөө,



хөтөлбөр чухал үүрэгтэйг мартаж болохгүй. Төлөвлөгөөнд үндэслэн тухайн хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хөтөлнө. Хичээлийн төлөвлөгөөнд дараах шаардлагыг тавина:

- Суралцагчийн бодит байдлын судалгаанд үндэслэх;
 - Урт болон богино хугацааны зорилтыг тодорхойлох;
 - Явцын болон үр дүнгийн үнэлгээг хийх;
 - Суралцагчийн онцлогт тохирсон арга зүй, хэрэглэгдэхүүнтэй байх;
 - Багшийн дэмжлэг арга зүйг тодорхой бичиж, тэмдэглэх;
 - Багш суралцагчийн ахиц, дэвшлийн талаар тэмдэглэл хөтлөх.
- Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд тус бүрд зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, сургалтын материал бэлэн болсны дараа гэр сургалтыг зохион байгуулна. Ингэхдээ дараах зүйлийг анхаарна.
 - Сонгосон хүүхдэд гэрээр хичээлийг явуулахад очих айлын зураглалыг гаргана.
 - Суралцагчийг биеэ барихгүйгээр чөлөөтэй оролцох сэтгэл зүйн орчныг эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран бүрдүүлнэ.
 - Багш суралцагчийнхаа тулгамдсан асуудлыг нь шийдэхэд, түүнд туслахад бэлэн байна.
 - Гэр сургалтыг зохион байгуулахаас өмнө эцэг эх, асран хамгаалагчдыг сургалтад хамруулж бэлдсэн байна.
 - Гэрээр хичээллэх үед эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо жигд байгаа эсэхэд анхаарна.
 - Хичээлийн явцад суралцагчийн гүйцэтгэж буй даалгавар нь тухайн хүүхдийн чадварт тохирсон эсэхийг ажиглана. Тохиромжгүй байдал ажиглагдсан нөхцөлд тэмдэглэн авч, цаг алдалгүй өөрчилж, засварлана.
 - Үнэлгээг тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар хийнэ.



2. Эцэг эх, асран хамгаалагч:

- Хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаарх мэдээллийг сургууль, багшид танилцуулна.
- Хүүхдийг гэрээр боловсрол нөхөн эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлнэ (мэдээлэл 6-г танилцуулах).
- Багш, сургууль, насан туршийн боловсролын төв, өрхийн эмнэлэг, сургалтын багийн бусад гишүүд, үе тэнгийн хүүхдүүд, найз нартай нь хамтран ажиллана.
- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан тавьсан сургалтын багийн шаардлагыг хүлээн зөвшөөрнө, биелүүлнэ.
- Хүүхдийнхээ суралцах хүсэл, сонирхлыг нь дэмжинэ.
- Хөгжлийн онцлогтой хүүхдийг өрхийн болон бусад эмчийн хяналтад байлгана. Цаг тухай бүрд эрүүл мэндийн үзлэгт оруулна.
- Хүүхдийг гэр бүлийн орчинд тасралтгүй сургахын тулд хөрш, саахалт айлын хүмүүсийн туслалцаа, дэмжлэгийг авч хамтран ажиллана.
- Хүүхдийг нийгэмшүүлэх асуудлыг анхаарч үе тэнгийн хүүхдүүдтэй тоглох, харилцах цаг гаргаж өгнө. Үзвэр, үйлчилгээ үзүүлж, аялал зохион байгуулан танин мэдэхүйн чиглэлийн ажлыг зохион байгуулна.
- Хүүхдийнхээ сургалтын үйл ажиллагааны явц, хөгжлийн ахиц, сургалтын үр дүнг багштай болон хүүхэдтэй ярилцаж, шаардлагатай зүйлсийг хамтран шийдвэрлэнэ.
- Хүүхдийнхээ дэргэд хэрэлдэж, зодолдохыг цээрлэнэ. Хүүхдэдээ үлгэр дуурайлал нь байна.
- Эцэг эх, гэр бүлийн гишүүдийн шаардлага нэгдмэл байна.
- Амласнаа биелүүлдэг байна.
- Хүүхэдтэй зөв, боловсон харилцана. Үгийг оновчтой зөв хэрэглэнэ.
- Иргэний үүргээ биелүүлнэ.

3. Тойргийн ерөнхий боловсролын сургууль:

- Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулахад Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажиллана.
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт дүйцсэн



хөтөлбөрийн сургалтыг гэрээр зохион байгуулах арга зүй, мэдлэг эзэмших сургалтыг зохион байгуулна.

- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай, гэрээр сурах хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад болон орон нутгийн зайлшгүй шаардлагатай байгууллагын төлөөллүүдэд зориулсан сургалтыг Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулна.
- Гэрээр суралцах хүүхдийн сурах бичиг, хичээлийн хэрэглэл, техник тоног төхөөрөмжөөр хангахад оролцоно.
- Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн эзэмшсэн суралцагчийг ЕБС-ийн зохих ангид шилжин суралцах нөхцөлөөр хангана.
- Боловсрол нөхөн олгох асуудлаар суралцагч, эцэг эх, асран хамгаалагч болон холбогдох байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлж ажиллана.
- Багш, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллана.

Үүнээс гадна НТБТ-ийн багш орон нутаг дахь боловсрол хариуцсан ажилтан, хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлэг, баг хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, цагдаагийн хэлтэсгэх мэт байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах хэрэгтэй.

Гэрээр сургалт зохион байгуулахад их дээд сургуулийн оюутан залуус, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хүүхдүүд, хөрш айлын гишүүд, хамаатан садан хүмүүс, сайн дурын ажилтан залуус зэрэг хүмүүсийг баг болгон, бэлтгэн тус үйл ажиллагаанд оролцуулж болно.

МЭДЭЭЛЭЛ 5. Гэрээр сургалт зохион байгуулах багшид өгөх зөвлөмж

Гэрээр сургалт зохион байгуулах багш:

- Тусгай хэрэгцээт хүүхдүүд, тэр дундаа хөгжлийн онцлог бүхий хүүхэдтэй ажиллах онол, арга зүйн материалуудыг судалж, модулиудтай танилцан, энэ чиглэлийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.
- Гэрээр боловсрол нөхөн олгох боломж, нөхцөлийг судалж тогтоон шийдвэрлэсэн байна:
 - эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдал, боловсролын түвшин, эрхэлдэг ажил;



- хүүхэд сургах гэрийн нөхцөл, орчин;
 - амьдралын түвшин, боломж;
 - хүүхдэд гэрээр сурахад туслах гэр бүлийн гишүүн;
 - суралцагчид үзүүлэх материаллаг тусламж, сургалтын материал, гарын авлага, зайны сургалтад ашиглах техник тоног төхөөрөмж;
 - сургалтын хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэх багийн бүрдүүлэлт;
 - Насан туршийн боловсролын төвөөс тухайн айл хүртэлх зай, тэднийд очих, буцах замын маршрут, зарцуулах цаг, унааны асуудлын урьчилсан төлөвлөлт зэргийг.
- Суралцагчдын судалгааг багш эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ярилцлага хийх, асуулт асуух, хүснэгт бөглүүлэх зэргээр дараах асуулгын хүрээнд хийж болно.

1. Хүүхдийн талаарх мэдээлэл:

- Хүүхдийн овог, нэр
- Төрсөн он, сар, өдөр
- Нас, хүйс
- Регистрийн дугаар
- Харьяалал, гэрийн хаяг
- Сургуульд орж байсан эсэх /орсон он
- Суралцаж байсан сургууль, завсардсан анги
- Судалгаанд орох болсон тухай тэмдэглэл

2. Ахуй амьдралын талаарх мэдээлэл:

- Ам бүлийн байдал /хэдүүлээ, хэн, хэнтэйгээ амьдардаг/
- Эцгийн ажлын газар, эрхэлдэг ажил
- Эхийн ажлын газар, эрхэлдэг ажил
- Хүүхдийн амьдралын нөхцөл байдал
- Хүүхэдтэй харьцах гэр бүлийн гишүүдийн харилцааны байдал /хэт эрхлүүлэх, шоовдорлох, аашлаж загнах, үл хайхрах гэх мэт/
- Өргөмөл, өнчин, хойд аав, ээжтэй эсэх

3. Эрүүл мэнд, биеийн байдал:

- Хүүхдийн өвчин, бэрхшээлийн байдал багшийн ажиглалтаар
- Мэргэжлийн эмч нарын өгсөн өвчний онош



4. Сэтгэл зүйн байдлын судалгаа:

- Орчин тойронтойгоо харьцах чадвар /тухайн хүүхэд судалгаанд хамрагдаж байх үед хийгдэх багшийн ажиглалтын үндсэн дээр тодорхойлно/
- Хүүхэд өөрөө эцэг эх, орчин тойрны байдалд дүгнэлт хийх чадвар

5. Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн байдал:

Гол зүйлийг ялгах чадвар /багш урьдчилан бэлтгэсэн хэрэглэгдэхүүн ашиглана/

- Дүрс өнгийг зөв ялгаж, дүрсийг дуурайлгах чадвар
- Сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар
- Эвлүүлэх чадвар /дүрс болон зураг ашиглаж болно/
- Төстэй ба төсөөгүй дүрсийг ялгах чадвар
- Сэтгэн бодох чадвар
- Хэсгийг зөв олох чадвар
- Өнгө дүрсийг ялгах чадвар
- Үйл явдлыг зөв ойлгож, дарааллын дагуу зөв байрлуулах чадвар

6. Ой тогтоолтын байдал:

- Дуу болон шүлэг мэддэг эсэх
- Багшийн ширээг тогших тоог хэлэх, дуурайж давтан тогшиж чадаж буй эсэх /Тухайлбал, 2, 4, 5 гэх мэт тоог тогшино /
- Багшийн уншиж эсвэл ярьж өгсөн зүйлийн утгыг ойлгож буй эсэх /богино үлгэр, өгүүлэл гэх мэт/

7. Хөдөлгөөний эвсэл:

- Нарийн эвсэл /тоглоомын жижиг хэсгүүдтэй ажиллаж чадаж байгаа эсэх. Тухайлбал, жижиг эд ангийг барьж, эвлүүлж чадаж байгаа байдал/
- Энгийн эвсэл /Зураг болон дүрс эвлүүлэх явцад нь багш ажиглалт хийнэ/

8. Тоолох чадвар:

- 1-10 хүртэл тоолох чадвар
- Урвуу тоолох
- Цифр таньдаг эсэх /тухайн хүүхдийн хөгжлийн түвшин, сургалтын хөтөлбөрөөс шалтгаалан өгөгдлийг өөрчилж болно/



9. Зурах чадвар:

- Зураг харж дуурайж зурах чадвар
- Дуртай зургаа өөрөө зурах чадвар
- Бүдэг зурсан зургийг тодруулан, давхарлан зурах чадвар

10. Бичих чадвар

- Үзэг, харандаа барих чадвар
- Дүрс дуурайн бичих чадвар
- Хуулан бичлэг хийх чадвар гэх мэт

11. Өгүүлэх эрхтний дуурайх чадвар

- Уруул, амны хөдөлгөөн хийх
- Хэлээ төрөл бүрийн чиглэлд хөдөлгөх
- Хэлний дасгалууд дээр ажиллаж байгаа байдал /багш ажиглалт хийнэ/

12. Авиа дуурайх чадвар

- Эгшиг авиа
- Гийгүүлэгч авиа
- Богино үг хэлэх
- Янз бүрийн амьтны дуу, авиаг дуурайх

13. Харилцааны арга:

- Харилцааны аргыг тодорхойлох
- Дохио зангаа хэрэглэдэг эсэхийг ажиглах

14. Нийгэмшихүйн байдал:

- Эцэг эх, багштайгаа мэндэлдэг эсэх
- Бусдаас уучлалт гуйж чаддаг эсэх
- Гэр бүлийнхнийгээ танилцуулж чаддаг эсэх
- Ямар нэгэн ажилд өөрийн санаачлагаар оролцдог эсэх

15. Өөртөө үйлчлэх чадвар:

- Бие даан өөрөө хувцасладаг эсэх
- Өөрөө хооллож чаддаг эсэх
- Сайн муу зүйлийг ялгаж чаддаг эсэх
- Мэдэхгүй зүйлээ асууж, тодруулж чаддаг эсэх.



- Гэр сургалтын үйлчилгээ үзүүлэх хугацаанаас шалтгаалан багшийн ажиллах цагийн хуваарь, хүүхдийн хичээлийн хөтөлбөр уян хатан байх шаардлагатай. Гэрээр боловсрол нөхөн олгох сургалтыг зайны сургалтын хэлбэртэй хослуулах байдлаар зохион байгуулж болно. Сургалтын ямар хэлбэр сонгосноос хамаарч хичээлийн ялгаатай хуваарийг хийнэ.
 - Гэр сургалтыг үр дүнтэй явуулахад багшийн хичээлийн төлөвлөлт, ээлжит хичээл бүрийн төлөвлөгөө чухал үүрэгтэй байдгийг санаж тухайн хүүхдийн онцлог байдлыг харгалзсан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан мөрдөнө. Хичээлийн төлөвлөгөөнд дараах шаардлагыг тавина:
- Суралцагчийн бодит байдлын судалгаанд үндэслэх;
 - Урт болон богино хугацааны зорилтыг тодорхойлох;
 - Явцын болон үр дүнгийн үнэлгээг хийх;
 - Суралцагчийн онцлогт тохирсон арга зүйг хэрэглэх;
 - Сургалтын хэрэглэгдэхүүнийг суралцагчийн онцлогийг тооцож боловсруулах, хийх;
 - Багшийн үзүүлэх дэмжлэг, арга зүйг тодорхой бичиж, тэмдэглэх;
 - Багш суралцагчийн ахиц, дэвшлийн талаар тэмдэглэл хөтлөх (Хавсралт 5-аас үзнэ үү) .

Дараах зүйлийг сургалтын үед анхаарч ажиллана:

- Багшийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллана.
- Сургалтын хуваарийг тооцоо судалгаанд үндэслэн гаргана.
- Хүүхдийн сурах хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургалтын арга зүй, агуулгыг сонгоно.
- Эцэг эх, асран хамгаалагчдыг багшлах арга барилд сургана, зохих зөвлөмжөөр хангана.
- Суралцагчийг биеэ барихгүйгээр хичээлд чөлөөтэй оролцох сэтгэл зүйн орчинг эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран бүрдүүлнэ.
- Суралцагчийн тулгамдсан асуудлыг нь шийдэж туслахад багш бүх талын бэлтгэлээ хангасан байна.
- Бага насны хүүхдийн нийгэмших үйлд онцгойлон тусална.



- 12-оос дээш насны хүүхдийг сурах арга барилд сургахад илүүтэй анхаарна.
- Багш, эцэг эх, суралцагчийн хамтаараа хөгжих боломжийг хангана.
- Тойргийн ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш, ажилчидтай хамтран ажиллана.
- Орон нутгийн засаг захиргааны байгууллага болон бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, олон улсын болон сайн дурын байгууллагуудын уялдаа холбоо, хамтач байдлыг ханган идэвх санаачилга гарган ажиллана.
- Хичээлийн явцад гүйцэтгэж буй даалгавар нь суралцагчдын чадварт тохирсон эсэхийг ажиглана. Тохиромжгүй байвал шалтгааныг тэмдэглэн авч, цаг алдалгүй алдааг засч, хүүхдийн онцлог, сонирхол, чадварт тохирсон даалгаварыг өгнө /Хавсралт 6-г үзнэ үү/.
- Гэрээр сурч буй хүүхэдтэй эргэх холбоог байнга тогтоон ажиллана.
- Ахицын болон явцын үнэлгээг байнга хийж, сургалтын явцад анализ хийнэ.
 - Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ. Үнэлгээг хийхдээ суралцагч судалсан агуулгыг өөрийн болгож, хэрэглээ болгож чадсан эсэх, нийгэмшихүйн чадамжид гарсан өөрчлөлт, бие хүний хөгжлийн төлөвшил, ахиц зэргийг харгалзана гэдгийг мартаж болохгүй (төслийн хүрээнд гэрээр бага боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдсан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч О.Д-ийн эрүүл мэнд, бие хөгжлийн талаарх судалгаа, сургалтад хамрагдаад гарсан ахиц, өөрчлөлтийг тэмдэглэсэн багшийн тэмдэглэл, ээлжит хичээлийн хөтөлбөрийг хавсралт №5-аас харна уу).

МЭДЭЭЛЭЛ 6. Хүүхдийг гэрээр сурах үед эцэг эх, асран хамгаалагчдад өгөх зөвлөмж

Хүнд өвчний улмаас, олон нийтийн хөл хорионы үед, урьдчилан тооцоолоогүй гэнэтийн нөхцөл байдлаас болж хүүхэд тодорхой хугацаанд гэрээр сурах үед эцэг эх, асран хамгаалагчид тэдэнд хэрхэн туслах вэ?



Хичээл хийх орчин нөхцөл, сурах цагийн хуваарь, зохион байгуулалтад эцэг эхчүүд ач холбогдол өгч хандах нь зүйтэй. Хүүхдийг танхимын сургалтаас гэрийн нөхцөлд шилжин сурах үед эцэг эх, асран хамгаалагчид:

1. Зайнаас сурахад хүүхдэд юу хэрэгтэй байдгийг уншиж, судлах

Гэрээр сурах нь хүүхдийн бие даан сурах үйл явц болохоос, эцэг эхийн хяналт, шахалт биш юм. Иймд түүнийг танхимын сургалтаас гэрээр сурах сургалтын шинэ хэлбэрт дасан зохицох, сурах арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлэх нь эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг билээ.

Гэрээр сурах үйл явц хэрхэн явагдах талаар эцэг эх, асран хамгаалагчид эхлээд өөрсдөө зөв ойлголттой болох ёстой. Үүний тулд анги удирдсан багштай уулзан гэрээр сурах хугацаанд ашиглах сургалтын хөтөлбөрүүдтэй танилцан, үнэн зөв мэдээлэл авч, багштай хамтран сургалтын өдрийн үлгэрчилсэн хуваарийг гаргах нь зөв. Гэрээр сурах үед юуны өмнө:

- Интернетэд холбогдсон байх
- Багштай холбогдох үед дүрсээ харах боломжийг бүрдүүлэн веб-камер болон микрофон бэлдсэн байх
- Хүүхдэд тохирсон, тав тухтай сандал, ширээ зэрэг сурах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх

2. Зайны сургалт явуулах боломж, интернэтийн холболтыг шалгах. Гэрийн сургалтын хөтөлбөрүүдийг судалж өөрийн болгох

Зайны сургалт явуулах боломжийг судлан, шаардлагатай үед техник тоног төхөөрөмжид гарах жижиг засвар үйлчилгээг хийж чаддаг болох: компьютер, камер, микрофон холбох, дууг чангалах, намсгах гэх мэт.

Хүүхдийн гэрээр сурах үед сургууль болон Насан туршийн боловсролын төвийн багш, эцэг эх, асран хамгаалагчдын хооронд хийгдэх гэрээ, заавар зөвлөмжийг анхааралтай судлах.


Гэрийн сургалт хоёр хэсгээс бүрддэг: видео холболтыг ашиглан багштай харилцах, бие даан сургалтын хөтөлбөрийг судлах. Эцэг эхчүүд зайнаас сургах техник тоног төхөөрөмж, интернэтийн хурд муу зэрэг нь гэрээр сурах үед хүүхдийн сургалтад сөргөөр нөлөөлөх, хүүхэд бусдаасаа хоцрох шалтгаан болох магадлал өндөр гэж үздэг. Иймд асуудал



тулгарсан үед хэрэглэх хичээлийг урьдчилан аудио, видео хуурцагт бичиж бэлдсэн байх, түүнийг өгөх, утсаар холбогдох, хуваарийн дагуу гэрээр очих, эцэг эх асран хамгаалагчид өөрсдөө багштай ирж уулзаж зөвлөгөө авах, хүүхдийн гэрийн даалгаврыг шалгуулах, хичээлд ашиглах дараагийн үзүүлэн, тараах материал, гэрийн даалгаврыг авах зэргээр шийдвэрлэж болно.

3. Сургуулийн горим, уур амьсгалыг хадгалах, хүүхдэд мэдрүүлэх

Зайнаас, гэрээр сурах нь сургуульд явж суралцахаас өөр. Иймд танхимын сургалтын үед баримталж байсан, хүүхдийн дассан сургалтын хуваарийг алдагдуулж болохгүй. Хичээлийн цаг, завсарлага тогтмол байхаас гадна үе тэнгийнхэнтэйгээ харилцах, уулзах цаг гаргаж өгөх хэрэгтэй. Тэр бүү хэл хичээлээ хийхээр унтлагын хувцастай, нүүрээ угаагаагүй, үсээ самнаагүй суулгаж болохгүй. Хэсэг хугацааны дараа хүүхэд сургуулийн, танхимын сургалтад эргэн хамрагдах тул гэртээ хичээллэх үед ч сургалтын горимыг баримталж байх нь зүйтэй. Хүүхдийн сэтгэл санааг дэмжсэн, өөдрөг байлгах зурагт хуудсыг нүдэнд нь харагдах газар өлгөж болно.




4. Хичээлээ хийх үед өмсөх хувцсыг сонгох

Гэртээ хичээл хийх үедээ өмсөх биед нь эвтэйхэн, тохиромжтой хувцсыг сонгон өмсгөж байх нь хүүхдэд сурах уур амьсгал бүрдүүлэх, үүрэг хариуцлагаа мэдрэхэд нөлөөлдөг. Иймээс унтлагын хувцас, гэртээ өмсдөг бэлтгэлийн өмд зэрэг хувцастай хичээл хийлгэхээр суулгах хэрэггүй. Хичээлийн цаг дуусахад хүүхэд өөрийн дуртай зурагтай цамц, гэрийн шаахайгаа өмсөж болох юм.

5. Хичээлийн хуваарь гаргах


Өнгөлөг, өөрийх нь дуртай баатруудын зурагтай хичээлийн хуваарийг хүүхэдтэйгээ хамтран хийх нь тэдний сэтгэлийг сэргээхээс гадна ямар хичээлийн, хэн багштай хэзээ, хэрхэн холбогдох зэргийг ч ойлгомжтой, хялбар болгоно.






6. Мэдээлэл тавих, тэмдэглэл хийх зориулалтын самбарыг ширээний дэргэд байрлуулах

Өөрийн зохион байгуулалтыг хийхэд соронзон жижиг самбар хүүхдийн хичээл хийх ажлын байранд тохиромжтой. Гэхдээ заавал мөнгө зарж ийм самбар авах шаардлагагүй бөгөөд эцэг эх, асран хамгаалагчид гар доорх материалаар хүүхэдтэйгээ хамтран панер, мод, хөөсөнцөр хавтан, раам зангидан даавуу татаж бүрэх зэргээр самбарыг хийж болно.




7. Өөрийн хүрсэн амжилтыг тэмдэглэж байхыг хүүхдэд зөвлөх

Хичээлийн ширээний дэргэд байрлуулсан самбартаа хүүхэд өөрийн хүрсэн амжилт, хийж чадсан зүйлсээ бичин өлгөж байхыг зөвлөх хэрэгтэй. Тухайлбал, сурсан дуу, шүлэг, тооны хичээл дээр алдалгүй бодсон өгүүлбэртэй бодлого, хэлний хичээл дээр алдаагүй бөглөсөн сорил зэрэг хийсэн зүйлээ хараад хүүхэд өөрөөрөө бахархах, өөртөө итгэлтэй болох, цааш сурах итгэлтэй болоход ач холбогдолтой байдаг.



8. Өнгөлөг хуанли хийх


Зайны сургалтад аливаа юмыг харж хүлээн авах асуудал чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс сурах таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна тэмдэглэлт өдрүүд, чухал өдрүүдийг хүүхдэд сануулах хуанлийг өөрсдийн хамтын хүчээр хийх хэрэгтэй. Тухайлбал, дотны хүмүүсийн төрсөн өдөр, гэр бүлийн тэмдэглэлт өдрүүд, танхимын сургалт эхлэх өдөр, эмчид үзүүлэх өдөр гэх мэт.





9. Зуршил болгон мөрдөх зүйлс, хийх ажлыг санагдуулах зурагт хуудас хийж өлгөх

Нүдэнд харагдах бүхэн анхаарал татаж, тархины үйл ажиллагааг өдөөж байдаг. Хүүхдийг ус уулгаж сургах, улаан лоолийг цус төлжүүлэх зорилгоор идүүлэх, эсвэл эмээ зөв уух зэрэг үйлдлүүдийг сануулах, зуршил болгох зорилгоор өнгөлөг зурагт хуудсыг хамтран хийж болно. Хүүхдийн дархлаа, эрүүл мэнд сайн байвал хүүхэд идэвхтэй, сайн сурахыг мартаж болохгүй.



10. Сайн сурсны төлөө өгөх урамшууллын хуудас бэлдэх

Хүүхдийг сайн сурч байгаагийн төлөө урамшуулж болно, гэхдээ тэр нь мөнгөн хэлбэрээр байж болохгүй. Мөнгө өгөх нь хүмүүжлийн арга биш, харин хүүхэд эцэг эхэд саад болохгүй, тэднийг элдэв асуудалд орооцолдуулахгүй, чих халууцуулалгүй сайн сурах хөшүүрэг болох буруу арга гэдгийг сэтгэл судлаачид тэмдэглэдэг. Хүүхэд сурч олсон мэдлэг нь эцэг эхэд биш, түүнд өөрт нь хэрэгтэй, сурах үйл нь мөнгө олох арга биш гэдгийг ойлгосон байх ёстой.



Хүүхдийг урамшуулах ёстой, гэхдээ тэр нь түүнд сайхан мэдрэмж төрүүлэм, өөрт нь ашигтай, хэрэгцээтэй, мэдлэгийг баяжуулсан, сонирхлыг нь татам байвал сайн. Урамшууллын хуудсыг хүүхэдтэйгээ хамтран хийхдээ дуртай кино үзэх тасалбар өгөх, амттан авч өгөх, найзуудтайгаа цэнгүүн хийх, агаарт гарах, ууланд зугаалах, музей үзэх, сонирхсон ном авахуулах зэрэг байж болно. Харин амжилтад хүрч чадахгүй, сул сурахад хүүхдийг загнаж болохгүй, түүнд тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэхэд нь, даван туулахад нь туслах хэрэгтэй.

11. Онлайнаар харилцах үед баримтлах ёс зүйн талаар ойлголт өгөх

Гэрээр сурах үед хүүхэд багштай болон анги хамт олонтой онлайнаар харилцана. Интернэтийн орчинд хүүхэд биеэ хэрхэн зөв авч явах талаар эцэг эх, асран хамгаалагчид ярилцаж, зөв ойлголт өгөх хэрэгтэй. Интернэт орчинд баримтлах дүрмийг хамтран зохиож,





зурагт хуудас хэлбэрт оруулан өлгөх нь хүүхдэд дүрмээ дахин дахин уншиж, хэвшил болгоход нөлөөлөх сайн талтай. Тухайлбал, том үсгээр бичихгүй, анхаарлын болон асуултын тэмдгийг дараалж олон тавихгүй, “баярлалаа, зүгээр, уучлаарай” үгнүүдийг хэлж байх, бусдын яриаг таслалгүй, санал бодлыг хүндэтгэж сонсож сурах, бүдүүлэг үгнүүд хэрэглэхгүй байх, нүүрээ янз бүр болгохгүй, хамраа ухахгүй гэх мэт хүүхдэд тулгарч болзошгүй, өөрийн мэдэлгүй хийдэг үйлдлүүдээс урьдчилан сэргийлж, бусдын өмнө эвгүй байдалд оруулахгүй байх үйлдлүүдийг тусгаж болно.

12. Хичээл хийхээс нэг цагийн өмнө хүүхдийг сэрээсэн байх

Хүүхдийн унтах горим амархан алдагддагийг санаж хичээл хийхээр суухаас нь өмнө нүүр гарыг нь угаалгаж, өглөөний цайг уулгаж, хувцсаа солин, сурах бэлтгэл хангагдсан үед ширээний ард суулгах ёстой. Хүүхдийг өлсгөлөн, ариун цэвэр сахиагүй байхад хичээл хийлгэхээр суулгаад ямар ч амжилтад хүрэхгүйг хатуу санах хэрэгтэй. Гэрээр сурах үеийн хичээлийн цагийг 9.00 эсвэл 10.00 цагт эхлэхээр төлөвлөх нь зүйтэй.



13. Хичээлийн үед мэдээллийн бүх сувгуудыг унтраах

Хүүхэд хичээл хийхээр суух үед зурагт, гар утас, радио зэрэг олон нийтийн мэдээллийн сувгуудыг унтрааж зөвхөн үзэж буй, судалж буй зүйлд төвлөрөх орчинг бий болгож өгнө. Хичээлийн цагаар интернэт орох, тоглох зэргийг хатуу хориглох хэрэгтэй.



14. Ширээн дээр ус бэлдэж тавих

Хичээл эхлэхийн өмнө хүүхдийн ширээн дээр нэг аяга цэвэр эсвэл буцалгасан бүлээн ус тавих шаардлагатайг эцэг эхчүүд мартаж болохгүй. Лимоны шүүс, гаа, цагаан гаа зэрэг витаминлаг, хоргүйжүүлэх зүйлийг усанд нэмж амт оруулж болно. Дэлгүүрээс худалдан авсан элсэн чихэр ихтэй, биед хортой ундаа, шүүснээс гэрийн нөхцөлд өөрсдөө байгалийн жимсээр чанасан шүүс, цэвэр ус уулгаж сургах нь хүүхдийн эрүүл мэндэд ач холбогдолтой билээ.



15. Хөнгөн зууш бэлдсэн байх

Хичээлийн дундуур хүүхэд анхаарлаа сарниулж, юм идэхээр гал тогооны өрөө рүү явах ёсгүй. Иймд завсарлагаанаар идэх хөнгөн зууш, боов, тараг зэрэг амин дэм ихтэй, эрүүл мэндэд хэрэгтэй зүйлийг бэлдсэн байх нь зүйтэй юм. Онлайнаар багш, ангийн суралцагчидтай харилцаж байх үед бусдыг хүндэтгэж идэж, уухгүй байхыг хүүхдэд анхааруулах хэрэгтэй.



16. Хичээл хийх үед өрөөнөөс гэрийн тэжээвэр амьтдыг гаргах

Гэрээр сурах үед хүүхдийн анхаарлыг гэрийн тэжээвэр амьтад болох нохой, муур, шувуу зэрэг нь анхаарлыг их сарниулдаг. Хүүхэд нохой, муураа илэх, тэднийг гүйхэд харах зэргээр уншиж, бичиж буй зүйлээ орхиж тоглох хүсэл нь ихэсдэг. Иймд хичээл хийх үед хайртай амьтдыг гадаа гаргах, өөр өрөөнд оруулах нь зөв юм.

17. Хүүхдийг дэлгэцнээс хол байлгах

Хичээлийн завсарлагаанаар хүүхдийг компьютер, гар утас, телевизийн дэлгэцнээс хол байлгах хэрэгтэй: өөр өрөөнд оруулах, гадаа гаргах, сонирхолтой зүйлийн талаар ярилцах, дуртай зургийг нь будуулах, хөдөлгөөнт дасгал хийлгэх, дуу дуулуулах, цэцэг услуулах гэх мэт.



18. Үе тэнгийн нөхөдтэй нь тоглуулах

Танхимын сургалтын үед хүүхэд зөвхөн сурдаг биш, тэд харилцаанд орж, нийгэмшиж байдаг. Иймд гэрээр сурах үед найз нөхөд, ангийнхан, хөрш айлын хүүхдүүдтэй тоглох, харилцах, уулзах, ярилцахад нь цаг гаргаж, нөхцөлийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй. Энэ бүгд хичээл дууссаны дараа болно гэдгийг эхнээс нь цагийн хуваарь хийхдээ ойлгуулах нь зөв юм.




19. Багштай холбоотой байх

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ гэрээр бие даан сурч байх үед ямар даалгавар гүйцэтгэж, юуг, яаж хийж байгаа, юу нь ойлгомжгүй хүндрэл учруулж байгаа зэргийг үргэлж сонирхож байх ёстой. Багштай байнгын холбоотой байж хүүхдийнхээ ололт амжилт, дутагдалтай тал, хоцрогдол, сахилга бат, шинээр судлахаар болсон хичээлийн хөтөлбөр зэргийг цаг тухай бүрд сонирхож байх нь зүйтэй. Хичээл, сургалтын талаар эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэлтэй байх, хичээлийн явцад анхаарал хандуулах нь хүүхдийг зайнаас гэрээр сурах асуудалд хариуцлагатай хандахад нөлөөлдөг гэдгийг мартаж болохгүй.

20. Биеийн тамир, дасгал, хөдөлгөөн хийх тоног төхөөрөмж, хэрэгсэл байршуулах

15 минутын завсарлагааны үеэр хүүхэд хөдөлгөөн хийж, нуруугаа сунган турникээс зүүгдэх, том бөмбөгөн дээр өнхрөх зэрэг боломжийг өрөөнд нь бүрдүүлэх нь зүйтэй юм. Хүүхдийн бялхаж буй энергийг тэдний эрүүл мэнд, чийрэгжилтэд нь хэрэгтэйгээр зөв чиглүүлэх нь маш чухал гэдгийг санаж байх хэрэгтэй.

Нөхцөл байдал өөрчлөгдөн гэрээр сурахад эхний долоо хоног дасан зохицоход бэрхшээлтэй байж болох боловч хоёр дахь долоо хоногоос бүх зүйл байрандаа орох тул санаа зовох зүйл эцэг эх, асран хамгаалагчдад тохиолдохгүй ээ. Хамгийн гол нь хүүхдийн сурах орчинг дээр дурдсаны дагуу бүрдүүлэх ёстойг анхаарах хэрэгтэй.





БҮЛЭГ 2. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ЗҮЙ

ДЭД СЭДЭВ 2.1. ХОЛИМОГ БҮЛЭГТ НЭГ ЦАГТ НЭГ ХИЧЭЭЛИЙГ ӨӨР ӨӨР ТҮВШИНД ЗААХ АРГАЧЛАЛ

ЗОРИЛГО	Холимог бүлгийн арга зүйгээр математикийн хичээлийг нэг цагт түвшин ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ангид заах аргачлалыг судлах
ХУГАЦАА	2 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Мэдлэгийн түвшин ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт нэг цагт нэг хичээлийг заах арга зүйд суралцаж, өөрийн сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэнэ.
АРГА ЗҮЙ	• Лекцийн арга • Харилцан мэдээлэл солилцох арга • Оролцооны арга • Багаар ажиллах арга • Эвлүүлгийн арга

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. “Шинэ үсгийн багш” уран сайхны киноны бичлэгийн хэсгийг үзүүлж холимог бүлгийн багш, суралцагч, орчин, арга зүйн талаар ярилцах

Хүрэх үр дүн: Холимог бүлгийн сургалтын уламжлал, хөгжил, шинэчлэл, хэрэгцээнд тулгуурлан дүгнэлт хийнэ.

Зарцуулах хугацаа: 50 мин

2. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулагдаж буй хичээлийн бичлэг дээр тулгуурлан шинэ мэдлэг олгох

Хүрэх үр дүн: Мэдлэгийн түвшин ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт нэг цагт нэг хичээлийг заах аргачлалтай болно.

Зарцуулах хугацаа: 60 мин

3. Хичээлийн дүгнэлт 10 мин



АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. Дэлгэц цаас
2. Скоч
3. Маркер /самбар, цаас/
4. Мэдээлэл
5. Зурагт үзүүлэн
6. Уран сайхны киноны бичлэг

ДААЛГАВАР:

№1. Мэдлэг бүтээх дасгал ажиллана. Энэхүү дасгалыг хийснээр монголд байсан уламжлалт холимог бүлгийн сургалт, холимог бүлгийн багш, суралцагч, орчин, арга зүйг тодорхойлно:

- Багш оролцогч нэг бүрт зураг тараан өгч 4 багт хуваана. Баг тус бүрийн ширээн дээр “**багш**”, “**суралцагч**”, “**орчин**”, “**арга зүй**” гэсэн тулгуур үгийг бичсэн бүлгийн цаас болон маркер бэлдэж тавьсан байна.

Оролцогчид өөрсдийн авсан зургийг хараад хамааралтай тулгуур үгтэй ширээнд сууна.

- Багш оролцогчдод “Шинэ үсгийн багш” уран сайхны киноны хэсгээс бичлэг үзүүлнэ. Оролцогчид бичлэгийг үзэхдээ 4 баг тус тусын ногдсон даалгаврын дагуу ажиглалт хийнэ. Тухайлбал:
 1-р баг багшийг ажиглан давуу болон сул талыг жагсаан бичих
 2-р баг суралцагчдыг ажиглан давуу болон сул талыг жагсаан бичих
 3-р баг орчныг ажиглан давуу болон сул талыг жагсаан бичих
 4-р баг арга зүйг ажиглан давуу болон сул талыг жагсаан бичих даалгаврыг өгнө.
- Баг тус бүр өөрсдийн ажигласан зүйлээ тайлбарлан дүгнэлт гаргана. Багш баг тус бүрийн дүгнэлтийг нэгтгэн “Холимог бүлгийн сургалтыг зохион байгуулах арга зүй” сэдвээр мэдээлэл өгнө.

№2. Мэдлэгийн түвшин ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт нэг цагт нэг хичээлийг заах аргачлалыг математикийн хичээлээр жишээ болгон танилцуулна.

Багш оролцогчдод холимог бүлэгт хичээл зааж буй бичлэг үзүүлэн, тайлбартай дасгалын аргаар шинэ мэдлэг олгоно. Хичээлийн:

- бүтэц
- цагийн төлөвлөлт



- арга зүй
- хэрэглэгдэхүүний талаар мэдээлэл өгнө. Ярилцлага зохион байгуулна.

№3. Дүгнэлт хийнэ:

1. Цаг хугацаа болон орон зайн хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш түвшинд нас сэтгэхүй, амьдралын туршлага, авьяас сонирхол нь харилцан адилгүй суралцагчид хамт хичээллэх сургалтын хэлбэрийг холимог бүлэг гэх ба холимог бүлгийг зөв зохион байгуулж чадвал олон давуу талтай.
2. Холимог бүлгийн багш нь холимог бүлгийн заах арга зүй, технологийг эзэмшсэн байхаас гадна хөрвөх чадвар сайтай байх ёстой. Суралцагчдын мэдлэг, чадварын түвшнээр өөр хоорондоо ялгаатай байдлыг үл харгалзан ангийн бүх суралцагчдад хичээлийг үр дүнтэй хүргэх янз бүрийн стратегийг ашиглан ээлжит хичээлийнхээ хөтөлбөрийг боловсруулдаг байна.

МЭДЭЭЛЭЛ 1. Холимог бүлгийн сургалтыг зохион байгуулах арга зүй

Холимог бүлгийн сургалтыг зохион байгуулахдаа:

1. Онолын бэлтгэл
2. Мэдээлэл сурталчилгаа
3. Суралцагчдын судалгаа
4. Бүлэг зохион байгуулалт
5. Хичээлийн хуваарь
6. Хичээлийн төлөвлөгөө
7. Хичээлийн зохион байгуулалт
8. Үнэлгээ гэсэн 8 үндсэн чиглэлээр бэлтгэл ажил хийгдэнэ.

Онолын бэлтгэл: Бага боловсролын дүйцсэн сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах онол, арга зүйн материалуудыг судалж, сурах бичиг, модулиудтай танилцана.

Багш ашиглаж болох ном, сурах бичиг, гарын авлагаас





Мэдээлэл сурталчилгаа: Сургалтад хамрагдах хүмүүсийг судалж урилга, мэдэгдэл өгч, цуглуулахдаа тухайн нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, сургууль, багийн засаг дарга зэрэг хүмүүстэй хамтран гүйцэтгэнэ. Суралцагчдаа цуглуулсны дараа тэдний зорилго, хэрэгцээг судалж, түвшинг тогтооно.

Суралцагчдын судалгаа: Судалгааны зорилго сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй тусгай хэрэгцээт хүүхэд бүрийн эрүүл мэндийн онцлог, гар хуруу, жижиг булчингийн ажиллагаа, хөдөлгөөний эвсэл, ярих, өөрийгөө илэрхийлэх, бичих, унших, бодох, тооцоолох чадварыг тогтооход оршино.

Эдгээр шалгалт нь хүүхдийг сургуульд тэнцэх үү? үгүй юу? гэдгийг шалгаж байгаа хэрэг биш, харин багш хичээл заах хүүхдүүдээ ямар онцлогоор, хэдэн бүлэгт, хэрхэн хуваах вэ? гэдгийг л тодруулахад туслана. Дээрх шалгалтыг хичээлийн жилийн эхэнд авахаас гадна, явц дунд, үе үе авч хүүхдүүдийн хөгжилд дүн шинжилгээ хийж, дараагийн асуудлуудыг зохицуулахад хэрэгтэй.

Нийслэлийн БЗД-ийн НТБТ-ийн холимог бүлгийн бага ангийн суралцагчдын түвшин тогтоох шалгалтын жишээ:

Унших чадвар:

Түвшин I /10 хүртэл оноо/

- ✓ Өгсөн үсгүүдийг нэрлэх
- ✓ Зургийг тохирох үгтэй нь холбох /3 хүртэлх үетэй үгс өгнө, даалгавар бүр 2 оноо/

Түвшин II /15 хүртэл оноо/

- ✓ Зургийг тохирох өгүүлбэртэй холбох
- ✓ Дараах өгүүлбэрийг уншаад асуултад хариулах /даалгавар бүр 3 оноо/

Түвшин III /20 хүртэл оноо/

- ✓ Өгөгдсөн эхийг уншаад, хариултуудаас зөвийг сонгох /хариу нь уншсан эхээс шууд олдохоор байна/
- ✓ Зааврыг уншаад түүний дагуу гүйцэтгэх үйл ажиллагааны зөв дарааллыг олно. /даалгавар бүр 4 оноо/

Түвшин IV /25 хүртэл оноо/

- ✓ Өгөгдсөн эхийг уншаад, хариултуудаас зөвийг сонгох /хариулт нь уншсан эхээс шууд олдохоор байна/
- ✓ Өгөгдсөн эхийг уншаад амьдралдаа шууд хэрэглэх боломжтой



зүйл байгаа эсэх, түүнийг яаж хэрэглэх тухай, байхгүй бол
яагаад гэдгийг товч тайлбарлах /даалгавар бүр 5 оноо/

Бичих чадвар:

Түвшин I /10 хүртэл оноо/

- ✓ Дармал үгийг бичмэлээр бичих
- ✓ Өөрийнхөө болон гэр бүлийнхээ хүмүүсийн нэрсийг бичих
- ✓ Зураг дээрх зүйлсийн нэрийг бичих /3 хүртэл үетэй үгс өгнө, даалгавар бүр 2 оноо/

Түвшин II /15 хүртэл оноо/

- ✓ Өгүүлбэрүүдийг хуулан бичих (1 мин)
- ✓ Өөрийнхөө тухай асуултад хариулж бичих

Түвшин III /20 хүртэл оноо/

- ✓ Зургуудад тохирох өгүүлбэр зохион бичих
- ✓ Намтраа бичих

Түвшин IV /25 хүртэл оноо/

- ✓ Өргөдөл, албан захидал гэх мэтийг бичих
- ✓ Сонинд мэдээ, эсээ бичих

Бодох чадвар:

Түвшин I /10 хүртэл оноо/

- ✓ Орхигдсон тоог нөхөж хэлэх
- ✓ Бичгээр өгсөн тоог цифрээр илэрхийлэх (3 хүртэлх оронтой тоо өгнө. Даалгавар бүр 2 оноо)

Түвшин II /15 хүртэл оноо/

- ✓ Тэмдгүүдийг тайлбарлах
- ✓ Дараах жишээнүүдийг бодох /1000-ын дотор нэмэх, хасах/
- ✓ Бодлого бодох /2 үйлдэлтэй/

Түвшин III /20 хүртэл оноо/

- ✓ Жишээнүүдийг бодох /10000-ын дотор нэмэх, хасах, 2 оронтой тооны 4 үйлдэл/
- ✓ Бодлого бодох /4 үйлдэлтэй/

Түвшин IV /25 хүртэл оноо/

- ✓ Жишээнүүд бодох /3 оронтой тооны 4 үйлдэл/
- ✓ Бодлогыг бодох /4-өөс дээш үйлдэлтэй/



- ✓ Өрхийнхөө орлого, зарлагын тооцоо хийх
- ✓ Өгсөн графикийг тайлбарлах

Дүгнэх заавар:

Гүйцэтгэх даалгаврын хүнд, хөнгөнөөс шалтгаалан тус бүрт өгөх оноо өөр өөр байна. Ярих чадварыг багш өөрөө өнгө, дүрс ялгуулах, гэр бүлийнх нь тухай асуух зэргээр шалгаад оноо өгнө. Онооны нийлбэр дүнгээр:

20–30 оноо-I түвшин

31-45 оноо-II түвшин

46–60 оноо-III түвшин

61-75 оноо-IV түвшин гэж тус тус тодорхойлж болно.

Бүлэг зохион байгуулалт: Түвшин тогтоосон шалгалтын дүнд тулгуурлан бүлэг зохион байгуулна. Хэрвээ 20 хүүхэд шалгахад 5 нь I түвшин, 6 нь II түвшин, 9 нь IV түвшинд байсан бол гурван түвшний суралцагчаас бүрдсэн холимог бүлэг болно. Гэхдээ бүлгүүд суралцаж байгаа байдлаасаа хамаарч, явц дунд өөрчлөгдөж болно. Түвшин тогтоох шалгалт зарим үед хүүхдийн үнэлгээг зөв гаргаагүй байж болох тул багшийн ажиглалт бас чухал үүрэг гүйцэтгэнэ. Суралцагчид гарах ахиц, хөгжил, дэвшлээс хамааран сургалтын зорилго, төлөвлөгөө өөрчлөгдөж байна.

Хичээлийн хуваарь: Дүйцсэн хөтөлбөрөөр бага боловсрол олгох сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдэд танхимын болон бие даан суралцах хэлбэрийг хослуулах, гэрийн сургалтаар зохион байгуулж болно. Аль хэлбэрийг сонгож байгаагаас хамаарч хичээлийн хуваарийг ялгаатай хийнэ. Хичээлийн хуваарийг хийхэд баримтлах гол зүйл бол бага боловсролыг дүйцүүлэн эзэмшүүлэх үлгэрчилсэн төлөвлөгөө гэдгийг санах хэрэгтэй. Мөн хичээлийн хуваарийг хийхэд анхаарах нэг зүйл бол тухайн цаг дээр нэг ангид, түвшин бүрт өөр өөр хичээл заах, эсвэл, нэг хичээлийг өөр өөр түвшинд заах эсэхийг урьдчилан төлөвлөж шийдэх явдал юм.

Хичээлийн төлөвлөгөө: ХБ-ийн сургалтыг үр дүнтэй явуулахад багшийн ээлжит хичээл бүрийн төлөвлөгөө чухал үүрэгтэй. Хичээлийн төлөвлөгөөг боловсруулахад дараах шаардлагыг тавина:

- Бүлэг бүрийн зорилго тодорхой байх
- Зорилгоо биелүүлэхийн тулд багш, суралцагчид ямар үйл ажиллагааг, ямар дарааллаар гүйцэтгэх



- Тухайн хичээл дээр суралцагч бүр өөр өөрийнхөө хэмжээнд мэдлэг бүтээж, нэг минутыг сул өнгөрөөхгүй байх
- Хичээлийн үр дүнг хэрхэн үнэлэх зэргийг тусгасан байна.

Цаг	Өдөр				
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1.	Монгол хэл (I, II, III)				
2.	I. Монгол хэл II. Математик III. Хүн–Орчин				
3.	I. Дүрслэх урлаг II. Технологи III. Математик				
4.	Математик (I, II, III)				

Хичээлийн зохион байгуулалт: Түвшин бүрийн суралцагчдын онцлогийг харгалзан хийсэн хичээлийн төлөвлөгөө, сургалтын материал бэлэн болсны дараа хичээлийг дараах зүйлсийг анхааран зохион байгуулна:

- Төлөвлөсөн хичээлийг явуулах анги танхимыг сонгоно.
- Хүүхэд бүрийг сургалтад чөлөөтэй оролцох сэтгэл зүйн орчинг бүрдүүлнэ.
- Хүүхдийн тулгамдсан асуудлыг шийдэхэд багш туслахад бэлэн байна.
- Бүлгээр ажиллах үед хүн бүрийн оролцоо жигд байгаа эсэхэд хяналт тавина.
- Гүйцэтгэж буй даалгавар нь суралцагчдын чадварт тохирсон эсэхийг ажиглана.

Хэрвээ тохиромжгүй байвал түвшин болон чадварт нь тохирсон даалгаврыг сольж өгнө.

Хичээлийн үед суралцагч бүрийг бие даан мэдлэг бүтээх, мэдээлэл сонгох, цуглуулах, боловсруулахад сургах ёстой гэдгийг багш онцгой анхаараарай.

Үнэлгээ: Холимог бүлгийн сургалтын үнэлгээг хийхэд стандарт болон стандарт бус үнэлгээний хэлбэрийг ашиглахаас гадна суралцагчдын бүтээл, бүтээлийн сан, мэтгэлцээн, уралдаан тэмцээн зэрэг олон хэлбэрийг ашиглаж болно.



Үнэлгээнд дараах шаардлага тавигдана:

- Тодорхой нэг үйл гүйцэтгэхэд явцуу биш, үйлийн тодорхой нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжихэд хадгалагдан баяжиж, бүтээлчээр хөгжих үйлийн баримжааг үнэлнэ.
- Оюун ухааны хөгжлийг үнэлнэ. Мэдлэг чадвар, арга барилаа ашиглан шинэ мэдлэг бүтээх, тулгарсан асуудлыг шийдэх арга замыг олох чадвар болно.
- Үнэлгээ зөвхөн суралцагчийн мэдлэг, чадвар, оюуны хөгжлийн түвшинг тогтоох төдийгүй үнэлгээний үр дүнгээс дүгнэлт хийж, сургалтын үр дүнг дээшлүүлэх, багш, суралцагчийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэнэ.
- Багш боловсруулсан жишиг даалгавраа урьдчилан туршиж найдвартай шалгах хэмжээнд хүрсний дараа нийтэд хэрэглэнэ.

ДЭД СЭДЭВ 2.2. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨЛТ

ЗОРИЛГО	Холимог бүлгийн сургалтын ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, төлөвлөлт хийж сурах
ХУГАЦАА	2 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Мэдлэгийн түвшин ялгаатай тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийг хийдэг, хэрэглэдэг болно.
АРГА ЗҮЙ	• Дадлага ажил • Оролцооны арга • Хэлэлцүүлэг • Багаар ажиллах арга • Эвлүүлгийн арга

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. Холимог бүлэгт заах хичээлийн загвар ашиглан ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах

Хүрэх үр дүн: Ээлжит хичээлийн хөтөлбөрийг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн онцлогийг харгалзан боловсруулж, өөрийн сургалтад хэрэглэдэг болно.

Зарцуулах хугацаа: 40 мин

2. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй анги, бүлэг зохион байгуулалтын



зураглал гаргах

Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн онцлогт тохируулан анги, бүлгийн зохион байгуулалтыг хийдэг болно.

Зарцуулах хугацаа: 30 мин

3. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн хичээлд ашиглах хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, туршлага хуваалцах

Хүрэх үр дүн: Өөрийн нөөц, бололцоог ашиглан суралцагчдын онцлогт тохирсон хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэж, хэрэглэдэг болно.

Зарцуулах хугацаа: 40 мин

4. Хичээлийн дүгнэлт-хэлэлцүүлэг 10 мин

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. Дэлгэц цаас
2. Скоч
3. Маркер /самбар, цаас/
4. Зурагт үзүүлэн
5. Сурах бичиг /Математик, Монгол хэл, Дүрслэх технологи /
6. Багшийн ном
7. Модуль

ДААЛГАВАР:

№1. Холимог бүлэгт заах хичээлийн загвар ашиглан ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулна. Багш оролцогчдыг 3 багт хувааж даалгавар бичсэн бүлгийн цаасыг тараан зааварчилгаа өгнө:

- **1-р багт** /багшийн бэлтгэсэн загварын дагуу дадлага ажил хийх/ 4, 5-р ангийн түвшинд "Математик"-ийн хичээлийг өөр өөр сэдвээр,
- **2-р багт** /багшийн бэлтгэсэн загварын дагуу дадлага ажил хийх/ 2, 4-р ангийн түвшинд "Монгол хэл"-ний хичээлийг нэг сэдвээр,
- **3-р багт** /багшийн бэлтгэсэн загварын дагуу дадлага ажил хийх/ 1, 2, 3-р ангийн түвшинд "Дүрслэх технологи"-ийн хичээлийг өөр өөр сэдвээр холимог бүлэгт заах ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулна.



1-р багт өгөх материал

Анги, бүлэг	4-р анги		Хугацаа	Арга зүй	5-р анги		Хугацаа	Арга зүй
Ээлжит хичээлийн сэдэв								
Зорилго								
Зорилт								
Сэдэлжүүлэлт								
Мэдлэг бүтээх	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	40 мин		Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	40 мин	
Шинэ мэдлэг олгох								
Мэдлэг бататгах								
Дүгнэлт								
Гэрийн даалгавар								

2-р багт өгөх материал

Түвшин	2-р анги	Багшийн		4-р анги	Арга зүй
	Суралцагчийн үйл ажиллагаа	чиглүүлэг болон цагийн нягтрал		Суралцагчийн үйл ажиллагаа	
Сэдэв					
Зорилго	Нэгдсэн зорилго /1 минут/				
Зорилт		1 мин	1 мин		
Мэдлэг бүтээх		15 мин	15 мин		
Шинэ мэдлэг		10 мин	10 мин		
Бататгал		10 мин	10 мин		
Дүгнэлт	Нэгдсэн дүгнэлт /2 минут/				
Гэрийн даалгавар		1 мин	1 мин		



3-р багт өгөх материал

Анги бүлэг	1-р анги	2-р анги	3-р анги
Сэдэв			
Зорилго			
Зорилт			
Мэдлэг бүтээх			
Арга зүй			
Шинэ мэдлэг			
Арга зүй			
Бататгал			
Арга зүй			
Дүгнэлт			
Арга зүй			
Гэрийн даалгавар			

№2. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн онцлогийг харгалзан анги, бүлэг зохион байгуулалтын зураглал хийнэ. Оролцогчдыг 3 баг болгон хуваана. Баг бүрт бүлгийн ажлын цаас, маркер, даалгавар бичсэн хуудсыг тараан өгнө.

1-р багт: Гурван түвшний ангид олон самбар,

2-р багт: Хоёр түвшин бүхий ангид нэг самбар,

3-р багт: Гурваас дээш бүлэг бүхий ангид самбар, ширээ, суудлыг байрлуулах схем зураглал хийх.

Баг бүр өөрсдийн хийсэн схем зураглалыг тайлбарласны дараа багш анги, бүлэг зохион байгуулалтын талаар РР ашиглан мэдээлэл хүргэнэ.

№3. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлгийн хичээлд ашиглах хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх дадлага ажил хийнэ. Багш бэлтгэсэн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үзүүлж, түүний төрөл, онцлог, тавигдах шаардлагыг тайлбарлана:

- Цахим хичээл:
 - үзэх
 - сонсох



- 3D ухаалаг карт буюу APP
- Биет үзүүлэн:
 - Олон хувилбарт
 - Харааны бэрхшээлтэй суралцагчдад ашиглах хэрэглэгдэхүүн



Багшид өгөх зөвлөмж:

Багш суралцагчдын ялгаатай түвшин, тусгай хэрэгцээт суралцагчийг тооцон сурагч нэг бүрийн оролцоог хангах, хөгжүүлэх, сонирхол татахуйц, өөрөө бие даан ажиллах боломжтой мөн олон агуулгыг багтааж чадахуйц бусад хичээлд хөрвүүлж ашиглагдахаар хэрэглэгдэхүүнийг сонгон авч үзүүлнэ.

№4. Хичээлийн дүгнэлт:

1. Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт ээлжит хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад тэдний мэдлэгийн түвшин, хэрэгцээ, чадвар, нас сэтгэхүйн онцлог, эрүүл мэндийн байдлыг харгалзан боловсруулна.
2. Холимог бүлэгт ээлжит хичээлийг зохион байгуулахад тусгай хэрэгцээт суралцагч бүрийн онцлогийг урьдчилан тооцож анги, бүлгийн төлөвлөлтийг хийж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ.

МЭДЭЭЛЭЛ 1. Ээлжит хичээлийн хөтөлбөр


2, 4, 5-р ангийн холимог бүлгийн “Математик”-ийн ээлжит хичээлийн хөтөлбөр

Анги	2-р анги	4-р анги	5-р анги
Бүлэг сэдэв	Тоо тоолол		
Ээлжит хичээлийн сэдэв	Дүрс ба биетийг таних	Талбайг хэмжих	Энгийн бутархайг жиших
Зорилго:	Дүрс биетийг ялган таньж, дүрсээр биет үүсгэнэ.	Тэгш өнцөгтийн урт өргөнийг хэмжиж, талбай ба периметрийг олж сурна.	Ахуй амьдралдаа аливаа зүйлийг энгийн бутархайгаар илэрхийлж, жишиж, харьцуулж сурна.



Зорилт:	➤ Дүрсийн орой ба талыг таньж мэдэх ➤ Дүрсээр биет бүтээх ➤ Тэгш өнцөгтийн талбай ба периметрийг томьёогоор олох ➤ Мэдлэгээ ахуй амьдралд хэрэглэх ➤ Ижил хуваарьтай, ижил хүртвэртэй бутархайг жиших ➤ Энгийн бутархайг тоон шулуун дээр тэмдэглэж, жиших
Хичээлийн бэлтгэл /2 минут/	Багш суралцагчдыг түвшнээр нь баг болгон суулгана. Баг тус бүрийн ширээн дээр хөтчийг байрлуулна. 2-р анги ажлын хуудас, 4-р анги эргүүлдэг хөтөч, 5-р анги цахим хөтөч ашиглана. Сурагчидтай мэндэлнэ. Хичээлийн дэгийг танилцуулна.
Сэдэлжүүлэлт /5 минут/	Zeem Zoom farmer. Cartoons for children.mp4 Бичлэг үзүүлж /анги нийтэд/ дараах асуултыг тавина. - Энд юуны тухай гарч байна вэ? - Эхлээд яасан бэ? дараа нь юу гарав? - Төгсгөлд нь яасан бэ? - Та нар энэ бүхнийг хийж чадах болов уу? гэж асуудал дэвшүүлэн ярилцана. - За тэгвэл эх дэлхийгээс хүүхдүүд та нарт захиа илгээжээ гэж хэлээд баг тус бүрт захиаг өгч сэдэлжүүлнэ. -
Хичээлийн зорилго, зорилттой танилцана. /3 минут/	Баг тус бүр өөрсдийн захиаг задлан даалгавраа авна. Захидлын дугтуйн дотор биет зүйл, захидал, хичээлийн зорилго, зорилт бичсэн цаас байна. 2, 4, 5-р ангиуд захиаг нээгээд нэгэн биет зүйлийг гарган авч тухайн биет зүйлсээр багийн нэрийг өгч хананд байрлуулна.




	2-р анги-нар баг Суралцагчид: Захидлыг нээн унших: <i>Сайн байцгаана уу? Байгаль дэлхий нь та нартаа дараах даалгаврыг өгч байна.</i> <i>Дүрс ба биетийг таньж эх дэлхийтэйгээ танилцаарай.</i> <i>Амжилт хүсье!</i>	4-р анги-навч баг Суралцагчид: Захидлыг нээн унших: <i>Сайн байцгаана уу? Хүүхдүүд ээ! Байгаль дэлхий нь та нартаа дараах даалгаврыг өгч байна.</i> <i>Талбайг хэмжиж, ногооны хүлэмж бүтээгээрэй.</i> <i>Амжилт хүсье!</i>	5-р анги-усны дусал баг Суралцагчид: Захидлыг нээн унших: <i>Сайн байцгаана уу? Хүүхдүүд ээ! Байгаль дэлхий нь та нартаа дараах даалгаврыг өгч байна. Талбайг хувааж, хүнсний ногоо тарих даалгаврыг өгч байна.</i> <i>Амжилт хүсье!</i>
Хөтөч хэрхэн ашиглаж хичээл сургалтад оролцох зөвлөмж өгнө. /2 минут/	Ажлын хуудасны зааврын дагуу багшийн оролцоогүйгээр даалгаврыг гүйцэтгэнэ. 	Эргүүлдэг хөтчийг ашиглан багшийн оролцоогүй гээр бие даан хичээлээ судална. 	Цахим хөтчийн дагуу бие даан хичээлээ судална. 
Хөтөч дэх даалгаврууд: Шинэ мэдлэг бүтээх /15 минут/	Даалгавар 1. Шоог орхиод тухайн дугаартай дугтуйг нээж дүрс тус бүрийг тохирох нүдэнд наагаарай.  Даалгавар 2. Ангид байгаа эд зүйлийг хараад ямар ямар дүрстэй төсөөтэй байгааг хоорондоо багаар ярилцаарай.	Даалгавар 1. Дэвтэртээ 1см талтай квадрат зураарай. Даалгавар 2. а  в Нэгж квадратаа ашиглан тэгш өнцгийн талбайг олоорой.	Даалгавар 1. Дүрс бичлэг үзэн бутархайн хүртвэр хуваари сэргээн санах Даалгавар 2. <i>Ногооны талбайг хэмжиж 6 тэнцүү хэсэгт хуваа. Хуваасан хэсгийнхээ</i> • $\frac{3}{6}$ хэсэгт төмс • $\frac{2}{6}$ хэсэгт лууван • $\frac{1}{6}$ хэсэгт сонгино тариарай.



Мэдлэг
бататгах
/10 минут/

Даалгавар 3.

Дүрс нь орой ба талаас бүрддэг.



Багшийн туслалцааг авна.

Даалгавар 4.

Дараах дүрсийн тал оройг тоолж бичих



Даалгавар 5.

4D карт ашиглан биет дүрс үзэх / багшаас дэмжлэг авах/ Даалгавар 6. Дараах дүрсүүдийг соронзтой савх ашиглан биет дүрс болгон үүсгээрэй.



Даалгавар 3.

$$S = a \cdot b$$

2 нэгж, 3 нэгж ашиглаад яаж талбайг олох вэ? дэвтэртээ зураад хийгээрэй.

Даалгавар 4.

Бэлдэц ашиглан хүлэмж хийгээд хүнсний ногоогоо хүлэмжиндээ тариарай.



Даалгавар 5.

Сурах бичгийн 18-р хуудасны дасгал 88-ыг ажиллаарай.

Даалгавар 3.

Энгийн бутархайг нэмэх, хасах, жиших бичлэг үзэх

Даалгавар 4.

$$\frac{3}{6}, \frac{1}{6}, \frac{5}{3}, \frac{5}{2}, \frac{5}{4}, \frac{5}{2}, \dots$$

жишиж

тоон шулуун дээр тэмдэглээрэй.

Даалгавар 5.

Дараах энгийн бутархайг жишээрэй.

$$\frac{5}{3}, \frac{5}{2}, \frac{3}{4}, \frac{3}{5}, \frac{6}{7}, \frac{2}{7}$$

Даалгавар 6.

Ахуйн тооцоо хийгээрэй. Доржийнх 7 хоногт хүнсэндээ дараах ногоог хэрэглэдэг.

№	Ногооны нэр	кг	үнэ	Нийт үнэ
1	Төмс	5	1000	
2	Лууван	2	1200	
3	Сонгино	1	1500	
4	Байцаа	1	1800	



Багшид өгөх зөвлөмж: 2-р ангийн суралцагч дунд харааны бэрхшээлтэй нэг хүүхэд байгаа тул ажлын хуудсын үсгийн фондыг томруулан бичсэн байхаар төлөвлөөрэй.

Даалгавар 7.

Сурах бичгийн 27-р хуудасны №100 хийгээрэй.

Даалгавар 8.

Гэрийн даалгаварт Сурах бичгийн 28-р хуудасны №101

Даалгавар 9.

Өнөөдөр сурч мэдсэн зүйлээ ангийнхандаа хэлж өгөөрэй.

Даалгавар 6.

Хийсэн хүлэмжээ багшийн бэлдсэн хашаанд байрлуулан тавиарай.

Даалгавар 7.

Гэрийн даалгаварт сурах бичгийн 18-р хуудасны дасгал 94, 95

Даалгавар 8.

Өнөөдөр сурч мэдсэн зүйлээ ангийнхандаа хэлж өгөөрэй.

Даалгавар 7.

Сурах бичгийн 54-р хуудасны № 267, 268

Даалгавар 8.

Өгөгдсөн талбайд хуваалт хийж ногоо тариад багшийн бэлдсэн хашаанд байршуулаарай.

Даалгавар 9.

Өнөөдөр сурч мэдсэн зүйлээ ангийнхандаа хэлж өгөөрэй.



Дүгнэлт /3 минут/	Багш сурагчдаар сурч мэдэж авсан зүйлийн талаар асууж хичээлийн зорилго, зорилтын биелэлтийн талаар харилцан ярилцаж, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахын тулд бид мод ногоог ихээр тариалан, усаа хэмнэж бохирдуулахгүй байх тухай уриалгаар хичээлийг төгсгөнө.		
Үнэлгээ	Багш суралцагч нэг бүрийг баг тус бүрт хийсэн ажлын гүйцэтгэл болгоноор дүгнэнэ. 2-р ангийн сурагчдыг цэцэг 4-р ангийн сурагчдыг модоор 5-р ангийн сурагчдыг хүнсний ногоогоор тус тус үнэлж багийн үнэлгээгээр хашаан доторх орчинг бүрдүүлнэ.		
Арга зүй:	Ажиглах, мэдлэг бүтээх, таамаглал дэвшүүлэх, тунгаан бодох, багаар ажиллах, бие даан суралцах, мэдээлэл солилцох, тайлбартай дасгалын арга, турших гэх мэт бусад аргуудыг ашиглаж болно.		
Хэрэглэг- дэхүүн	Дүрс бичлэг, шоо, соронзон дүрс, 4D карт, ажлын хуудас, сурах бичиг, үнэлгээ, цавуу, бал, харандаа, өнгийн харандаа	Сурах бичиг, хүлэмжийн бэлдэц, хүлэмжний ногоо шугам, харандаа, цаасан эргэдэг хөтөч	Ногооны талбай, хүнсний ногоо, дүрс бичлэг, бал, шугам харандаа, цахим хөтөч

МЭДЭЭЛЭЛ 2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь боловсролын тусгай үйлчилгээ авах хүүхдийн сурч боловсрох үйл ажиллагааны тодорхой үе шатанд тусгагдах өөрчлөлт төлөвлөлт юм. Тус төлөвлөгөөг боловсруулахад эцэг эх, багш, шаардлагатай тохиолдолд суралцагчийн оролцоо чухал байдаг.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хугацаа нь харилцан адилгүй байдаг ба хагас жил болон бүтэн жилээр нэмэлт, өөрчлөлтийг оруулж шинэчилж болдог онцлогтой. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь олон талын асуудлыг авч үздэг. Тухайлбал, хүүхдийн өмнө нь шалгуулж байсан сорил асуумж, даалгаврын гүйцэтгэл, бие даалт, багшийн зүгээс үзүүлж байсан тусламж, дэмжлэг зэргийг эргэцүүлэн цаашид хийх ажлын зорилго, зорилтыг тодорхойлж, үйлчилгээний төрлийг (сэтгэл зүйн, хөдөлгөөний нөхөн сэргээх, хэл заслын, эрүүл мэндийн, эрх зүйн г.м.) тогтоодог.



Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг:

- тодорхойлох,
- боловсруулах,
- хэрэгжүүлэх үе шаттай явуулдаг.

Эдгээр үе шатанд багш, эцэг эх, мэргэжилтнүүд уулзаж ярилцан мэдээлэл солилцох, зөвлөн туслах үйлчилгээ авах шаардлага гардаг.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь тухайн хүүхдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Багш суралцагчийн тусгай хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрт оруулах өөрчлөлтийг хийх бөгөөд ердийн орчинд, үе тэнгийнхэнтэй сурахад ямар тусламж, үйлчилгээ шаардлагатай болох, суралцагчийн хөгжлийн түвшний байдлаар (өөртөө үйлчлэх энгийн чадвар, хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол, нийгэмшихүй, бие бялдар, хөдөлгөөн) зорилго, зорилтод хүрэх арга, замыг тодорхойлсон байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү).

МЭДЭЭЛЭЛ 3. Анги болон бүлэг зохион байгуулалтыг холимог бүлэгт ашиглах арга

Холимог бүлгийн өөр түвшний болон тусгай хэрэгцээт суралцагчдад сургалтыг нэг ангид, зэрэг явуулах хамгийн тохиромжтой хэлбэр нь бүлгээр ажиллуулах явдал юм. Холимог ангийн суралцагчдыг бүлэгт хуваарилан ажиллуулснаар багшийн ажил хөнгөрч, үүрэг өөрчлөгдөнө. Гэхдээ ямар ч нөхцөлд багш хөтлөх, чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Бүлгээр ажиллах буюу ажлын бүлэг гэдэг нь 2 ба түүнээс дээш хүнтэй, багийн гишүүд нь суралцах, туршлага гүйцэтгэж буй ажиллагааныхаа зорилгоос хамааран солигдож байдаг зохион байгуулалтын хэлбэр юм. Бүлэгт ажиллаж буй суралцагчдын үүрэг, байр суурь нь багшаас өгч буй даалгавраас хамааран ялгаатай байдаг.

Бүлгээр ажиллахад дараах зарчмыг баримтална:

- Бүлгийн гишүүн бүр бүлгийн ажилд зэрэг оролцох
- Хүн бүр өөрсдийн хийж гүйцэтгэх үүргээ ойлгож мэдэх
- Ярилцлага, хэлэлцүүлгийн үеэр суралцагчид өөд өөдөөсөө харж суух, ярилцагч болон багшийн тайлбарт анхаарлаа хандуулах, өөрийн туршлага болон сурч мэдсэн зүйлээсээ бусад нөхөдтэйгөө хуваалцах
- Бүлгийн нэг гишүүн ярьж байхад бусад нь түүнийг анхааралтай сонсох



- Бүлгийн ажлыг хэлэлцэх үед нэг нь хэтэрхий удаан ярихаас болгоомжлох /энэ нь бусад сурагчид бага ярих, ярианд бараг оролцохгүй байх байдлыг үүсгэнэ/
- Бүлгийн гишүүд санал нийлж буй эсэхээ илэрхийлж хэлж байх
- Зөв ч бай, буруу ч бай бусдын санаа бодлыг хүндэтгэж, нэгэн санаа бодолд хүрэхийн тулд харилцан ярилцах
- Гишүүд бүлгийн ахлагчийн зааврыг дагах ба ярилцлагын үеэр бичиж, тэмдэглэх ажлыг дадлага болгож энэ чадвараа зэрэг хөгжүүлэх
- Бүлгийн гишүүд ахлагч, танилцуулагчийн үүргийг ээлжлэн гүйцэтгэнэ.

Бүлгээр ажиллах нь тусгай хэрэгцээт хүүхдүүдэд ямар ач холбогдолтой вэ?

- Суралцагчид багшийн даалгаврыг гүйцэтгэх үед *сурч мэдсэнээ харилцан хуваалцах* боломжтой, хувийн чадварыг хөгжүүлэн, *найрсаг дотно харилцааг буй болгоно*. Түүнчлэн суралцагчдад илүү идэвхтэй ажиллах эрмэлзлийг төрүүлж, хариуцлагаа хүлээх, оногдсон үүрэг даалгавраа ухамсартайгаар биелүүлэх зэрэг чадвар суухаас гадна тэдний *бие даан ажиллах чадвар сайн хөгжинө*.
- Бүлгээр ажилласны үр дүнд сурагчид бусадтай харилцах, асуулт тавих, хариулах, эргэцүүлэн бодох, бусдын хариултад үнэлэлт өгөх зэрэг чадвар эзэмшинэ. Илүү *зоримог, идэвхтэй, өөртөө итгэлтэй байж сурна*.
- Суралцагчид бусдын санаа бодлыг сонсох, харилцан бие биеэсээ суралцах боломж бүлгээр ажиллах үед л олдоно. Ингэснээр *тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд илүү бүтээлчээр хандах* чадвар, дадал сууна.
- Бүлгээр ажилласны үр дүнд ичимхий бүрэг хүүхэд *нээлттэй, өөртөө итгэлтэй болох* боломж бүрдэн бусадтай харилцах, танин мэдэх чадвар нь дээшилнэ.
- Тусгай хэрэгцээт хүүхдүүд *нийгэмших*, анги хамт олон, найз нөхөдтэй, багштай, сургуультай болно.
- Багш бүлгээр ажиллах үед суралцагчдыг ажиглах, тэдний хувийн онцлог, хэрэгцээг мэдсэнээр цаашид авах арга хэмжээг тодорхойлох боломжтой.



Анги ба бүлгээр ажиллахад гарах ялгаа:

Ангиар ажиллах үед	Бүлгээр ажиллах үед
- Хичээл багш төвт - Багш зохион байгуулагч, манлайлагч - Багш заах сургах л үүрэгтэй - Асуудлыг ангиар хэлэлцүүлдэг, энэ үед идэвхтэй хэдэн сурагч оролцож бусад нь үлддэг.	- Хичээл сурагч төвт - Тухайн сурагч болон бүлэг өөрийн удирдлагатай - Сурагч мэдлэгээ өөрөө бүтээх, практик чадвар эзэмших үүрэгтэй - Жижиг бүлгээр хэлэлцэн шийдвэр гаргана, бүлгийн бүх гишүүд адил тэгш оролцоно.

Бүлгийн төрлүүд:

Холимог бүлэгт заах өөр өөр хичээлийн онцлог, зорилго, шинж чанар зэргээс хамааран багш суралцагчдыг жижиг бүлгүүдэд хуваарилна. Бүлгийн дараах хэлбэрүүд байж болно:

- **Анги ижил бүлэг:** Энэ нь ижил түвшинд суралцаж буй нэг ангийн хүүхдээс бүрдэнэ.
- **Өөр түвшний бүлэг:** Нэг бүлэгт өөр өөр түвшинд сурч буй суралцагчид багтана.
- **Авьяас сонирхлын бүлэг:** Сэтгэл зүй, нас, биеийн хөгжил зэрэгцээ ойролцоо суралцагчдыг нэг бүлэг болгоно.
- **Ур чадвар ойролцоо бүлэг:** Тухайн хичээлээр мэдлэг, чадварын хувьд ойролцоо суралцагчдыг нэг бүлэг болгоно.
- **Охид хөвгүүдийн бүлэг:** Зарим бүлгийг охид хөвгүүдээр ялган зохион байгуулж болно.
- **Холимог бүлэг:** Нас, анги, хүйс, сурч буй түвшний хувьд өөр өөр, тусгай хэрэгцээт суралцагч нэг бүлэг болон ажиллахыг хэлнэ.

Суралцагчдыг бүлэг болгон хуваарилах олон аргууд байдаг. Тухайлбал, тоолох, дүрс тэмдэг ашиглах, өнгөөр бүлэг болгох гэх мэт аргуудыг ашиглаж болно.



Багшид өгөх зөвлөмж:

Бүлгийн эдгээр хэлбэрүүдийн дотроос холимог бүлгийн сургалтад хамгийн өргөн ашиглагддаг нь анги ижил бүлэг болон өөр түвшний (холимог ангийн) бүлэг бөгөөд эдгээрийг хамгийн энгийн бөгөөд тохиромжтой хэлбэр гэж үздэг. Багш хичээлээ бэлдэх явцдаа бүлгийн ямар хэлбэрийг сонгох,




хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байгаа эсэх, суралцагчдын онцлогийг тооцон урьдчилан шийдсэн байна. Бүлэг болгон ажиллуулахдаа суралцагчдын хүйсийн харьцаа, эрүүл мэндийн онцлог зэргийг бодолцох хэрэгтэй.

Анги зохион байгуулах хэлбэрүүд:

Загвар 1



Загвар 2



Загвар 3



Дээрх байдлаар анги зохион байгуулалтыг хийж болно. Зохион байгуулалтыг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тусгаарлахгүй, анги бүлэгт хамт суулгаж хичээл сургалтыг зохион байгуулна. Эдгээрийг



хийж гүйцэтгэх, байрлуулах, сольж өөрчлөх зэрэгт ахлах бүлгийн суралцагчдыг татан оролцуулж байх нь багшийн ажлыг хөнгөвчлөхөөс гадна бага бүлгийн суралцагчдад үлгэр дуурайл болж, тэдэнд өөрсдөд нь сургах арга барил төлөвших, нийгэмших, өөртөө итгэх итгэлийг буй болгодог.

МЭДЭЭЛЭЛ 4. Холимог бүлэгт ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх

Холимог бүлгийн сургалтын чухал хэсэг нь сургалтын хэрэглэгдэхүүн, материалын хүрэлцээ хангамж, түүнийг боловсруулах асуудал байдаг. Сургалтын материал болон хэрэглэгдэхүүнийг олшруулах, түүний төрөл зүйлийг нэмэгдүүлэхийн тулд аль болох хямд төсөр гарын доорх материалыг ашиглах нь зөв боловч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Багш суралцагчид орон нутгийнхан өөрсдөө хийж, дахин сэлбэж болохоор байх
- Ангид болон суралцагч, тусгай хэрэгцээт хүүхдэд ашиглахад үр өгөөжтэй байх
- Хэрэглэгдэхүүнийг хийхэд хямд төсөр, энгийн байх
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, хийхэд цаг хугацаа бага зарцуулах, орон нутгаас амархан олж болох түүхий эд болон бусад гарын доорх зүйл байх хэрэгтэй.

Түүхий эд		
Байгалийн нөөц	Үйлдвэрлэлийн хаягдал	Гэр ахуйн хаягдал
<i>Ургамлын гаралтай:</i> Модны навч, үр, үндэс гэх мэт	Ашиглаж дууссан чийдэнгийн шил	Жимсний чанамлын шил,
<i>Амьтны гаралтай:</i> Арьс, яс, хайрс гэх	бусад зүйл	ундааны шил, сав, гэх мэт
<i>Эрдэс чулуулаг:</i> Шохойн чулуу, нүүрс гэх мэт		

Цахим хичээлийн хэрэглэгдэхүүн:

Сонсох: Бэлтгэсэн хичээлийг суралцагч компьютер болон хөгжим тоглуулагч ашиглан багш, эцэг эхийн оролцоогүйгээр ашиглах шийдэл.

Үзэх харах: Суралцагчийн хэрэгцээнд тулгуурлан бие даан суралцахад хөтөлдөг сургалтыг дэмжих материал.

Ухаалаг карт APP: Интернэтгүй орчинд ашиглах боломжтой, суралцагчийн танин мэдэх чадварыг хөгжүүлэх карт. Аппликейшний тусламжтайгаар:

- Сонсох
- Кино үзэх




- Дүрс амилуулах
- Эвлүүлж тоглох
- АХА мэдлэгээ бататгах
- Суралцагчдад хэрэгтэй зөвлөмж авч болно.



Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан хичээлийн хэрэглэгдэхүүн нь бие даан өөрөө гүйцэтгэх боломжтой, аюулгүй байдлыг хангасан байна. Сургалтын хэрэглэгдэхүүнийг дан ганц багш биш, суралцагчид, тэдний эцэг эх, сургуулийн сурагчдыг дайчлан хийж болно.

Зураг 1. Сорилын тест



Зураг 2. Хэрэглэгдэхүүн





ДЭД СЭДЭВ 2.3 ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

ЗОРИЛГО	- Холимог бүлгийн суралцагчдын ур чадвар, онцлог, сурлагын ахиц, цаашид үргэлжлүүлэн суралцах чадварыг үнэлэх - Суралцагчдын мэдлэгийн түвшинг үнэлэх жишиг даалгаврыг боловсруулах арга зүйд суралцах
ХУГАЦАА	2 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Холимог бүлгийн суралцагчдын суралцах чадварыг үнэлэх, тэдний танин мэдэхүйн түвшинг үнэлэх жишиг даалгаврыг боловсруулах арга зүйтэй болно.
АРГА ЗҮЙ	• Мэдлэг бүтээх • Харилцан мэдээлэл солилцох арга • Оролцооны арга • Багаар ажиллах арга • Эвлүүлгийн арга

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. Дадлага ажил №1. Холимог бүлгийн суралцагчдыг үнэлэх, дүгнэх аргыг эзэмшүүлэх

Хүрэх үр дүн: Холимог бүлэгт суралцаж буй тусгай хэрэгцээт хүүхдүүдийн онцлогийг харгалзан суралцах чадварыг үнэлдэг болно.

Зарцуулах хугацаа: 60 мин

2. Дадлага ажил №2. Холимог бүлгийн суралцагчдын танин мэдэхүйн түвшинг үнэлэх жишиг даалгавар боловсруулах

Хүрэх үр дүн: Холимог бүлэгт суралцаж буй тусгай хэрэгцээт хүүхдүүдийн танин мэдэхүйн түвшинг үнэлэх жишиг даалгавар боловсруулах туршлага эзэмшинэ.

Зарцуулах хугацаа: 60 мин

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

1. Дэлгэц цаас
2. Скоч
3. Маркер /самбар, цаас
4. Мэдээлэл
5. Зурагт үзүүлэн
6. РР



ДААЛГАВАР:

№1. Оролцогчдын тоогоор бэлтгэсэн дөрвөн өнгийн ундааны бөглөөг уутан дотроос сугалуулан 4 багт хуваана. Баг тус бүрийн ширээн дээр ажлын зааварчилгаа, цаас, маркерийг бэлтгэсэн байна. Багш оролцогчдыг сэдэлжүүлэх зорилгоор суралцагчдыг үнэлж, дүгнэдэг аргуудыг нэрлүүлж, самбарт бичнэ. Харилцан ярилцах аргаар тайлбар хийгдэнэ. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн онцлогийг харгалзан тэдний ур чадвар, сурлагын ахиц, цаашид үргэлжлүүлэн суралцах чадварыг үнэлэх талаар асуудал дэвшүүлэн шинэ мэдээллийг хүргэнэ.

№2. Холимог бүлгийн суралцагчдын танин мэдэхүйн түвшинг үнэлэх жишиг даалгавар боловсруулах дадлага ажлыг багшийн бэлтгэсэн загварын дагуу хийнэ. Оролцогчдыг 4 баг болгон хуваана:

- **1-р баг:** 4-р ангийн “Математик”-ийн нэгж хичээлийн түвшинг шалгах жишиг даалгаврыг боловсруулах (зөвийг олж дугуйлах хэлбэрийг сонгоно)
- **2-р баг:** 5-р ангийн “Монгол хэл”-ний нэгж хичээлийн түвшинг шалгах жишиг даалгаврыг боловсруулах (холимог сонголттой хэлбэрийг сонгоно)
- **3-р баг:** 2-р ангийн “Зураг технологи”-ийн нэгж хичээлийн түвшинг шалгах жишиг даалгаврыг боловсруулах (зургийг будах, наах, эвлүүлэх хэлбэрийг сонгоно)
- **4-р багт:** 3-р ангийн “Хүн ба орчин”-ны нэгж хичээлийн түвшинг шалгах жишиг даалгаврыг боловсруулах (цэгийн оронд нөхөх хэлбэрийг сонгоно)

Багийн бүлгийн ажлын танилцуулгын дараа нэгдсэн хэлэлцүүлэг хийгдэнэ.

МЭДЭЭЛЭЛ 1. Үнэлгээний зорилго

Үнэлгээ нь дараах зорилготой:

- Суралцагчдын ур чадвар, онцлог, сурлагын ахиц, цаашид үргэлжлүүлэн суралцах чадварыг үнэлэх
- Багшийн сурган хүмүүжүүлэх ур чадвар, сургалтын арга хэлбэрийг тодорхойлох, багийн үйл ажиллагааг зохион байгуулж буй байдалд дүгнэлт өгөх

Үнэлгээ нь сургалтын явц болон үргэлжлэх байдлын бүрэлдэхүүн хэсэг.



Тийм учраас таагүй уур амьсгалтай гэр бүлд амьдардаг, эрүүл мэндийн ямар нэгэн асуудалтай, сурах ангиас нас нь хэтэрсэн г.м. тусгай хэрэгцээт хүүхдүүдийг загнах, эвгүй харилцах, доромжлох, шүүмжлэхийг тэвчих хэрэгтэй. Харин ямар учраас, юунаас болоод энэ суралцагч хүнд байдалд орж байгаад багш сэтгэл зовж асуудлыг илрүүлэн шийдвэрлэж туслахад анхаарна. Суралцагчид нь холимог бүлгийн багт хуваагдан хичээллэхэд багш суралцагчдын сурлагын ахицын талаар мэддэг байх, үүнийг бие даасан түвшинд нь байнга үнэлж байх ёстой. Хичээлийн үед суралцагчдын бие даасан сургалтад зарцуулах хугацааг нэмэгдүүлж хүн бүртэй тулж ажилласнаар тэдний мэдлэгийн түвшний ахицыг нарийн хянах боломжтой. Мөн багаар ажиллах боломжийг нэмэгдүүлснээр суралцагчийн өөртөө болон бусдын ажилд өгөх хөндлөнгийн үнэлгээг сайжруулна.

Холимог бүтэцтэй ангид олон түвшний суралцагчдын сурах үйл явцын үр дүнг үнэлэх амаргүй. Иймээс багш суралцагчдад дүн тавих бус, үнэлгээ өгөхөд л анхаарах ёстой. Мэдлэгийн олон түвшинтэй суралцагчидтай ажиллаж буй холимог бүлгийн багш суралцагч бүрийн ахиц дэвшлийн талаар ямар мэдээлэл цуглуулах, хэрхэн цуглуулах аргаа өөрөө сонгож шийднэ. Суралцагч тус бүрийн үнэлгээ бүлэг хоорондын харьцуулах үнэлгээнээс чухал үүрэг гүйцэтгэдэг. Мэдлэгийн түвшин ижил суралцагчдыг харьцуулан үнэлэх асуудал ач холбогдолтой ч нээлттэй, ил тод байх нь зарим үед сөрөг талтай байдаг.

Холимог бүлгийн суралцагчид бусдын адил төвөгтэй үе шатуудыг дамжин тасралтгүй суралцдаг. Сургалтын уян хатан агуулгыг суралцагч өөрийн мэдлэгийн түвшин, сурах чадвар, арга барил, онцлогт тохируулан эзэмшиж, өөрсдийнхөө хэмжээнд харилцан адилгүй ч ахиж дэвшиж байдаг. Багш суралцагчдын зөвхөн мэдлэгийн (жишээ нь, унших бичих чадвар) түвшинг үнэлэх бус тэдний сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийг ч анхаарах хэрэгтэй. Ангид аливаа ажил үүрэг гүйцэтгэхэд оролцох, найзуудтайгаа хуваалцах, өөрсдийн ажлыг зохион байгуулах хүсэл сонирхол зэрэг суралцагчдын бусад талын хөгжлийг үнэлж, дэмжихийг мартаж болохгүй. Гэхдээ суралцагчдын хоорондын харилцаа, үнэт зүйл, зан байдлыг хэмжиж тогтоон үнэлэх асуудал амаргүй.

Суралцагчдын үнэлгээг тухайн багшийн чадвараас хамааран өдөр тутам эсвэл тодорхой хугацаанд тэдний сургалтын хэлбэрээс хамааран давтамжтай хийж болно. Үнэлгээнийхээ зорилгыг ямагт бодож, заах болон сурах үйл явцын дөрвөн тохиолдол бүрт төлөвлөж байх хэрэгтэй.



Багш шинэ сэдэв үзэх:

- **Хичээлийн өмнө**, суралцагчид энэ сэдвээр ямар ойлголт, туршлагатай байгааг тодорхойлох; тэдэнд ямар шинэ мэдээлэл шаардлагатай байгааг мэдэж авах
- **Хичээлийн явцад**, суралцагчид зааж буй хичээлийг ойлгож байгаа үгүйг тодруулах; хэрвээ анги бүхэлдээ эсвэл ганц нэг суралцагч асуудалтай байгааг мэдвэл хичээлийн явцад залруулах
- **Хичээлийн төгсгөлд**, дараагийн сэдэв рүү шилжихээс өмнө суралцагчдын чадварыг үнэлэхдээ нэмэлт давталт шаардлагатай эсэхийг тогтоож, өөрийн заах аргын талаар санал хэлэх боломжийг олгох хэрэгтэй.

Харин **улирал эсвэл хичээлийн жилийн эцэст**, суралцагчид сурсан бүхнээ хэрэглээ болгож чадсан эсэхийг үнэлэх цаг бөгөөд үнэлгээний давтамжтай үйл явцыг хэрэглэх ёстой. Энэ үйл явц суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэгийг тодорхойлохоос эхэлнэ.

Давтамжит үнэлгээний явц





МЭДЭЭЛЭЛ 2. Холимог бүлгийн суралцагчдыг үнэлэх арга

Холимог бүлгийн суралцагчдыг үнэлэх хэд хэдэн арга хэрэглэж болно:

- *Суралцагч тус бүрийн үнэлгээ* - тестээр суурь мэдлэгийн түвшин тогтоох, даалгавар, бусад ажлыг шалгах, багшийн хянах хуудсаар суралцагч нэг бүрийн үйл ажиллагаанд оролцож буй байдал болон бичгийн ажлыг хянах, тэдний хөгжлийн талаарх тэмдэглэл хөтлөх зэрэг багтана. Суралцагч болгонд хувийн хэрэг хөтлөх нь тэдний талаар тогтмол судалгаатай байж, мэдлэгийн түвшинг байнга үнэлэх эх сурвалж болдог.
- *Бүлгийн үнэлгээ* - бүлгийн гишүүд хэрхэн баг болж ажиллаж байгаа, хэн нь удирдаж, хэний оролцоог урамшуулах шаардлагатай байгаа, хэн бусдыгаа оролцоход саад болж байгааг ажиглан, тухайн бүлгийн ажлын үр дүнд суралцагч бүрийн оруулсан хувь нэмрийг дүгнэж, үнэлнэ.
- *Өөрийн үнэлгээ* - суралцагч тус бүрийн мэдлэгийн түвшинг үнэлснээр ямар хичээлд, ямар нэмэлт тусламж шаардлагатай байгааг тогтоон тусгай даалгавар өгч, сургалтын чанарыг сайжруулна.
- *Суралцагч суралцагчаа үнэлэх үнэлгээ* - үе тэнгийн сурагч-багшаар суралцагчдыг дүгнүүлэх, багш тэдний хамтын ажиллагаанд үнэлгээ өгнө. Асуудалтай нөхцөлд шалтгааныг тодруулж, шаардлагатай бол үе тэнгийн сурагч-багшийг солих зэргийг шийдвэрлэнэ.

Үндсэн хичээлийн агуулгаар мэдлэгийн түвшинг тодорхойлж үр дүнг хэмжихийн хажуугаар дараах дадал, харилцаануудыг үнэлж болно:

- Тайлагнах, ярих, зураг зурах, зураг унших, газрын зураг бөглөх гэх мэт
- Сонсох, ярих, санаагаа илэрхийлэх
- Биеийн хөдөлгөөн, утга уянгын хэлбэр гэх мэтээр өөрийгөө илэрхийлэх
- Шийдвэр гаргах, логик холболт хийх
- Сониучирхаж асуух, асуулт тавих
- Анализ хийх, дүн шинжилгээ хийх
- Хийнгээ суралцах
- Боломж муутай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй нөхөртөө сэтгэл зовниж, мэдрэмжтэй хандах
- Бусдын өмнө хариуцлага хүлээх, мэдлэгээ хуваалцах, хамтарч ажиллах г.м.

Суралцагчийг үнэлэхээс гадна багш өөрийн ур чадвар, стратеги, арга



барил зэрэгт байнга дүгнэлт хийж, үнэлгээ өгснөөр хичээлийн болон сэдвийн төлөвлөгөө, сургалтын материал боловсруулах, суралцагчдад үүрэг даалгавар хуваарилах, заавар зөвлөгөө өгөх ба сургалтын зохион байгуулалт, чанар, суралцагчдын мэдлэгийн түвшин, үйл ажиллагаанд эцэг эх, гэр бүлийн гишүүдтэй хамтарч хөндлөнгийн үнэлгээг хийнэ. Багшийн сургалтын талаарх бусад эх сурвалжийн үнэлгээ мөн чухал. Тухайлбал, ахлах багш, хичээлийн эрхлэгч, бусад багш нар, суралцагчдын албан бус үнэлгээ г.м.

Холимог бүлгийн суралцагчдын сурлагын ахицыг дараах 3 аргаар шалгаж болно.

1. Элсэлтийн шалгалт
2. Энгийн шалгалт
3. Тогтмол шалгалт

Элсэлтийн шалгалт: Хичээлийн жилийн эхэнд болон гэрээр, бие даан суралцсан, удаан хугацаагаар өвдсөн, тусгай хэрэгцээ зэргийг харгалзан сурлагын ахицад өөрчлөлт гарсан эсэхийг тодорхойлно. Энэ нь суралцагчдын аль бүлэгт дэвшин сурах түвшинг тодорхойлж байдаг учраас шийдвэрлэх шалгалтад тооцогдоно.

Энгийн шалгалт: Энэ шалгалтын хэлбэрийг өдөр тутмын, 7 хоногийн, сарын гэх мэтчилэнгээр зохион байгуулан шалгах бөгөөд багшийн зааж байгаа сургалтын арга, сургалтын явцын үр дүнг тодорхойлдог. Үүнийг нэгж болон ээлжит хичээлийн дараа авна. Мөн урвуу хэлбэрээр суралцагчид хэр сурч байгаа, ямар хичээлийг ойлгохгүй, юуг дутуу ойлгож байгааг мэдэхэд чиглэгддэг. Шалгалтын үр дүнд багш арга зүй, сургалтын хэлбэрээ өөрчлөн төлөвлөх, дутагдлаа олж мэдэх, суралцагчдад тавих анхаарал халамжаа нэмэгдүүлэх, орхигдсон, дутагдалтай зүйлийг нөхөн олгох зэргээр өөртөө шүүмжлэлтэйгээр ханддаг.

Тогтмол шалгалт: Энэ нь энгийн шалгалтын хугацаанаас богино байх ба 1 юм уу хэд хэдэн бүлэг сэдэв үзсэний дараа, улирлын эсвэл жилийн эцэст авна. Жилийн эцэст суралцагчдын мэдлэгийн түвшинг шалгаж сул сурлагатны алдсан алдааг олж, тогтоох, бие даан сурах хугацаанд өгөх даалгаврыг тодорхойлж нэмэлт даалгаврыг төлөвлөнө.

Сэдвийн шалгалт: Шалгалтын материалыг тусгай цаасан дээр хийх бөгөөд суралцагчдыг дүгнэх олон хэлбэртэй байж болно. Үүнд: зохион бичлэг хийх, түүх бичих, холимог бодлогууд бодох, асуултад хариулах гэх мэт. Шалгалтын дараа дүнгийн байдлыг багш тайлбарлаж өгөх ба оноогоор дүгнэх нь илүү тохиромжтой.



Бодлого, тест: Тестээр шалгалт авах, бодлого бодуулах зэрэг нь холимог бүлгийн сургалтад их тохиромжтой байдаг. Даалгавар дараах хэлбэртэй байж болно:

- Зөв бурууг олж дугуйлах
- Холимог сонголттой
- Цэгийн оронд нөхөх
- Үг болон холбоо үгийг хослуулан асуултууд тавих
- Хичээлийн агуулгад нийцүүлэн зургийг будах, наах, эвлүүлэх зэрэг.

Өөрийгөө болон бусдыг шалгах: Суралцагч өөрөө өөрийгөө шалгаж дүгнэх асуудал сургалтад их чухал бөгөөд мэдлэгийн түвшний цар хүрээг нэмэгдүүлэхэд (багшаас тусламж авахад) тустай. Тарааж өгсөн материал дээр ажилласны дараа өөрийн алдааг олж, юуг дутуу ойлгож хийснээ багшаас асууж тусламж авна. Бие биеэ шалгах явцад баг, бүлэг хооронд ажлаа солилцон шалгах, гишүүдийн түвшинг өөрсдөө тодорхойлохоос гадна хамт олны эв нэгдэл сайжрах ач холбогдолтой. Энэ аргууд суралцагчдад үйл ажиллагааг идэвхтэй сонирхолтой болгох, сурлагын түвшинг дээшлүүлэх, ангийн уур амьсгалыг дулаан болгодгоороо онцлогтойгоос гадна багш суралцагчаас мэдээлэл авах боломжтой.

Ердийн хичээл дээр шалгах: Багш суралцагчдын дунд “Өнгөрсөн хичээлийг ойлгосон уу?, Шинэ хичээлд бэлтгэсэн үү?” гэх зэрэг асуулт тавьж, тэднээс товч хариулт авснаар хичээл эхэлнэ. Энэ аргыг хичээлийн өмнө болон дараа тухайн өдрийн хичээлийг ойлгосон эсэхийг мэдэх зорилгоор хэрэглэнэ. Хэрвээ ийм асуулт тавих цаг хугацаа хязгаарлагдмал бол нөхцөл байдал бүрдсэн үед хэрэглэнэ.

Сул сурлагатай сурагчдад туслах: Сул сурлагатанг хэрхэн олж тогтоох вэ?

- Юуны өмнө багш тухайн суралцагчийн сурлагад ахиц гарахгүй, хичээлдээ муудаж байгааг илрүүлнэ.
- Шалтгааныг илрүүлсний дараа түүнтэй ярилцлага хийнэ.
- Сул сурлагатай суралцагчид сурахын утга учрыг сайн тайлбарлан ойлгуулна.
- Бие даан сурах арга барилд сургах, цаашид бие даан хичээллэхэд анхаарна.
- Нэмэлт даалгаврыг багш бодлоготой өгөх ба бусад багийн суралцагчид хийж байсан зүйлээс авч хэрэглэнэ.
- Багш тухайн суралцагчид байнга анхаарал, хяналт тавихаас гадна нэмэлт даалгавар өгч алдааг өөрөөр нь олуулж,



тайлбарлуулна.

Суралцагчдын шалгалтыг тэмдэглэх: Суралцагч бүрийн шалгалтын дүнг оноогоор илэрхийлэх ба авсан оноог хувийн сурлагын дэвтэрт бичнэ. Харин сул сурсан суралцагчдын дүнг дэвтэрт бичих хэрэггүй. Энэ нь тэдэнд айдас түгшүүр үүсгэж болох бөгөөд улмаар сурах сонирхлыг бууруулах сөрөг талтай. Ийм тохиолдолд багш нэг суралцагчид хэд хэдэн тэмдэглэгээ хийнэ.

Үнэлгээ

Холимог бүлгийн үнэлгээг хийхэд стандарт болон стандарт бус үнэлгээний хэлбэрийг ашиглахаас гадна суралцагчдын бүтээл, бүтээлийн сан, маргаан, мэтгэлцээн, уралдаан, тэмцээн зэрэг олон хэлбэрийг ашиглаж болно. Үнэлгээнд дараах шаардлага тавигдана:

1. Тодорхой нэг үйл гүйцэтгэхэд тохирсон явцуу алгоритмыг биш үйлийн тодорхой нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжихэд хадгалагдан баяжиж, бүтээлчээр хөгжих үйлийн баримжааг үнэлнэ.
2. Оюун ухааны хөгжлийг үнэлнэ. Оюун ухааны хөгжлийн шалгуур нь сурах ерөнхий арга барилыг (үйлийн баримжааг) өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх, мэдлэг, чадвар, арга барилаа ашиглан шинэ мэдлэг бүтээх, тулгарсан асуудлыг шийдэх арга замыг олох, шийдэх чадвар болно.
3. Үнэлгээ зөвхөн суралцагчийн мэдлэг, чадвар, оюуны хөгжлийн түвшинг тогтоох төдийгүй үнэлгээний үр дүнгээс дүгнэлт хийж, сургалтын үр дүнг дээшлүүлэх, багш суралцагчийн хамтын үйл ажиллагааг дэмжихэд чиглэнэ.
4. Багш боловсруулсан жишиг даалгавраа урьдчилан туршиж, найдвартай шалгах хэмжээнд хүрсний дараа ангид хэрэглэнэ.

МЭДЭЭЛЭЛ 3. Холимог бүлгийн суралцагчдыг үнэлэх жишиг даалгавар

БЗД-ийн АБ-НТБТ

4-р ангийн “Математик”-ийн хичээлийн түвшин тогтоох шалгалтын материал

3-р улирал

1. Илэрхийллийн утгыг олоорой.

3636:(872-868)+14917-136×29



2. Дараах тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.

а. 375 б. 4386 в. 12842 г. 16009

3. Ах дүү хоёрт 900 төгрөг байв. Тэд бүх мөнгөнийхөө 250 төгрөгөөр үзэв авсан бол хэдэн төгрөг үлдсэн бэ?

4. Өгсөн тоонуудын арифметик дунджийг олоорой.

54, 236, 1092, 13450

5. 2354 гэсэн тоог аравт, зуут мянгатаар тоймлоорой.

аравтаар: 2354

зуутаар: 2354

мянгатаар 2354

6. Тэгш өнцөгтэй талбайн урт нь 18м, өргөн нь уртаасаа 2 дахин бага бол талбай, периметрийг олоорой.

Дүгнэх журам:

№	1.	2.	3.	4.	5.	6.
Хариу	11882	$375=300+70+5$ $4386=4000+300+80+6$ $12842=10000+2000+800+40+2$ $16009=10000+6000+9$	300 төг	3708	$2354 \sim 2350$ $2354 \sim 2400$ $2354 \sim 2000$	$P=54 \text{ см}$ $S= 162 \text{ см.кв}$
Оноо	6	2	1	2	1	3

Үнэлгээ:

Түвшин	Үнэлгээ хувиар	Авсан оноо
VIII	90-100%	15, 14
VII	80-89%	13, 12,
VI	70-79%	11, 10
V	60-69%	9, 8
IV	50-59%	6, 5
III	40-49%	4, 3
II	30-39%	2, 1
I	0-29%	0



БҮЛЭГ 3. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРАЛЦАГЧДЫН СУРАХ, ХӨГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ АРГА

ДЭД СЭДЭВ 3.1. ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРӨӨР ДАМЖУУЛАН СУРАЛЦАГЧДЫГ ЕБС-Д БЭЛТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗОРИЛГО	- Холимог бүлгийн суралцагчдыг ЕБС-ийн зохих ангид шилжүүлэн суралцуулахад тулгарах хүндрэл, бэрхшээл, асуудлыг илрүүлэх, түүнийг даван туулахад дэмжлэг үзүүлэх - Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх - Холимог бүлгийн суралцагчдыг ЕБС-ийн зохих ангид шилжин суралцахад бэлтгэх үйл явцыг дэмжих ажлыг зохион байгуулах
ХУГАЦАА	2 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийг ЕБС-д шилжин суралцах үйл явцыг дэмжих арга зүйд суралцана.
АРГА ЗҮЙ	• Дүрд тоглох • Ярилцлага • Кейс дээр ажиллах • Лекц

АЖИЛЛАХ АЛХАМ:

1. Дүрд тоглон даалгавар гүйцэтгэх

Хүрэх үр дүн: Хүүхдэд тулгардаг бэрхшээлийг өөрийн биеэр мэдэрнэ.

Зарцуулах хугацаа: 10 минут

2. Оролцогчдыг 2 бүлэгт хуваан кейс дээр ажиллуулж тусгай хэрэгцээт хүүхэд, тэдний гэр бүлд тулгардаг бэрхшээл болон асуудлын талаар ярилцан, тодорхой зорилтот бүлгүүдэд тулгарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх боломж, арга замын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх

Хүрэх үр дүн: Холимог бүлэгт суралцаж буй тусгай хэрэгцээт суралцагчдыг ЕБС-д шилжүүлэн суралцуулахад тохиолдох



бэрхшээлийг илрүүлж шийдвэрлэх арга замуудыг тодорхойлно.

Зарцуулах хугацаа: 20 минут

3. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх

Хүрэх үр дүн: Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах талаар онолын мэдлэг эзэмшинэ.

Зарцуулах хугацаа: 20 минут

4. Оролцогчдыг 2 бүлэгт хуваана.

Бүлэг 1- Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх, Бүлэг 2- Нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах

Хүрэх үр дүн: Холимог бүлэгт суралцаж буй тусгай хэрэгцээт суралцагчдыг ЕБС-д шилжүүлэн суралцуулахад хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөтэй болно.

Зарцуулах хугацаа: 40 минут

5. “Сургуульд шилжин суралцаж буй сурагчийг дахин завсардах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр ярилцлага зохион байгуулах, дүгнэлт хийх

Хүрэх үр дүн: ЕБС-д шилжин суралцаж буй тусгай хэрэгцээт сурагчийн дахин завсардах эрсдэл, урьчилан сэргийлж авах арга хэмжээг тодорхойлно.

Зарцуулах хугацаа: 20 минут

6. Оролцогчдод видео үзүүлж тодорхой асуултын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх

Хүрэх үр дүн: Эцэг эх, асран хамгаалагчийн хандлагад нөлөөлөх арга зүйд суралцана.

Зарцуулах хугацаа: 10 минут

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Нүдний хаалт
- Кейс
- Дэлгэц цаас
- Маркер
- Видео



ДААЛГАВАР:

№1. Дадлага ажил 1. Сэдэлжүүлэх даалгавар гүйцэтгэнэ. Багш оролцогчдоос 2 хүнийг сайн дураараа гарч ирж даалгавар гүйцэтгэхийг хүснэ. Эхний хүнийг ангиас түр хугацаагаар гаргана. Үүний дараа 2 дахь хүний нүдийг нь зориулалтын алчуураар хааж урьдчилан бэлтгэсэн саадын дэргэд зогсооно. Дараа нь эхний хүнийг танхимд буцаан оруулж ирж 2 дахь хүнд зөвхөн амаар зааварчилгаа өгөх байдлаар бэлтгэсэн саадыг даван туулахад нь хөтчөөр ажиллуулна. Бусад оролцогчид үйл явцыг ажиглана. Даалгаврыг гүйцэтгэж дууссаны дараагаар уг 2 оролцогч болон хөндлөнгийн ажиглагч оролцогчдод төрсөн сэтгэгдлийг сонсож ярилцана.

№2. Дадлага ажил 2. Нийт оролцогчдыг 2 багт хуваан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлд тохиолдож буй бэрхшээл, асуудлын талаар өгүүлсэн 4 кейс /баг тус бүрт 2 кейс/ дээр ажиллуулна:

- Тухайн хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчид ямар бэрхшээл тулгарч буйг илрүүлэн ярилцана.
- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй суралцагчийг ЕБС-д шилжүүлэн суралцуулахад тулгарч буй саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлно.

Оролцогч талууд	Тулгарч буй бэрхшээл	Шийдвэрлэх арга зам
• Багш 1 /НТБ-ын багш/ • Багш 2 /ЕБС-ийн багш/ • Суралцагч • Анги хамт олон • Эцэг эх, асран хамгаалагч • Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, бусад ажилтнууд		



Кейс 1.

Баянхонгор аймагт амьдардаг 12 настай Г-ийн ээж: Хүү маань сонсголгүй, ярьдаггүй, унаж татдаг, оюун ухааны хоцрогдолтой. Харилцаанд ороход хүндрэлтэй. Өөрөө явдаг. Өөрөө өөртөө үйлчлэх чадвар дунд зэрэг. Сургууль, цэцэрлэгт ер явж байгаагүй. Унаж татдаг тул цэцэрлэг, сургууль авдаггүй. Хоёрдугаарт, сонсголгүй хүүхдийг авдаг сургууль, цэцэрлэг манай аймагт байдаггүй. Бусад хүүхэдтэй харилцаанд ороход хүндрэлтэй. Бичиг үсэг мэдэхгүй. Зөвхөн амны хайрцаар таамаг төдий уншина. Өөрөө сайн ойлгож байгаа эсэхийг бид мэдэхгүй. Сэтгэл санаагаа илэрхийлэхэд нь бид ойлгодоггүй. Гадаа гарахад гадаа гэж дохиод л бид түүнийг шууд аваад гардаг. Яах гэж гарч байна гэж боддог л байж таараа. Хүү маань юу бодож, юу хүсч мөрөөдөж, юу хийхийг хүсч байгаагаа бусдад илэрхийлж чаддаггүй. Бид ч бас юу хэлэхийг хүсч байгаагаа бүтэн илэрхийлж чаддаггүй. Хүү маань өөрөө л "Тэр гаднаас ирлээ, явлаа" гэх мэт ойр зуурхан зүйлээр бидэнтэй харилцдаг.



Кейс 2.

Ховд аймгийн Цэцэг суманд амьдардаг 8 настай Б-ийн аав: Хүү маань унаж татдаг. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй. Цэцэрлэгт 3 жил явсан. Сургуульд 1 жил суусан. Үсгээ нүдэлсэн ч уншиж чаддаггүй. Уналт таталт нь нэмэгдээд байсан тул сүүлийн хоёр жил сургуульд суугаагүй. Унаж татаад байхаар багш болон сургуулийн захиргаа хүүхдийг сургуульд авахаас татгалзсан. Сургууль дээрээ татах нь их л хүндрэлтэй санагддаг. Сургуулийнхан татахад нь анхан шатны тусламж үзүүлж чаддаггүй. Эмч нь уналттай хүүхдээ өдөрт үздэг. Ийм хүүхдүүдийн эрүүл мэндэд нь илүү их анхаардаг болмоор байна. Мөн сургууль хүүхдийн сайн эмчтэй болмоор байна. Зарим сургууль эмчгүй байна. Хүүхэд сургуульд явахгүй байх нь үе тэнгийнхнээсээ хөгжлийн хувьд их хоцордог. Одоо гэрээр хичээл зааа гэж боддог. Хичээл заахаар заримдаа үгэнд ордог, заримдаа үгүй. Одоо 9-р сараас сургуульд, хоёрдугаар ангид явуулна. Оюуны ачааллаас болоод уналт таталт нь нэмэгдээд байх



шиг санагддаг. Унаж татдаг болохоор жирийн хүүхдүүдээс илүү багасгасан цагт буюу хөнгөвчилсөн байдлаар хичээл авах хэрэгтэй гэж боддог. Ийм хүндрэлтэй хүүхдүүдэд багш нь илүү уян хатан ханддаг байвал илүү сайн байх болно.



Кейс 3.

Улаанбаатар хотод амьдардаг 6 настай А-ийн ээж: Нугасны эвэрхийгээс хүүгийн маань доод мөчний мэдрэл алдагдсан. Зогсож, явж чаддаггүй. Бие засах мэдрэл алдагдсан. Бөөрний үйл ажиллагаа хүндрэлтэй. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй. Оюун ухаан, дээд мөчний үйл ажиллагаа хэвийн. Цэцэрлэгт явснаар хүүхдийн хөдөлгөөн анх байснаасаа илүү сайжирсан. Оюуны чадвар нэмэгдсэн. Олон нийт дунд ороод ярих чадвар сайжирсан. Байнга живх хэрэглэдэг тул живх авч чадахгүй үед цэцэрлэгтээ явж чаддаггүй, завсарддаг байсан. Мөн мөнгөний асуудлаас болоод хааяа хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгч чаддаггүй байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байнгын тасралтгүй сургалтын үйл ажиллагаанд хамрагдах ёстой. Даанч ийм нөхцөл бүрдэхгүй байна. Хүүхдийн оюун ухаанд нь тохируулан хичээл заалгамаар байна. Миний хүүхдийн оюун ухаан зүгээр байхад оюуны хоцрогдолтой хүүхдэд заадаг хичээлээ миний хүүд бас заагаад байдаг нь хүүд маань таалагддаггүй. Миний хүүгийн явж байсан 10-р цэцэрлэг хичээлийн шинэ жил эхлэхэд нийтдээ 100,000 төгрөгийн сургалтын хэрэгсэл эцэг эхээр авахуулдаг байсан хэрнээ дандаа хэрэглэсэн цаасны ар тал дээр хүүхдээр зуруулсан байдаг. Хичээлд бидний авч өгсөн зүйлсийг хэрэглэж байгаа эсэх нь мэдэгддэггүй. Ер нь багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаад их л залхсан янзтай байдаг. Бүр цөхөрсөн, идэвх зүтгэлгүй байдаг. Ажил тарах цагаа хүлээсэн багш нар л байдаг даа. Яаж тэднийг идэвхжүүлэх, урамшуулахыг мэдэхгүй байна.



Кейс 4.

Улаанбаатар хотод амьдардаг 14 настай Х-ийн ээж:



Хүү маань саажилтын улмаас тулах, хөдлөх эрхтний бэрхшээлтэй. Хүн ойлгох хэмжээнд ярина. Хөтлөхөд муухан явна, юм түшээд зогсоно. Гараараа хийх юмыг хөлөөрөө хийнэ. Хоолоо иднэ. Хүүхэд өөрөө гараараа юм барьж чадахгүй ч, өнгө мэднэ. 100-гийн дотор тоо мэднэ. Баруун гараараа юм барьж сурч байна. Нэг жил саажилттай хүүхдийн 10-р цэцэрлэгийн 24 цагийн ангид явсан. Багш нарын зүгээс асаргаа муу байсан. Хооллоод л болно. Ээж, аавд нь хичээлээ заагаад өг гэхээр биднийг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа ер оруулдаггүй. Жишээ нь, бариа засал зэрэг зүйлийг би бас суръя гэхээр зөвшөөрдөггүй байсан. Багшаас бусад цэцэрлэгийн ажилчид их муу харилцаатай байсан. Уг нь хүүхдээ цэцэрлэгт өгвөл би ажил хийж чадна. Толгойтын 42-р сургуулийн тусгай ангид нэг жил хагас дутуу явсан. Сургуульд явахад бусад хүүхдүүдтэй харилцаад, илэн далангүй байж сурсан. Даанч сургууль гадаа жорлонтой тул үргэлжлүүлэн сургах боломжгүй болоод гарсан. Сургуульд явахад гарч байсан бас нэгэн асуудал нь унааны асуудал. Гурав дахь том бэрхшээл нь хүүхдэд тохирсон тусгай сандал, ширээ сургуульд байхгүй байсан. Саажилттай хүүхэд, ялангуяа замбараагүй хөдөлгөөн хийдэг хүүхдүүдийн хувьд тусгай сандал ширээ нь хөдөлгөөнөө удирдахад зайлшгүй хэрэгтэй туслах хэрэгсэл шүү дээ. Иймд сургуулийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авах боломжтой болгоод, унаагаар үйлчилдэг болвол сургуульд явж эхэлнэ. Оюун ухаан нь зүгээр байхад энгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авахгүй гэдэг, бүгдийг нь сурах чадваргүй гэж боддог. Миний хүүхэд бусдын л адил хүүхэд шүү дээ.

№3. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн зорилго, зорилт, арга зүй, зохион байгуулалт, хүрэх үр дүнгийн талаар онолын мэдлэг олгож, суралцагчдыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, нийгэмшихүйн хөгжлийн судалгааны загварт үндэслэн үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй эзэмшүүлнэ.

№4. Дадлага ажил 3. Оролцогчдыг 3 бүлэгт хуваан загварын дагуу хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулна.



БАТЛАВ.

НИЙГМИЙН АЖИЛТАН /

СУРАЛЦАГСДЫГ ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРӨӨР ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

..... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

Зорилго: Хичээлийн бус цагаар суралцагчдыг нийгэмшүүлэх, тэдний авьяас чадварыг нээн хөгжихөд нь дэмжин туслахаас гадна, бусдаас суралцах, шинээр олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцан нийгэмд зөв дадал хэвшилтэй иргэн болгон төлөвшүүлнэ.

№	Чиглэл	Хийгдэх ажил	1-р улирал			2-р улирал		3-р улирал		4-р улирал	
1											
2											
3											

№5. Дадлага ажил 4. “Сургуульд шилжин суралцаж буй сурагчийг дахин завсардах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр ярилцлага зохион байгуулна. Оролцогчдыг 2 бүлэг болгон хувааж гарч болзошгүй эрсдэлийн жагсаалтыг гарган түүнээс урьдчилан сэргийлж авах арга хэмжээг тодорхойлно.

Сургуулиас дахин завсардах эрсдэл	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	Зохион байгуулагч

№6. Дадлага ажил 5. Оролцогчдод видео үзүүлж тодорхой асуултын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Видеоны агуулга:

Нэгэн гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд мэндэлжээ. Эмч хосуудад “Танай хүүхэд хэзээ ч явж чадахгүй” гэж хэлэв. Хосуудын аав, ээж, найзууд нь хүүхдээсээ татгалзахыг зөвлөжээ. Хосууд хүүхдээ асрамжийн газарт өгөх тухай утсаар ярилцана. Гэтэл тэдний яриаг нэгэн эмч санамсаргүй сонсоно. Эмч тэдэнд хандан “40 жилийн өмнө нэгэн гэр бүл хөлгүй, тахир дутуу хүүхэд төрүүлсэн юм. Тэд хүүгээ асрамжид өгсөн. Хүү өсөх тусам үргэлж гадуурхагдаж, шоолуулдаг байжээ. Гэвч тэр бууж өгөлгүй тэмцсээр алдартай мэс заслын эмч болж олон хүмүүсийг аварч байна. Тэр хаягдсан хүү бол БИ. Харин жилийн өмнө би төрсөн ээжийгээ эмчилж эдгээсэн. Ээж маань намайг орхисондоо харамсаж, хайж явсан ч олон



жилийн дараа олж уулзсан юм. Та хоёр хүүхдээ асрамжид өгөх хэвээрээ юу?" гэж асуув.

Чиглүүлэх асуулт:

- Хосууд ямар шийдвэр гаргах бол?
- Хэрвээ хүүхдээ асрамжид өгвөл ...
- Хэрвээ хүүхдээ өөрсдөө асарвал ... зэрэг асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ 1: Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр

Суралцагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих, нийгэмшүүлэх үйл ажиллагааг "Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр"-өөр дамжуулан зохион байгуулна.

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн *зорилго* нь "суралцагч нь хамт олны үйл ажиллагааны явцад өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах, хөгжүүлэх, бусдыг манлайлах чадвартай, хөгжилтэй, эвсэг, ажилсаг хамт олныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг бүтээлч, санаачилгатай, оролцоот иргэн болж төлөвших"-д оршино.

Зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарна:

- Зорилгын мөн чанар, үрдүнг сургууль, НТБТ болон түүнд ажиллаж буй багш, ажилтнууд сайтар ойлгож өөрийн байгууллагын онцлог, суралцагчдын нөхцөл байдалтай уялдуулан бүтээлчээр хамтран хэрэгжүүлэх
- Хүүхдийн хүрэх үр дүн, эзэмших чадварыг суралцагч, эцэг эх, олон нийтэд ойлгуулах, хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн талаарх өнөөгийн ойлголт хандлагыг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэх
- Зорилгоо дэмжсэн олон хувилбартай, цөөн үйл ажиллагаа байх

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд доорх *зорилтыг* биелүүлнэ:

- Хамт олны нэг гишүүний хувьд өөрийн хүсэл сонирхол, авьяас чадвар, хувийн онцлогоо нээж, өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах, хөгжүүлэх, манлайлах чадвартай болох;
- Хөгжилтэй, эвсэг, ажилсаг хамт олныг бүрдүүлэх арга замыг эрэлхийлж, ажил үүргээ хуваарилан, биелүүлэхийн төлөө хамтдаа хичээн ажиллах;
- Бусдын үзэл бодол, байр суурь, ялгаатай байдлыг хүндэтгэн тэдэнтэй зүй зохистой хүнлэг харилцаж хэвших;



- Нийгмийн нэг гишүүний хувьд нийтийн сайн сайхны төлөө санаачилга гарган хэрэгжүүлэхийг эрмэлзэх;

Арга зүй:

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн үйл ажиллагааны явцад суралцагч бие даан бүтээлчээр оролцож асуудал шийдвэрлэх арга барилд суралцана. Суралцагч дараах үе шат бүхий үйл ажиллагаагаар дамжуулан өөрт, хамт олонд болон сургууль, орон нутаг, хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадварт суралцана. Үүнд:

1. Асуулт гаргаж, анхаарал татсан асуудлыг тодруулах
2. Асуудал үүсэх нөхцөл буюу тохироог илрүүлэх
3. Асуудлыг шийдвэрлэх
4. Асуудал дэвшүүлэх г.м.

Хүүхэд өөрөө бие даан хийж гүйцэтгэх, оролцох үйлийн явцдаа суралцан хөгждөг зарчмыг баримтлан сургалтын арга зүйгээ төлөвлөн хэрэгжүүлнэ.

Арга зүйг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл:

- Асуудлыг шийдвэрлэхэд шинжлэн судлах арга, оролцоо, манлайллыг дэмжих олон төрлийн аргуудыг хослуулан хэрэглэх
- Хүүхэд бүрийн асуудал шийдвэрлэх чадварын түвшинд тохируулан үйл ажиллагаанд оролцуулах замаар ахиулах

Арга зүй нь дараах шаардлагыг хангана:

- Хүүхдийн хувь шинж, хөгжлийн ялгаатай, онцлог байдлыг харгалзан тэгш оролцуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
- Асуулт дэвшүүлснээр үйл ажиллагаа болон суралцагчийн хөгжлийг дэмжих;
- Олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;

Зохион байгуулалт:

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн хувьд орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн янз бүр байна. Хөтөлбөрийн үйл ажиллагаа нь танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулагдана.

Танхимын хэлбэрээр:

- Баг, бүлгээр хэлэлцүүлэг хийх, илтгэл тавих, мэдээлэл солилцох, мэтгэлцээн хийх г.м.
- Урлагийн арга хэмжээ: дууны, бүжгийн, хөгжмийн, жүжгийн, хүүхэлдэйн жүжгийн, уран зургийн, фото зургийн, цаасан болон шүр сувсан урлалын дугуйлан, ганцаарчилсан сургалт явуулах г.м.



- Спортын арга хэмжээ: төрөл бүрийн спортын дугуйлан, явган аяллын клуб, шатар, даам, газрын, агаарын, ширээний теннис, спортын төрлийн тэмцээн, уралдаан, спартакиад зохион байгуулах г.м.
- Интернэт орчинд холбогдож мэдээлэл хайх, ашиглах, компьютерийн хэрэглээний программууд дээр ажиллаж сурах, сонсдог ном зохиолыг ашиглах, гадаад хэл сурах г.м.
- Мужаан, оёдол, эсгүүр, нэхмэл, хатгамал, сийлбэр, зүймэл эдлэл, сур суран эдлэл хийх г.м. үйл ажиллагааг суралцагчийн сонирхол, авьяас, хэрэгцээ, эрүүл мэндийн онцлог зэргийг харгалзан хамруулж, зохион байгуулж болно. Тухайлбал, тусгай хэрэгцээт хүүхдүүд нь сургууль завсардсан, тэр бүр үе тэнгийнхэнтэйгээ чөлөөтэй харилцдаггүй тул өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг нь хүндрэлтэй байдаг. Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд мэдээлэл солилцох, илтгэл тавих, мэтгэлцээн хийх зэрэг баг, бүлгээр хамтран ажиллах нь эергээр нөлөөлнө.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлогоос хамаарч хамруулах дугуйланг сонгоно. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сонирхол, авьяасыг харгалзан фото зургийн дугуйлан, явган аяллын клубд хамруулах, гишүүн болгох зэрэг нэмэлт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаанд хамруулж болно.

Танхимын бус хэлбэр:

- Сургуулийн орчин, үйл ажиллагаатай
- Орон нутгийн байгаль орчинтой
- Музей, соёлын биет өв, түүх соёлын дурсгалт газартай
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтай
- Эцэг эхийн ажлын газар зэрэгтэй танилцах аялал, зугаалга зохион байгуулж болно.

Тухайлбал, сургуулийн орчин, үйл ажиллагаатай үе шаттай танилцах ажлыг зохион байгуулснаар холимог бүлгийн хүүхдүүд сургуулийн байрны зохион байгуулалт, анги кабинетын зориулалт, номын сан, багш, эмч, нийгмийн ажилтны өрөө, хүүхэд хөгжлийн танхим зэрэгтэй танилцаж, үйлчлүүлж, ашигладаг болох эхлэл тавигдаж, сургуулийн орчинд дасан зохицох нөхцөл бүрдэнэ.

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийн сонирхол, ур чадвар, авьяасд тулгуурлан бусдад туслах сайн дурын



хамтлаг, бүлгэм байгуулж ажиллуулах нь өөртөө итгэлтэй болох, бусдад туслах, нийгмийн хариуцлагатай, үүргээ ухамсарласан нэгэн гишүүн болоход нөлөөлөх ач холбогдолтой. Тухайлбал, хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гэрээр очиж хичээлийг нь заах, ном унших, дуу, шүлэг хамтран сурах, гэр орны ажилд нь туслах, салхинд гаргах г.м. ажлыг сайн дураар хийх нь гэртээ байгаа хүүхдүүдэд ч урам зориг өгөн, найз нөхөдтэй болох, шинийг мэдэх сайхан боломж өгөх тустай ажил юм.

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрийг амжилттай зохион байгуулснаар дараах үр дүнд хүрнэ:

- Суралцагч өөрийгөө танин мэднэ. Би хэн бэ? ирээдүйд хэн болохыг хүсч, мөрөөдөж байна вэ? хүсэл мөрөөдөлдөө хүрэхийн тулд хэнтэй хамтран, хэний дэмжлэгтэйгээр би өөрөө юу хийж болох вэ? зэрэг асуудлыг тодорхойлж эхэлнэ.
- Өөртөө итгэлтэй болж, эрүүл мэндийн хувьд асуудал байдаг ч энэ нь бусад хүүхдүүдээс ялгарах асуудал биш, бусадтай адил сурч, ажиллах эрхтэй, чадалтай, чадвартай гэдэгт итгэлтэй болно.
- Өөрийн удирдлагатай, сурах арга барил эзэмшсэн суралцагч болж эхэлнэ. Зорилго зорилтоо дэвшүүлэх, хүрэх арга замаа тодорхойлох, хийх болон хийсэн үйлдэлдээ үнэлгээ, дүгнэлт өгч дараагийн алхмаа олж харах чадвартай болно.
- Оролцооны идэвх нэмэгдэж, нийгэмшинэ. Өөрт хамааралтай асуудлын талаар үзэл бодлоо илэрхийлж, шийдвэр гаргаж чаддаг болно.
- Өөрийн болон хамт олны хөгжил, бусдын сайн сайхны төлөө санаа тавьж санал, санаачилга гаргаж өөрийн хувь нэмрээ оруулах явцад ирээдүйн мэргэжлийн чиг баримжаатай болно.

МЭДЭЭЛЭЛ 2: Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх ажлын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар

Төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд:

- Суралцагч бүрийн саналыг авч, хэрэгцээнд үндэслэсэн
- Суралцагчдын бүтээлч санаачилга, сургууль, НТБТ-ийн бодит байдалд тулгуурласан
- Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжил, эрүүл мэндийн онцлогийг харгалзсан
- Төлөвлөсөн ажлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангасан



- Гэр бүл, эцэг эх, ЕБС-ийн багш, сурагчид, орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтарсан байхыг анхаарна.

БАТЛАВ.
НИЙГМИЙН АЖИЛТАН /Б.БОЛД/

НТБТ-ИЙН СУРАЛЦАГСДЫГ ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨРӨӨР ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018-2019 оны хичээлийн жил

Зорилго: Хичээлийн бус цагаар суралцагчдыг нийгэмшүүлэх, авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд нь дэмжин туслах, бусдаас суралцах, шинээр олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцан нийгэмд зөв дадал хэвшилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

№	Хийгдэх ажил	I улирал			II улирал			III улирал			IV улирал		
1	Ангийн хурал /сонгуульт ажил, сургалт/	9 сар		11 сар		1 сар		3 сар		5 сар			
2	Ажиглалтын судалгаа /хүүхэд нэг бүрээр/	9 сар	10 сар										
3	Зам тээврийн аюулгүйн байдлын заавар өгөх	9 сар	10 сар	11 сар	12 сар			2 сар	3 сар	4 сар	5 сар		
4	Ангиараа хийх хөдөлгөөнт дасгал	Тогтмол											
5	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах							4 сар					
6	Үндэсний тоглоомоор тоглох өдөр		10 сар					2 сар					
7	Сэтгэлийн илгээмж /захидал бичих/					1 сар					5 сар		
8	Дугуйлан секцийн үйл ажиллагаанд суралцагчдыг оролцуулах	9 сар	10 сар	11 сар	12 сар								
9	Уншлагын цаг /номын тэмдэглэл хөтлөх/	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар			
10	Нийслэлийн өдөр аялал		10 сар										
11	Шинэ оноо сурлага, авьяасаараа угтъя				12 сар								
12	Зөв хувцаслалтын талаар зааварчилгаа				12 сар								
13	Цэвэр агаар - Эрүүл мэнд					1 сар							
14	Үндсэн хуулийн өдөр /хүүхдийн эрх, үүрэг, хамгааллын хуультай танилцах/					1 сар							
15	Цагаан сар /ёс заншил/							2 сар					
16	Ээжүүдийн баярт бүтээл хийх							3 сар					
17	Ном унших, бүтээх /дүрийн тоглолт хийх/									4 сар			
18	Гэр бүлийн өдөр										5 сар		
19	"Монгол хүн" хүмүүжлийн аян	9 сар	10 сар	11 сар	12 сар		2 сар	3 сар	4 сар	5 сар			
20	Зөв дадал хэвшилд суралцъя аянд ТХБ-ын үзэл санааг тусган ажиллах			11 сар				3 сар					
21	Би үүнийг чадна /тайлант өдөрлөг/			11 сар		1 сар		3 сар			5 сар		
22	Улсын шалгалтад бэлтгэх										4, 5-р сар		

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
АНГИ УДИРДСАН БАГШ: /

МЭДЭЭЛЭЛ 3. Суралцагчдын нийгэмшихүйн хөгжлийн судалгааны загвар

Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулахын өмнө суралцагчдаас нийгэмшихүйн судалгааг авч хэрэгцээ, шаардлагыг тодорхойлно. Судалгааны үр дүнд тулгуурлан ажлын төлөвлөгөөг боловсруулж үйл ажиллагааг зохион байгуулна. Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсний дараагаар судалгааг дахин авч ахицыг үнэлнэ.



Хүснэгт 1. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулахын өмнө авах судалгааны загвар

“СУРАЛЦАГЧДЫН НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖИЛ”-ИЙН СУДАЛГАА /өмнөх/

№	Суралцагчдын нэр	А. Нийгэмшихүй				Б. Хувийн сахилга бат				В. Бусад хүүхдүүдтэй харилцах харилцаа				Г. Сурч хөдөмөрлөх чадвар			
		Ангийн ажилд идэвх санаачилгатай оролцдог эсэх				Хийж буй үйлдэл, ангийн уур амьсгал орчинд нөлөөлдгийг ойлгох эсэх				1 ба түүнээс дээш хүүхэдтэй зохицон харилцах чадвар				Өгсөн үүрэг даалгаврыг өөрийн уран санаагаар баяжуулдаг эсэх			
		тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор
1	С.Хишигбаяр																
2	Б.Тэнгэр																
3	Э.Чинхүслэн																
4	О.Энх-Отгон																
5	Ө.Энххүслэн																
6	Б.Анццэг																
7	О.Баяндаваа																
8	Б.Номин-Эрдэнэ																
9	Б.Гантулга																
10	Б.Одоншагай																
11	М.Оюумаа																
12	Б.Түмэнбаяр																
13	Б.Чинхүслэн																
14	М.Батбаатар																
15	Э.Билгүүн																
16	Б.Хүчитбаатар																
17	Б.Нямрагчаа																
18	М.Отгонбат																
19	У.Тэмүжин																
20	Б.Анхзаяа																
21	А.Ганчимэг																
22	Э.Жавхлан																
23	Б.Жанчивсамба																
24	Д.Давааням																
		8%	20%	33%	37%	29%	20%	20%	29%	20%	25%	25%	25%	16%	20%	29%	29%

Багшийн гаргасан дүгнэлт: Ангийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдын хувийн сахилга батыг сайжруулах, бие биетэйгээ зөв харилцах, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлэх асуудалд анхаарах.

Хүснэгт 2. Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх төлөвлөгөөт үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа авах “Суралцагчдын нийгэмшихүйн хөгжлийн судалгаа”-ны загвар

“СУРАЛЦАГЧДЫН НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖИЛ”-ИЙН СУДАЛГАА /дараах/

№	Суралцагчдын нэр	А. Нийгэмшихүй				Б. Хувийн сахилга бат				В. Бусад хүүхдүүдтэй харилцах харилцаа				Г. Сурч хөдөмөрлөх чадвар			
		Ангийн ажилд идэвх санаачилгатай оролцдог эсэх				Хийж буй үйлдэл, ангийн уур амьсгал орчинд нөлөөлдгийг ойлгох эсэх				1 ба түүнээс дээш хүүхэдтэй зохицон харилцах чадвар				Өгсөн үүрэг даалгаврыг өөрийн уран санаагаар баяжуулдаг эсэх			
		тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор	тогтмол	ихэнх	зарим	ховор
1	С.Хишигбаяр																
2	Б.Тэнгэр																
3	Э.Чинхүслэн																
4	О.Энх-Отгон																
5	Ө.Энххүслэн																
6	Б.Анццэг																
7	О.Баяндаваа																
8	Б.Номин-Эрдэнэ																
9	Б.Гантулга																
10	Б.Одоншагай																
11	М.Оюумаа																
12	Б.Түмэнбаяр																
13	Б.Чинхүслэн																
14	М.Батбаатар																
15	Э.Билгүүн																
16	Б.Хүчитбаатар																
17	Б.Нямрагчаа																
18	М.Отгонбат																
19	У.Тэмүжин																
20	Б.Анхзаяа																
21	А.Ганчимэг																
22	Э.Жавхлан																
23	Б.Жанчивсамба																
24	Д.Давааням																
		29%	29%	21%	21%	50%	17%	21%	8%	41%	25%	25%	21%	37%	20%	25%	8%

Гарсан ахиц:

А. Тогтмол – 29% ахисан

Б. Тогтмол – 50% ахисан

Ихэнх – 29% ахисан

Ихэнх – 17% ахисан

Заримдаа – 21% буурсан

Заримдаа – 8% ахисан

Ховор – 21% буурсан

Ховор – 41% буурсан



В. Тогтмол – 41% ахисан Ихэнх – 25% ахиагүй Заримдаа – 25% буурсан Ховор – 21% буурсан
Г. Тогтмол – 37% ахисан Ихэнх – 20% ахисан Заримдаа – 25% буурсан Ховор – 8% буурсан

МЭДЭЭЛЭЛ 4. Сургуульд шилжин суралцаж буй сурагчийг дахин завсардах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

"Насан туршийн боловсролын төв, нэгжийн дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй суралцагчид"⁹ судалгаанаас үзэхэд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 2016-2017 оны хичээлийн жилд 9291 суралцагч хамрагдсан бөгөөд тэдгээрийн сургууль завсардсан шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон байна.



* Бусад шалтгаанд шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, багш нарын таагүй харилцаа, гадуурхалт, гэр сургуулиас алслагдсан байдал, хөдөлмөр эрхлэлт, үе тэнгийнхний дарамт, ялгаварлал зэрэг шалтгааныг авч үзсэн байна.

Судалгаанаас үзэхэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй нийт суралцагчдын дунджаар 5 хувь нь ЕБС-ийн зохих ангид шилжин суралцдаг боловч дахин завсарддаг байна. Дахин завсардах эрсдэлийг бууруулахад оролцогч талууд дараах байдлаар дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

⁹ "Насан туршийн боловсролын төв, нэгжийн дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй суралцагчид". Үндэсний хэмжээнд хийсэн судалгаа 2016-2017. 2017 он



Сургуулиас дахин завсардах шалтгаан	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	Зохион байгуулагч
Амьжиргааны түвшин болон амьдралын боломж тааруу тул сургуульд сурах нөхцөл: дүрэмт хувцас, хичээлийн хэрэглэгдэхүүн зэрэг нь дутмаг	- Эцэг эхэд зөвлөгөө өгөх: сургуульд сурах бэлтгэл хангах - Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдийн дүрэмт хувцас, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангахад дэмжлэг үзүүлэх хувь хүн, байгууллагын судалгаа гаргах, тусламжийн аян зохион байгуулах	Эцэг эх, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, холимог бүлгийн багш, анги удирдсан багш, хувь хүн, байгууллага
Ангийн хүүхдүүдийн ялгаварлан гадуурхалт их	- ЕБС-ийн багш, сурагч, ажилтанд хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээт хүүхэд, тэдний гэр бүлийн нөхцөл байдлын талаар зөв, эерэг хандлага бий болгох нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах: ярилцлага, хэлэлцүүлэг хийх, тэдэнд туслах сайн дурын баг ажиллуулах...	Багш, Нийгмийн ажилтан, сурагчдын сайн дурын хамтлаг
Багшийн хандлага, харилцаа, дэмжлэг, мэргэжлийн ур чадвар, сэтгэл дутмаг	- Хүүхдийн эцэг эх, ар гэрийнхэнтэй уялдаа холбоотой ажиллах - Холимог бүлгийн тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга барил эзэмших - Мэргэжил, арга зүйн хувьд өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, ганцаарчлан ажиллах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах - Сурагчаа ойлгох, мэдрэх, хамтран ажиллах ажлуудыг зохион байгуулах	Багш, сургуулийн удирдлага
ЕБС-ийн анги удирдсан багш болон холимог бүлгийн сургалтын багш нарын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоо муу	- Холимог бүлгийн багштай хамтран ажиллах: сурагчийн талаарх мэдээлэл хуваалцах, судалгаа хийх, түүний эрүүл мэндийн онцлог, сурах арга барил, суралцах чадварыг тодорхойлох, тохирсон хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах	Холимог бүлгийн болон анги удирдсан багш



Сургуульд шилжин суралцах сэтгэл зүйн бэлтгэл хангагдаагүй, шинэ орчин нөхцөл, хамт олонд дасан зохицох чадвар сул	- Сургуульд шилжин орж ирэхээс өмнө ангийн хамт олонтой танилцуулах, нөхөрлөх арга хэмжээг хамтран зохион байгуулах: спортын болон урлагийн арга хэмжээ зохиох, гэр ойрхон хүүхдүүдээр хичээлд нь туслуулах, аялалд хамт явах, баг болон хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах, уралдаан тэмцээнд оролцох, дугуйлан секцэд сурах ... - Сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай хамтран шаардлагатай зөвлөгөө өгөх	Нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, эцэг эх, анги хамт олон, сурагчдын сайн дурын хамтлаг
Сургуулийн орчин, анги танхимын зохион байгуулалт эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцээгүй	- Сурагчийн эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлийн онцлогийг харгалзан ээлтэй, аюулгүй, сурах орчинг бүрдүүлэх - Тохиромжтой орчин, тохируулгат хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах	Сургуулийн удирдлага, ажилтнууд Орон нутгийн засаг, захиргаа, байгууллага, хувь хүн, эцэг эх
Сургуулийн орчин дахь хүмүүсийн харилцаа, хандлага сөрөг	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хүүхэд, залуус, насанд хүрэгчдийн ойлголт, хандлагыг эерэг болгох чиглэлийн нэвтрүүлэг, сурталчилгааг олон нийтийн радио, телевизээр явуулж байх - Багш, ажилтнуудын ойлголтыг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх чиглэлээр нөлөөллийн ажил, аян зохион байгуулах - Шилжин ирсэн сурагчийг сурталчлах ажил зохион байгуулах: сургуулийн радио үзэлээр ярилцлага хийх, бүтээлээр үзэсгэлэн гаргах, тухайлбал авсан фото зургаар, зурсан зургаар, хийсэн цуглуулгаар ...	Сургуулийн удирдлага, багш, сурагчдын сайн дурын хамтлаг, орон нутгийн радио, телевиз, байгууллага, хувь хүн, эцэг эх



	- Урлаг, спортын авьяас, ур чадварыг бусад хүүхдэд, - эцэг эх, сургуулийн ажилтнуудад сурталчлах	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчлэх унааны асуудал шийдвэрлэгдээгүй	- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургууль, гэрийн хооронд зориулалтын унаагаар тээвэрлэх - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг графикийн дагуу унаагаар үйлчлэх багш, эцэг эх, сайн дурын туслах баг байгуулах	Орон нутгийн засаг, захиргаа, сургуулийн удирдлага, эцэг эх, багш, сайн дурын туслах баг
Эцэг эхийн боломж хомс, хариуцлага сул	- Суралцагчдын ар гэрийн амьдрал ахуйтай танилцах, судлах, үүргийг ухамсарлуулах нөлөөллийн ажил зохион байгуулах - Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эхэд зөвлөгөө өгөх хамтарсан баг байгуулах, ажиллуулах: сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтан, холимог бүлгийн болон анги удирдсан багш - Тусгай хэрэгцээт суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчийг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах	Багш, эцэг эх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч



ДЭД СЭДЭВ 3.2. ЕБС-ИЙН ЗОХИХ АНГИД ШИЛЖҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХАД ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ БУУРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ, СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ

ЗОРИЛГО	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байсан тусгай хэрэгцээт холимог бүлгийн хүүхдүүдийг сургуульд шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох, суралцах чадварыг нь дэмжих арга хэмжээ зохион байгуулах арга зүйд суралцах
ХУГАЦАА	3 цаг
ХҮРЭХ ҮР ДҮН	Холимог бүлгээр боловсрол нөхөн эзэмшсэн тусгай хэрэгцээт хүүхдүүдийг сургуульд шилжүүлэн суралцуулах бэлтгэлийг хангаж, зохих ангид үргэлжлүүлэн суралцах нөхцөлийг бүрдүүлдэг болно.
АРГА ЗҮЙ	• Ярилцлага • Кейс дээр ажиллах • Лекц • Зурагтай ажиллах

АЖИЛЛАХ АЛХАМ:

- Оролцогчдод видео үзүүлж, асуудал дэвшүүлэн, хэлэлцүүлэх өрнүүлэх
Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурч, амьдрах орчинг бий болгох талаарх ойлголт нэмэгдэнэ.
Зарцуулах хугацаа: 10 минут
- Ялгаатай байдал ба бусдыг ойлгох, хүүхдийн дасан зохицох болон суралцах чадварын талаар мэдээлэл өгөх
Хүрэх үр дүн: Ялгаатай байдал ба бусдыг ойлгох, хүүхдийн дасан зохицох болон суралцах чадварын талаар онолын мэдлэг эзэмшинэ.
Зарцуулах хугацаа: 40 минут
- Оролцогчдыг 4 багт хуваана. Багшийн санал болгосон сэдвээс баг тус бүр 1 сэдэв сонгож багшийн чиглүүлж буй асуултуудад хариулж харилцан ярилцах
Хүрэх үр дүн: Ялгаатай байдал, түүний давуу тал, ялгаатай байдлаас үүсэж болзошгүй бэрхшээл, түүнээс урьдчилан сэргийлэх



талаар мэдээлэлтэй болно.

Зарцуулах хугацаа: 10 минут

4. Оролцогчдыг 4 бүлэгт хуваан кейс дээр ажиллуулна. Тухайн хүүхдийн хөгжил, суралцахуйд гарсан ахиц, дэвшлийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөө боловсруулах

Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдана.

Зарцуулах хугацаа: 40 минут

5. Хүүхдийн суралцах чадварыг сайжруулах зарим аргуудын талаар мэдээлэл өгөх

Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах чадварыг сайжруулах арга барил эзэмшинэ.

Зарцуулах хугацаа: 30 минут

6. Дадлага ажил. Тусгай хэрэгцээт холимог бүлгийн хүүхдүүдийг сургуульд шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох чиглэлээр нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулах, арга зам, хамтран ажиллах иргэд, хамт олон, байгууллагыг тодорхойлох

Хүрэх үр дүн: Тусгай хэрэгцээт холимог бүлгийн хүүхдүүдийг сургуульд шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох чиглэлийн нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулагдана.

Зарцуулах хугацаа: 50 минут

АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Видео
- Дэлгэц цаас
- Маркер
- Өвөрмөц хэлцийн тайлбар толь
- Өнгийн цаас

ДААЛГАВАР:

№1. Нийт оролцогчдод видео үзүүлж “Хэрвээ нөхцөл байдал ийм байсан бол хөгжлийн бэрхшээл гэх нэршил байх байсан болов уу?” гэсэн асуулт тавьж хэлэлцүүлэг өрнүүлнэ.

№2. ЕБС-ийн зохих ангид холимог бүлгээс шилжин орсон тусгай хэрэгцээт хүүхдэд тухайн нөхцөл байдалд дасан зохицох чадвар эзэмшүүлэх арга зүйн онолын мэдлэгийг хэлэлцүүлгийн аргаар эзэмшүүлнэ.



№ 3. Оролцогчдыг 4 багт хуваана. Баг тус бүр дараах сэдвээс нэгийг сонгоно. Үүнд:

- Жимс, жимсгэнэ
- Амьтан
- Мэргэжил
- Хөгжмийн зэмсэг

Нэг минутын хугацаанд сонгосон сэдвийн дагуу аль болох олон үг жагсаан бичнэ. Баг тус бүрийн жагсаан бичсэн үгийн тоог хэлэхийг хүснэ. Хэлсэн тоог сэдвийнх нь хажууд бичээд тэдэнд олон үг бичсэнд нь баяр хүргэнэ.

Сонгосон сэдвээс хамааран баг тус бүрээс дараах асуултыг асууна.

Жимс жимсгэнэ: Таны дуртай жимс аль нь вэ? Хэрэв манай оронд зөвхөн чацаргана л ургадаг байсан бол ямар байх байсан бол?

Амьтан: Эдгээр амьтдаас гэртээ тэжээх боломж олдвол аль амьтныг сонгох байсан бэ? Хэрэв Монголд ганцхан төрлийн амьтан байсан бол нөхцөл байдал ямар байх байсан бол?

Мэргэжил: Шинэ хот барих бол эзгээр мэргэжлээс хэдийг нь ашиглах вэ? Хэрэв зөвхөн нэг л мэргэжлийн хүмүүс хотыг барьж эхэлбэл юу болох бол?

Хөгжмийн зэмсэг: Та аль хөгжмийн зэмсгийг тоглож сурахыг хүсэж байна вэ? Дэлхий дээр зөвхөн хийл хөгжим байдаг байсан бол ямар байх байсан бэ?

Бүх багуудаас дараах асуултыг асууж харилцан ярилцана.

№	Асуулт	Гарч болох хариулт
1	Хаа сайгүй бүх зүйл адилхан байсан бол дэлхий ертөнц ямар байх байсан бэ?	- Уйтгартай - Гунигтай - Нэг хэвийн байх байсан
2	Дэлхий дээр маш олон төрлийн юмс байхын ач холбогдол нь юунд байдаг вэ?	- Амьдралыг илүү сайхан, сонирхолтой болгоно - Амьдралын олон өнгийг олж харна



3	Нийгэмд ялгаатай байдал байхын ашигтай тал нь юу вэ?	- Нийгмийн амьдрал илүү сонирхолтой болно - Өөр олон зүйл хийж, сурч, бүтээж болно - Илүү олон сонголттой болно - Анхаарч үзэх болон бодож цэгнэх илүү их санаа бодол, төсөөлөл, үзэл санаа бий болно - Бодол санаагаа солилцох боломжтой болж, оюун ухаан, соёлын амьдрал илүү баялаг болж хөгжинө - Маш олон үзэл бодол, хандлагаас хамгийн шилдэг сайныг нь авах буюу хэрэглэх бололцоотой болно - Бэрхшээлийг даван туулах болон шаардлагыг хангах арга зам олдох магадлал их болно. - Ирээдүйн амьдралд туршлага болдог
4	Ялгаатай байдлаас шалтгаалан ямар бэрхшээл гарч болох вэ?	- Өөр зүйлийг ойлгох буюу хүлээн авах нь бага байх тохиолдолд хүмүүс бие биетэйгээ харилцан учраа ололцоход хүндрэл учруулдаг - Бие биеэсээ өвөрмөц ялгаатай хүмүүст хамтран ажиллах, зорилгодоо хүрэх, бэрхшээлийг шийдвэрлэхэд хэцүү байхж магадгүй - Хүмүүс бие биетэйгээ санал нийлэхгүй байх магадлалтай учир үл ойлголцол, маргаан үүсэх нь бий - Зөрчилдөөний эх үүсвэр болж хүчирхийлэл гарч болзошгүй
5	Ялгаатай байдлын улмаас үүсэж болзошгүй бэрхшээлээс урьдчилан сэргийлэхийн тулд бид юу хийх хэрэгтэй вэ?	- Өөрөөсөө ялгаатай хүмүүсийн тухай мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх - Өөрөөс нь өөрөөр бодож сэтгэдэг эсвэл аливаа асуудалд өөрөөр буюу шинээр ханддаг хүмүүсийг хүндэтгэж сурах - Санал зөрөлдөх болон бусдын санаа бодлыг хүндэтгэх, бүх хүн санаа нэгтэй байх эсвэл үргэлж “зөв” байх ёстой гэсэн бодлоос салах - Бусдаас өөр хүн байх нь ямар байдгийг мэдрэх, ойлгох

№4. Дадлага ажил 1. Оролцогчдыг 4 багт хувааж баг тус бүр 1 кейс дээр ажиллана. Тухайн хүүхдийн хөгжил, суралцахуйд гарсан ахиц, дэвшлийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.



Кейс 1.

Улаанбаатар хотод амьдардаг 12 настай Д. 2-р ангид сурдаг. Багшийн тодорхойлсноор авиа үсэг тогтоосон боловч холбож унших чадвар сул, анхаарал тогтворгүй, хөдөлгөөн ихтэй. Сурагч Д дуучин С.Жавхлангийн дуунд дуртай, нэлээд дууны аяыг сайн мэдэх хэдий ч үг дутуу, заримыг ямар ч хамаагүй үг хэрэглэн дуулдаг. Багшийн ажиглалтаар сэтгэцийн үйлийн илрэл гадагшаа, хөгжмийн мэдрэмж сайтай, дуулах сонирхолтой. Багш дуртай дуучин Жавхлангийн дууны үгэн дээр уншиж сургах зорилго тавин ажилласан. Суралцагчийн өөрийнх нь сонирхолд нийцсэн тул унших болон хуулан бичих чадвар богино хугацаанд эзэмшсэн.



Кейс 2.

Улаанбаатар хотод амьдардаг 11 настай Т. Оюун ухааны болон зан төлвийн бэрхшээлтэй. Өөрөө өөртөө үйлчлэх чадвар дунд зэрэг, хөдлөх эрхтэн хэвийн. 3-7 нас хүртлээ цэцэрлэгт явсан. Одоо тусгай сургалттай 70-р сургуулийн 3-р ангид сурч байна. Сургуульд хамрагдсанаар тогтож сууж, бусдыг сонсож, юм бичиж сурч байна.



Кейс 3.

6 настай Б-ийн ээж: Хүү маань саажилтын улмаас хөдлөх, тулах эрхтэн муу тул явж чаддаггүй. Сонсгол, оюун ухаан сайн. Хувцсаа өөрөө муухан өмсдөг. Хоолоо өөрөө иддэг. Гэхдээ ганцаараа бие засаж чаддаггүй. Одоо зогсож сурч байна. Өөрөө сурах дуртай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвд явснаар хүүхдийн маань байдал эрс сайжирсан. Багш, удирдлагын зүгээс сайн ханддаг. Хөдөлгөөн нь сайжирч байгаа. Дуулдаг болсон. Аливаа зүйлд анхаарал нь сайжирсан. Ийм төвтэй болсноор хүү минь сурах, нийгэмших газартай болсон.



Кейс 4.

18 настай Э-ийн ээж: Охин маань оюун ухааны хоцрогдолтой. Хөдөлгөөн, хэл яриа хэвийн. Гурван настайдаа 10-р цэцэрлэгт хоёр сар явсан. Дараа нь Хан-Уул дүүргийн цэцэрлэгт хоёр жил явсан. Цэцэрлэгийн багш нар танай хүүхэдтэй ажиллахад хүндрэлтэй байна гэж гомдоллодог байсан. Гэхдээ цэцэрлэгт манай хамаатан байдаг байсан тул яаж ийж байгаад л хоёр жил явуулсан.



Дараа нь дүүргийнхээ тусгай 63-р сургуульд 9 настайдаа элсэн ороод энэ хавар 9-р ангиа төгссөн. Одоо Сэргээн засалтын үндэсний төвд бэлэг дурсгал, гар урлалын ангид сурч байна.

№5. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрүүл мэнд, хөгжлийн онцлог, чадвар, суралцахуйн хэв шинж, сурах арга барилд тулгуурлан хүүхдийн суралцах чадварыг хөгжүүлэх арга барилын талаар онолын мэдлэг олгоно.

№6. Дадлага ажил 2. Нийт оролцогчдыг 4 багт хуваана. Холимог бүлгийн тусгай хэрэгцээт хүүхдүүдийг сургуульд шилжүүлэн суралцуулахад ялгаатай байдлыг бууруулах, дасан зохицох чиглэлээр нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллах иргэд, хамт олон, байгууллагыг тодорхойлно.

Чиглэл	Хамтран ажиллах бүлэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа
Ялгаатай байдлыг бууруулах	Сургуулийн орчинд		
	Төрийн байгууллага, ТББ, иргэд олон нийтийн хүрээнд		
Дасан зохицох	Сургуулийн орчинд		
	Төрийн байгууллага, ТББ, иргэд олон нийтийн хүрээнд		

МЭДЭЭЛЭЛ 1. . Ялгаатай байдал ба тусгай хэрэгцээт хүүхдийн сургуульд дасан зохицох үе шат

Ялгаатай байдал гэдэг нь олон янз буюу өөр өөр байх явдал юм. Нийгмийн түвшинд авч үзвэл, энэ нь маш олон янзын үзэл баримтлалын эх үүсвэр болдог соёл иргэншил, үндэс угсаа, арьсны өнгө, хэл болоод шашин шүтлэгийн ялгаа юм. Ялгаатай байдлын улмаас үүсэн гарах



олон янзын үзэл баримтлал, баялаг туршлага нийгэмд тус болохоос гадна асар их төвөг бэрхшээлийн үндэс болдог. Ялгаатай байдал ихсэх тусам бүлгүүдийн хооронд таагүй уур амьсгал бий болж ялгаварлан гадуурхалтыг үүсгэдэг¹⁰ байна.

Хэрэв хүмүүс бусдыг ойлгож ухаарах, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхийн тулд ямар нэг зүйл хийхгүй бол ялгаатай байдал нь өөр бүлэг буюу өөр өөр итгэл үнэмшилтэй хүмүүсийн хоорондох харилцаа холбоонд бэрхшээл үүсгэх боломжтой.

Ялгаатай байдлыг зохицуулах, ойлгохын салшгүй нэг хэсэг нь бусдыг мэдэрч ойлгох ба энэ нь бусдын байгаа байдал, мэдрэмж, сэдлийг таньж мэдэн түүнийг ойлгох, өөр хүний мэдэрч байгааг мэдрэхийг хэлнэ. Бусдыг ойлгох нь хүмүүст ертөнцийн янз бүрийн ялгаатай нөхцөл байдалд амьдрахын сайн сайхныг мэдрэхэд тусалдаг.

Насан туршийн боловсролын төвийн боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байгаад сургуулийн зохих ангид шилжин суралцаж буй тусгай хэрэгцээт хүүхдүүдэд сургууль, анги, багш, ангийн сурагчдад дасан зохицож цаашид үргэлжлүүлэн суралцах асуудал хамгийн хүндрэлтэй байдаг. Холимог бүлгийн суралцагч эдгээр зүйлд сэтгэл зүйн хувьд бэлтгэгдэлгүй шилжин ордог тул хэсэг хугацааны дараа эргэн завсардах асуудал элбэг тохиолддог. Хүүхэд хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал хэвшил, үе тэнгийнхний дунд орж харилцаа үүсгэж чаддаг эсэхээс хамаараад сургуульд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй байдаг. Гэтэл сургуульд орох насандаа сургуульд огт хамрагдаагүй, эсвэл тодорхой ангиас завсардсан, тэр тусмаа эрүүл мэндийн хувьд ямар нэгэн асуудалтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхэн дундаа илүү хаагдмал, өөртөө итгэлгүй, шинэ орчинд дасах нь хүнд байдаг байна.

Эрдэмтэн Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо дараах 3 үе шатыг дамждаг байна:

- 1) түгшүүрийн,
- 2) дайчлах,
- 3) дасан зохицох эсвэл үл дасан зохицох үе шатыг¹¹.

Хүүхдэд ээлтэй, аюулгүй байгаа нөхцөлд тухайн суралцагч өөртөө итгэлтэй, тайван байж, тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж

¹⁰ "Амьдрах ухааны чадвар" чиглүүлэгчийн багц гарын авлага. С.Энхтуяа, Э.Мөнгөтулга. УБ.2016

¹¹ Сургууль-эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй. Сургалтын модуль. 2017



үздэг байна. Учир нь өөртөө итгэлтэй, аз жаргалтай, өөриймсөг, дулаан уур амьсгалтай орчныг мэдэрсэн хүүхэд сургуульд хурдан дасан зохицож, түүнийхээ хэрээр суралцах чадварын ахиц илүү байна.

Хүүхэд сургуульд дасан зохицоход дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг:



Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг холимог бүлэгт хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан, тусгай орчинд боловсрол нөхөн эзэмшүүлж байсан бол сургуульд шилжин орсон эхний өдрөөс шинэ орчин нөхцөл, сурах үйл ажиллагаанд дасах шаардлагатай болдог. Тухайн суралцагч сургуулийн сурагч болж, амьдралын шинэ хэв маяг, сургалтын шинэ арга барил, ангийн сурагчдын дунд эзлэх шинэ байр суурь, багш, үе тэнгийнхэнтэй харилцах харилцааны шинэ хэлбэрт шилждэг.

Иймд сургуульд шилжин орсон эхний үе нь хүүхдийн хувьд шинэ нөхцөлд дасан зохицох үе болдог. Энэ үеийг даван туулж чадаагүй хүүхэд эргээд сургууль завсардах, өөртөө итгэлгүй, гутрангуй, өөрийгөө бусдаас өөр хүн гэсэн ойлголттой болох сөрөг талтай.

Эхний үе шат буюу түгшүүрийн үед хүүхэд сэтгэл санааны тогтворгүй байдалд ордог: айх, сандрах, ээрэх, гацах, хичээлээ ойлгохгүй байх, сургуульд явах дургүй болох, өвчин нь сэдрэх г.м. шинж илэрдэг байна.

Хоёр дахь буюу дайчлах үе шатны үед айдсаа даван туулах, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, ангийн найзтай болох, багш, ангийн хүүхдүүдийн үйлдэл, харилцааг өөриймсөг хүлээн авдаг болох, анги, сургуулийн орчиндоо дасч хөдөлгөөнд ордог байна. Холимог бүлгээс шилжин ирсэн хүүхдүүд энэ үеийг нилээн урт хугацаанд туулдаг байна.

Гурав дахь үе шат: дасах эсвэл үл дасах үе. Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, тухайн ангийн хүүхдүүдээс ялгагдах шинж үгүй болдог.



Холимог бүлгийн багш, ангийн хүүхдүүдээ санах, үгүйлэх байдал аажмаар багасдаг. Харин энэ үе шатыг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд хүүхэд ордог. Ийм тохиолдолд хүүхдийн сурч хөгжих боломжид саатал гарах, үргэлжлүүлэн сурах хүсэлгүй болох, сургуулиас дахин завсардах асуудал тулгардаг.

Сургуульд шилжин суралцах хүүхдүүдийг холимог бүлэгт сурч байх хугацаанд сургуулийн орчинд дасан зохицох үйл ажиллагааг багш системтэй зохион байгуулж, сэтгэл зүйн хувьд бэлтгэснээр дээр дурдсан үе шатуудыг богино хугацаанд даван туулах ач холбогдолтой юм.

МЭДЭЭЛЭЛ 2. Тусгай хэрэгцээт хүүхдийн сургуульд дасан зохицох чадвар

Тусгай хэрэгцээт хүүхдүүд эрүүл мэнд, бие, хөгжлийн онцлог, сурах чадвараасаа хамааран шинэ орчин нөхцөлд харилцан адилгүй дасан зохицдог. Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинг ялгаж үзсэн байна.

Дасан зохицох чадвар сайн	Дасан зохицох чадвар дунд	Дасан зохицох чадвар сул
- Дасан зохицох чадвар сайн хүүхэд 10-15 хоногийн дотор хэвийн байдалд орж, хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага байна. - Сургуульд явах дуртай, багшийн тавьсан шаардлагыг хүлээж авна. - Хичээлийн агуулга, хөтөлбөрийг хялбар аргаар бүрэн эзэмшинэ. - Төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чадна. - Багшийн тайлбарыг анхааралтай сонсоно.	- Дасан зохицох чадвар дунд хүүхдийн ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, «өвдөх» болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрнэ. - Сургуульд явахдаа дургүйцдэггүй. - Багш хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгох чадвартай. - Хичээлийн хөтөлбөрийн гол агуулгыг эзэмших чадвартай.	- Дасан зохицох чадвар сул хүүхдийн түгшүүрийн болон биеэ дайчлах үе нь 6 хүртэл сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд өвдөх, дадал болсон зүйлээ мартах, биеийн болон сэтгэл санааны хямралд орно. - Сургуульд явах дургүй. - Дарамттай мэдрэмж зонхилно. - Сахилга бат зөрчих байдал ажиглагдана. - Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчлэн ойлгоно. - Бие дааж ажиллах чадвар сул байна.



- Хяналт шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг хичээнгүй биелүүлнэ. - Бие даан ажиллах чадвар сайтай байна. - Нийгмийн идэвх, хариуцлага сайтай байна.	- Томчуудын хяналтан дор даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгэнэ. - Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө. - Ангийн хүүхдүүдтэй найзалж нөхөрлөнө.	- Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, өдөөх, туслах шаардлага гарна. - Нийгмийн идэвх сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ. - Дотны найз нөхөдгүй, ангийн цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ.
--	---	---

Эцэг эхчүүдийн хийж болох зүйлүүд	Эцэг эхчүүдийн хийж болохгүй зүйлүүд
- Сургуульд шилжин орохоос өмнө сургууль, анги танхимтай танилцах аялал хийх - Сургууль, багш нарын тухай эерэг ойлголт төрүүлэх яриа өрнүүлэх - Сургуульд суралцсанаар амжилт гаргасан хүүхдүүдийн тухай ярьж, бүтээлийг нь үзүүлэх - Хүүхдийнхээ дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслийг худалдан авахдаа өөрийнх нь хүсэлтийг харгалзах - Хүүхдээ сургуульд хүргэж өгөхдөө хүүхдээ болон өөрийгөө цэвэр, цэмцгэр хувцаслаарай. Энэ нь сургуулийг эрхэмлэн хүндэтгэх үзэлтэй болгоход тустай. - Хичээлийн бэлтгэлийг бүрэн хангаж явуулах - Цүнхэндээ хичээлийн хэрэгслийг эмх, цэгцтэй ангилж авч явахад нь зааж сурах - Хүүхдээ байнга урамшуулах, итгэл найдвар, сурах хүсэл эрмэлзлийг нь дэмжиж байх	- Өмнө нь сургуультай танилцуулалгүй шууд хичээлийн эхний өдөр очих. Энэ нь хүүхдэд сэтгэл зүйн хувьд таагүй байдал үүсдэг. - Сургуулийн талаар сөрөг ойлголт өгөх зүйлийн талаар ярих - Бүх хүүхдүүд заавал сургуульд сурдаг ч гэсэн сурах хэрэгтэй гэж шаардах. - Ганцаараа явж хүүхдийнхээ хичээлийн бэлтгэлийг хангах - Сургуульд хүүхдээ хиртэй, урагдсан хувцастай явуулах. Энэ нь хүүхэд өөртөө итгэлгүй таагүй байхаас гадна сургуулийг үл хүндэтгэсэн хандлага төрүүлэх муу нөлөөтэй. - Бэлтгэл дутуу эсвэл чанаргүй хэрэглэгдэхүүн бэлтгэж өгөх нь хүүхэд хичээлдээ явахаас дургүйцэх, хичээлээс хоцрох шалтгаан болдог. - Цүнхэн дэх хичээлийн хэрэгсэл эмх цэгцгүй байх нь хүүхдэд хэрэглэгдэхүүнээ олохгүй байх зэрэг хүндрэл учруулдаг. - Шүүмжлэх, дооглох, бусад хүүхдүүдтэй харьцуулах, хийсэн ажлыг нь голох, үнэлэхгүй байх нь хүүхдийг сурах хүсэл сонирхолгүй болгодог.



Сургуульд шилжин орж буй хүүхдийн эцэг эхэд нөлөөллийн ажлыг багш заавалурьдчиланзохионбайгуулаххэрэгтэй. Учирнь сургууль завсардсан болон эрүүл мэндийн хувьд асуудалтай, хөгжлийн бэрхшээлтэй, тусгай асаргаа шаардагддаг хүүхэдтэй эцэг эхэд сэтгэл зүйн тусламжаас, хүүхдээ сурахад дэмжлэг үзүүлэх арга зүйн мэдлэг ч шаардлагатай байдаг. Багш энэ чиглэлийн нөлөөллийн ажлыг янз бүрийн сонирхолтой арга хэрэглэн үе шаттай явуулах нь зүйтэй. Мөн хүүхдүүдийн эцэг эхээс бүрдсэн сайн дурын баг бүрдүүлж, хүүхдээ сургуульд шилжүүлэн суралцуулахад дасгах, сургуульд суралцах чадварыг нь дэмжих ажлыг хамтран зохион байгуулах нь хүүхдийн бүтээлч, бие даан суралцах чадвар эзэмших таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ 3. Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах чадвар

Аливаа юмс үзэгдлийг сурч, танин мэдэх зорилгоор ухамсартайгаар хийж гүйцэтгэж буй сэтгэхүйн олон янзын үйлүүдийг хүүхдийн суралцах чадвар гэнэ. Суралцах чадварт уншиж, бичиж, ярьж сурахаас эхлээд ажлаа бие даан төлөвлөх, гүйцэтгэсэн ажилдаа өөрөө хяналт тавих, зөв бурууг шалгах, засварлах зэрэг чадвар, дадал багтдаг. Суралцагч тодорхой сонирхол, хэрэгцээгээ хангах зорилгоор ухамсартайгаар хийж гүйцэтгэж буй үйл ажиллагааны үр дүнд танин мэдэх, ойлгох, гүйцэтгэх, чадвар дадалтай болох, алдаа оноогоо дүгнэх зэргээр суралцах бүхий л явцад түүний сурах үйл явц явагддаг.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрүүл мэнд, хөгжлийн онцлог, чадвар, суралцах хэв шинжийг судлан багш суралцах чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллана. Хүүхэд амжилттай суралцахад нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг нь суралцагчийн суралцахуйн хэв шинжийг зөв тодорхойлж, хичээл сургалтын үед анхаарах явдал юм.

Суралцахуйн хэв шинжээр нь:

- Хийж гүйцэтгэх замаар суралцагч
- Ойлгон ухаарах замаар суралцагч
- Туршлагаар суралцагч
- Зөн билгээр суралцагч г.м. ангилж болдог.

Харин сурах арга барилыг VARK-ийн хэв шинжээр хараа, сонсгол, хөдөлгөөн, унших, бичих замаар суралцагч хэмээн ангилдаг.

Хараагаар суралцагч нь ихэвчлэн нүдээ ашиглан аливаа зүйлийг харж тогтоох, ойлгох замаар суралцдаг. Тэд зурагт үзүүлэн, видео, бодит



дүрслэл ашигласан хичээлд идэвхтэй оролцож сайн сурдаг. Ихэнх хүүхдүүдэд хараагаар суралцах үйл ихээхэн ач холбогдолтой.

Сонсголоор суралцагч нь мэдээллийг сонсох үедээ шинэ санаа, ойлголтыг олж авч чаддаг. Тэд 1-2 удаа хэлэхэд зааврын дагуу үйл ажиллагааг гүйцэтгэдэг, сонссон бүхнээ давтан хэлж чаддаг. Цээжлэх шаардлагатай мэдлэг, мэдээллийг дуу хэмнэлд оруулан сайн тогтоодог.

Хөдөлгөөнөөр суралцагч нь биеэр үйл ажиллагаанд оролцох, ямар нэгэн хөдөлгөөн хийх явцдаа цэгцтэй сэтгэж, сайн суралцдаг байна. Тэдний суралцах үйлд хөдөлгөөн хамгийн чухал бөгөөд анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалдаг.

Унших, бичих замаар суралцагч нь унших үйлээр мэдлэг, мэдээллийг олж авахдаа сайн ба өөрийн бодол санаа, бүтээл туурвилыг бичгээр илэрхийлэх чадвартай байдаг.

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч дээрх сурах арга барил өөр өөр байдаг. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүүхэд хараагаар суралцагч байх нь илүү байдаг бол харааны бэрхшээлтэй хүүхэд сонсголоор суралцагч байх нь элбэг тохиолддог.

Багш суралцагчдад суралцах чадварыг эзэмшүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

1. Сурах хэрэгцээг ойлгуулах, сурах сонирхлыг төрүүлэх
2. Суралцагчийг өөртөө итгэх, бусадтай адил сурч чадах чадвартайг ойлгуулах
3. Сургалтын сурах үйлийн ба материаллаг болон сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх
4. Хүүхэд бүрийн сэтгэхүйн болон эрүүл мэндийн онцлог, мэдлэгийн түвшин, чадвар, сэдэл, төсөөлөл зэрэгт тохируулан заах аргыг сонгож хэрэглэх. Хөгжлийн бэрхшээлтэй болон хэт хоцорсон хүүхэдтэй ганцаарчлан ажиллах хөтөлбөр боловсруулан ажиллах
5. Тухайн өдөр, хэнд, ямар агуулгыг, ямар суралцах чадвар эзэмшүүлэн, ямар үр дүнд хүрэх зорилгыг хичээл тус бүрийн өмнө тодорхойлж, сайтар боловсруулах
6. Суралцах идэвхтэй аргуудыг ашиглан хамтран хийж бүтээх, харилцан суралцах боломж олгох
7. Сурч мэдсэн зүйлээ бусдадаа зааж өгөх, өөрийн туршлагаас хуваалцах чөлөөт цагийг гаргаж өгөх



8. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих үнэлгээний төрлүүдийг хэрэглэх
9. Эцэг эхийн дэмжлэг, туслалцааг сайжруулах, сургалтын ажилд татан оролцуулах

Багш, эцэг эх хамтран ажиллаж, хүүхдэд суралцах чадваруудыг амжилттай эзэмшүүлснээр өөртөө хэрэгтэй мэдлэг, мэдээллийг бусдын дэмжлэггүйгээр бие даан сурах чадвартай болгох ба өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, шинийг бүтээх арга барилтай болгоно. Ингэснээр хүүхдийн суралцах чадварт эхний үед дуурайх үйлдлүүд давамгайлдаг байсан бол анги дэвших тусам сурах үйлүүд нь бие даасан, бүтээлч шинжтэй болно.

МЭДЭЭЛЭЛ 4. Хүүхдийн суралцах чадварыг дэмжих зарим аргаас

1. "Зан төлөвшил-Ахиц амжилтын мод" хэрэглэгдэхүүн ашиглах арга

Багш уг хэрэглэгдэхүүнийг сургалтад хэрэглэснээр суралцагчдын зан төлөвшил, сурлагын ахиц амжилт болон өөрийн ажлын явцад хяналт-үнэлгээ, дүн шинжилгээ хийх боломжтой.

Мөн суралцагчид даалгавруудыг хэрхэн гүйцэтгэсэн, ямар дэгийг баримталж хичээллэх, сургууль орчин, олон нийтийн газар, гэртээ ямар ёс суртахууны хэм хэмжээг баримталж төлөвших вэ гэсэн цогц бөгөөд тасралтгүйгээр тогтвортой хөгжих боломжийг олгоно.

Хэрвээ хүсвэл багш та уг хэрэглэгдэхүүнийг гарын доорх материал ашиглан хийх боломжтой. Энэхүү хэрэглэгдэхүүнийг хийхдээ ватум цаасыг алимны мод хэлбэртэй болгон хайчилж модон суурин дээр наана. Мөн улаан, шар өнгийн цаасыг алим хэлбэртэй хайчилж ватум цаасан дээрээ давхарлан наана. Улаан өнгийн алим шар өнгөтэй алимнаас 1-2 см том байхаар хайчилна. Алим хэлбэртэй цаасаа наахдаа тарааж өгөх материалуудыг дотор нь байршуулж болохуйц зайтай хийнэ.



Хэрэглэгдэхүүнийг ашиглах алхам:

- Улаан алиманд судлагдахууны дасгал /хэрчмэл байдлаар



бэлтгэсэн/-уудыг байршуулсан байна.

- Суралцагчид ангид орж ирэнгүүтээ улаан алимнаас өнөөдрийн хичээлийн хуваарийн дагуу гүйцэтгэх хичээлийн дасгал, даалгавруудыг авч, оронд нь шар алиманд өнөөдрийн хичээлд баримтлах дэг /хэрчмэл байдлаар бэлтгэсэн/-ийг хийнэ.
- Хичээлийн төгсгөлд дасгал даалгавруудыг хэрхэн гүйцэтгэснээ дүгнэж, үнэлж ярилцана.
- Ангиас гарахдаа олон нийтийн газар /автобус, дэлгүүр, цайны газар, номын сан... гэх мэт/ болон гэртээ баримтлах ёс суртахууны хэм хэмжээг заасан тараах материалыг сонгон авч явна.
- Маргааш нь дэгийг хэрхэн баримталсан тухайгаа найзууддаа тайлбарлан ярина.

Хэрэглэгдэхүүний ач холбогдол:

- Суралцагч өөртөө зорилго тавин суралцах, аливаа асуудалд хариуцлагатай хандах, шийдвэр гаргах чадваруудыг эзэмшинэ.
- Багш даалгаврын санг холимог бүлгээр бүрдүүлнэ.
- Хичээлийн явцад цагийн алданги гарахгүй байх ач холбогдолтой болно.

2. Урмын үг хэрэглэх арга

Суралцагчдад урмын үг хэлэх нь тэдний суралцах идэвх оролцоо, өөртөө итгэх итгэл, үгийн сангийн баялаг зэргийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой. Багш урмын үгийг янз бүрийн аргаар, хэлбэрээр, байнга хэрэглэж байх хэрэгтэй. Үүний тулд:

- Багш, эцэг эхчүүдийн хэрэглэдэг урмын үгийн цуглуулга хийх
- Өвөрмөц хэлцийн тайлбар толиос урмын үгийн түүвэр хийх
- Суралцагчдын гэрийн даалгаврын дэвтэрт урмын үг бичих
- Суралцагчдад урмын үгийг олон хувилбараар хэлэх
- Суралцагчдадаа урмын захидал бичих
- Эцэг эхчүүд хүүхэддээ урмын үгийг олон хувилбараар хэрэглэх талаар зөвлөгөө өгөх г.м.

Зөв хэрэглэсэн урмын үг, түүнийг илэрхийлэх үйлдэл, хөдөлгөөн суралцагчдад сурах тэмүүллийг өдөөх хэрэгсэл болдог. Магадгүй, багшийн хайралсан, хүндэлсэн харц, толгой илэх зэрэг нь суралцагчдад хамгийн их баяр, баясгаланг авчирч болох юм. Хүүхдэд “Чи хөөрхөн,



царайлаг” гэхээсээ илүүтэй “ухаантай, авьяастай, чадалтай” гэх үгсийг хэрэглэх нь зөв байдаг.

Ихэвчлэн хэрэглэдэг урмын үгс	Хэрэглэж болох үгс	Зүйр цэцэн үгээр урамшуулах
Маш сайн байна Болж байна Дөхөж байна Зөв байна Итгэж байна Амжилт гаргаарай Урагшаа Чи чадна Оролд, бод, бүтээ Чи шүү Мундаг байлаа Гайхалтай Ялалт авчирлаа Гоё болжээ Үнэхээр гоё болжээ Үнэхээр чадварлаг Уран гартан Ирээдүйн яруу найрагч Чи маш сайн эрэлчин Ажилсаг хүү/охин шүү Содон байлаа Гайхалтай байна Цагаа баримталсанд баярлалаа Хамтарч ажиллаж чаджээ Эвсэг байлаа Хичээгээрэй	Сонсоход таатай байна Найздаа дэм өгөөрэй Итгэлтэй байсанд баярлалаа Мэлмий нь тунгалаг, магнай нь баясгалантай байг Од болон гялалзаарай Чиний хариулт таалагдлаа Содон байсан шүү Чамаар бахархлаа Санаачилга гаргасанд баярлалаа Чи чаддаг юм байна Энэ чинь чамд маш их түшиг болно Нууц чадвараа таниулсанд баярлалаа Чи ирээдүйн удирдагч Өөрийгөө нээж чадлаа	Айлаас эрэхээр авдраа уудал Нэг нь нийтийн төлөө нийт нь нэгийн төлөө Эвт шаазгай буга барина Оролдлого сайт оройд гарна Эрдэмт хүн даруу их мөрөн дөлгөөн Аавын хүү алдраараа гайхагдана, Ээжийн хүү эрдмээрээ гайхагдана Бэлтгэл сайн бол ажил сайн Дэм дэмэндээ дээс эрчиндээ Дуугарвал дуу нэг, Дугтарвал хүч нэг Оролдвол нэгийг сурдаг, Уралдвал нэг нь түрүүлдэг Төрсөн ухаанаас Сурсан ухаан илүү Усан далай булгаас эхтэй Ухаан далай номоос эхтэй



Манай хүүхдүүд гэртээ ирэнгүүтээ “Урмын үгтэй дэвтэр”-ээ үзүүлж, маш их баярладаг. Даалгавраа хийх дуртай болсон. Цэвэрхэн бичихгүй бол болохгүй гээд маш хичээнгүй даалгавраа хийдэг болсон. Мэдэхгүй зүйлээ биднээс байнга асуудаг болсон.

Эцэг эхийн төлөөлөл



3. Зураасан зургийг хүүхдийн хөгжилд ашиглах арга


Тусгай хэрэгцээт хүүхдийн эрүүл мэндийн онцлог, сонирхол, авьяасд тулгуурлан зураг зурах энгийн аргуудыг (давхарлаж зурах, дуурайж зурах, гүйцээж зурах, зохиож зурах г.м.) хэрэглэснээр дараах чадварыг хөгжүүлж болно:

Анхаарал	Хүртэхүй	Танин мэдэхүй	Зохион бодохуй	Харилцаа хандлага
Ажигч гярхай чадварыг хөгжүүлэхийн хамт хүүхэд юманд тэсвэр тэвчээртэй хандах байдлыг дээшлүүлнэ.	Хүүхдийн зурах чадварыг нэмэгдүүлж гарын хөдөлгөөнийг засан сайжруулна.	Юмны адил төстэй ба ялгаатай зүйлийг танин мэдэх, харьцуулан дүгнэх, тоолж тооцоолох зэрэг чадварыг хөгжүүлнэ.	Зохиомжлон, хийсвэрлэн сэтгэж зурах чадварыг нэмэгдүүлнэ.	Өөртөө итгэлтэй болох ба үг ярианы баялаг нэмэгдэж, цэвэрч нямбай байх чадварыг хөгжүүлнэ.


Зураг зурах энгийн аргуудын жишээ:



Зураасын дагуу давхарлан зурах



Тодорхой хэсгүүдийг гүйцээж зурах



Тодорхой сэдвийн дагуу утга санааг өөрөө зохиомжлон зурах

4. Оюуны бэрхшээлтэй хүүхдэд дагнасан үр чадвар эзэмшүүлэх арга

Оюуны бэрхшээлтэй болон аутизмтай хүүхдийг дагуулан сургах, давтан үйлдүүлэх замаар дагнасан үр чадвар эзэмшүүлж ажил, хөдөлмөрийн баримжаа олгох боломжтой.



Дагнасан ур чадвар эзэмшүүлэх дасгал ажлын жишээ:

А. Брошюр зөвхөн:



Бэлтгэл ажил:

- Байгууллагын танилцуулгыг А4 хэмжээтэй цаасанд 3 баганаар бичсэн хэвлэмэл хуудас урьдчилан бэлтгэсэн байна.
- Цаасыг адил тэнцвэртэй нугалахад зориулсан хатуу цаасаар хийсэн шаблон бэлтгэнэ.

Гүйцэтгэл:

- Хэвлэмэл хуудсыг нэг нэгээр авч нүүр талыг доош харуулан тавина.
- Шаблоноо хуудасны голд дээш бага зэрэг илүү гаргаж тавина.
- Шаблоны дагуу хуудсыг зүүн гар талаас давхарлан тавина. Шаблоноо давхарлаж буй хэсгийн дотор тал руу сайн шахна.
- Цаасны нугалж буй хэсгийг яаран дарж нугалаас үүсгэхээс өмнө ирмэгүүдийг яг тааруулсан эсэхээ шалгана.
- Эхний нугалаасыг хэмжээ алдалгүй нугалсан бол баруун гар талаас цаасны дараагийн ирмэгийг давхарлан нугална.
- Хүн бүр өөрийн нугалсан брошюраа өмнөө давхарлан өрнө.

Шалгуур:

- Багш нугалсан брошюруудыг зөв цэвэрхэн, алдаатай буруу нугалсан эсэхээр ялган тавина.
- Хурдан алдаатай гүйцэтгэх нь гологдол гаргах учир дараалал, зааврын дагуу гүйцэтгэж сурахыг зөвлөнө.

Б. Туузаар бэлэг дурсгалын чимэглэл хийх:

Энэ нь тусгай хэрэгцээт суралцагчдын жижиг булчингийн хөдөлгөөнийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.



Бэлтгэл ажил:


- 1,5-2,0 см өргөнтэй чимэглэлийн туузыг 20 см урттай тайрч бэлтгэсэн байна.
- Туузыг эрвээхий хэлбэртэй болгон нугалаад ороож тогтоох гоёлын утсыг 5-7 см урттай байхаар тасалж бэлтгэнэ.

Гүйцэтгэл:

- Туузны үзүүрийг зөрүүлэн 4 см орчим диаметртэй гогцоо үүсгэнэ.
- Гогцоог доош дарж туузны зөрлөг дээр давхарлан барьж “Бантик” үүсгэнэ.
- Үүссэн бантикны төвийг гоёлын утсаар 2 ороож чангална.
- Туузны зөрсөн хэсэгт нугалааг засаж бантикаа зөв хэлбэртэй болгон засна.

Үр дүн шалгуур:

- Бантик зөв хэлбэртэй, 2 талын гогцоо ижил байна.
- Ороосон гоёлын утас сулрахааргүй бат бэх байна.



В. Шошгонд огноо дарах:

Энэ нь оюуны болон аутизмын хүнд хэлбэрийн бэрхшээлтэй, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхдийн анхаарлын тогтворжилтыг сайжруулахад чиглэгдэнэ.



Бэлтгэл ажил:

- 6*9 см харьцаатай цаасанд бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн хугацааг тэмдэглэх зайг тохируулан хүрэлцээтэй хэмжээгээр хэвлэсэн байна.
- Хайч, огноо тэмдэглэх дардас зэргийг багийн гишүүдэд хүрэлцээтэй байхаар бэлтгэсэн байна.

Гүйцэтгэл:

- Багийн гишүүд ажлаа хуваарилна. /хайчлах, дардас тэмдэглэх, багцлах гэх мэт/
- Багийн гишүүд дотроо тойргоор үйлдэл тус бүрийг хийж гүйцэтгэнэ.
- Тухайн өдрийн он, сар, өдрийг дардаст тохируулна.

Үр дүн шалгуур:

- Тэмдэглэгээг зохих зайд аль болох гаргацтай, тэгш тэмдэглэж дарсан байх



ХАВСРАЛТ 1

БСШУ-ы сайдын 2010 оны 12 дугаар сарын
10-ны 556 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. УДИРТГАЛ

- Мянганы хөгжлийн зорилт Бүх нийтийн боловсролын Дакарын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ Бичигтэн болох НҮБ-ын арван жилийн зорилт
Дэлхий нийтээр анхаарал хандуулж буй “Мянганы хөгжлийн зорилт”, Бүх нийтийн боловсролын талаарх “Дакарын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ”, “Бичигтэн болох НҮБ-ын арван жил”-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд албан сургалтаас гадна албан бус сургалтын үүрэг, оролцоо туйлын чухал юм.
- Алслагдсан нутгийнхан, эмзэг бүлгийхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хамруулах
Ялангуяа алслагдсан нутгийнхан, эмзэг ядуу бүлгийхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролын хүртээмжид тэгш хамруулах, бүх шатны боловсролын чанарыг сайжруулахад бусад улс орны туршлага, албан ба албан бус сургалтын аль алинд нь хэрэглэж болох сургалтын шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлэх, түүнийг бодлогын хувьд дэмжих шаардлагатай болж байна.
- бүх шатны боловсролын чанарыг сайжруулах
Хүн ам сийрэг оршин суудаг ямар ч газрын хүн амын боловсролын хэрэгцээг хангахад тохирсон сургалтын өвөрмөц хэлбэр болох холимог бүлгийн сургалтыг ашиглах, агуулга арга зүйг боловсронгуй болгох нь чухамхүү дээрх шаардлагад бүрэн нийцэх билээ. Ингэснээр манай нийгмийн өмнө тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхэд ч чухал нөлөөтэй. Тухайлбал, хөдөөнөөс хот суурин газар луу чиглсэн их нүүдлийг зогсоон барих нэг гол арга бол хөдөөгийн сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах, түүний дотор багийн бага сургуулиудын талаар дорвитой арга хэмжээ авах явдал юм.
- Албан-багийн бага сургуульд
Манайд багийн бага сургуулиуд болон албан бус боловсролын дүйцсэн сургалтад холимог бүлгийн арга зүйг хэрэглэж байна. Гэвч энэ талаар баримтлах цогц бодлого үгүйлэгдэж, сургалтын материал, хэрэглэгдэхүүн хангалтгүй байгаагаас гадна холимог бүлгийн сургалтын хөтөлбөр боловсруулагдаагүй, багш нарыг бэлтгэх тогтолцоо ч бүрдээгүй байна. Иймд сүүлийн жилүүдэд БСШУЯ-наас НҮБ-ын хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлсэн холимог бүлгийн сургалтын төслийн үр дүн, туршлагад үндэслэн “**Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр**”-ийг боловсруулан гаргаж байна.
- Албан бус-боловсрол нөхөн олгох дүйцсэн сургалт
Хөтөлбөр нь дараах зорилтот бүлэгт зориулагдсан болно.
- Суралцагч
Үүнд:
- Багш, арга зүйчид
- Сургалтыг зохион байгуулахад оролцогч хэн бүхэн



- Хууль эрх зүйн акт, бусад бичиг баримт
- Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага боловсрол эзэмшиж буй холимог бүлгийн суралцагчид, тэдний эцэг эх
- Албан бус боловсролын Гэгээрэл төвийн багш нар, арга зүйчид
- Хүүхдийн тоо цөөн, бага оврын, бага сургуулийн багш суралцагчид (Багийн сургууль гэх мэт)
- АББ-ын сургалтыг зохион байгуулах, оролцох сургуулийн болон олон нийтийн байгууллагын ажилтан, менежерүүд
- Боловсролын бусад байгууллагын ажилтан
- Хяналт үнэлгээ хийх хүмүүс

Хөтөлбөрийг боловсруулахад дараах хууль эрхзүйн акт, баримт бичигт тулгуурлав. Үүнд:

- Мянганы хөгжлийн зорилт
- Дакарын үйл ажиллагааны үлгэрчилсэн хүрээ: Бүх нийтийн боловсролын зорилтууд
- Монгол улсын бага боловсролын тухай хууль Бага, дунд боловсролын стандарт, кинрикулимын үзэл баримтлал
- Бага, дунд боловсролын стандарт
- Бага боловсролын түвшинд үзэх хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь холимог бүлгийн сургалтаар бага, дунд боловсролын стандартад нийцүүлсэн, чанартай боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн агуулгыг тодорхойлсон удирдамж баримт бичиг болно.

Хоёр. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Анги өөр • Түвшин өөр • Нас өөр • Чадвар өөр • “Олон түвшинт” анги (Канад) • “Нийлмэл” анги (Англи) • Алслагдсан нутгийнхан, хүн ам цөөтэй газар • Үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмзэг | <p>Холимог бүлгийн сургалтыг олон янзаар тодорхойлж болох ч хамгийн товчоор авч үзвэл нэг өрөөнд нэг багш өөр өөр түвшинд суралцагсдад зориулан явуулж буй сургалтын хэлбэр бөгөөд хүн ам сийрэг оршин суудаг ямар ч газар, ялангуяа хөдөө нутгийн хүн амын боловсролын хэрэгцээг хангахад зориулагдсан сургалтын өвөрмөц хэлбэр юм.</p> <p>Холимог бүлгийн сургалтыг хөгжингүй ба хөгжиж буй аль ч оронд түгээмэл хэрэглэдэг олон шалтгаан бий ч хүн амын сууршил бага, нэг ангид суралцагчдын тоо жирийн анги үүсгэх боломжгүй болтлоо цөөрөх зэрэг амьдралын бодит хэрэгцээнээс үүсэн гарч байна.</p> <p>Ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад хүн амын байгалийн өсөлт буурах, хөгжиж буй орнуудад хөдөөгөөс хот суурин газар луу чиглэсэн механик шилжилт ихсэх, сургууль</p> |
|---|--|



- | | |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> • бүлгийнхэнд тохиромжтой • Завсардалтыг бууруулахад тустай • Хамтарсан сургалтын орчин • Хамгийн уян хатан сургалт • Багийн сургалт • Багт багшилдаг хэлбэр • Бие биенээсээ суралцах, хамтарч суралцах орчин • Сурагч төвт сургалтын орчин • Суралцахад ээлтэй орчин • Оролцооны түвшин өндөр, шавь-төвт сургалт • Бие даан ажиллах ур чадварыг сайн хөгжүүлдэг • хөгжил хурдтай | <p>завсардалт нэмэгдэх нь нэг ангид байх хүүхдийн тоог цөөрөхөд хүргэдэг. Ийм байдал манай оронд 1990-ээд оны нийгмийн шилжилттэй уялдан гарч ирсэн нь одоо хүн цөөтэй зарим хөдөөгийн суурин газруудад анги дүүргэлт маш багасаж байгаагаас харж болно. Үүний нэг жишээ нь хөдөө багийн төвүүд дэх бага сургуулиуд юм. Ийм бага оврын сургуулиудад холимог анги хичээллүүлэх нь багшийн орон тоо, өрөө тасалгаа хэмнэх гэхчлэн эдийн засгийн ач холбогдолтой юм. Хүн ам ихтэй ч Балба, Вьетнам зэрэг зарим оронд багшийн нөөц, хүрэлцээгүй байдаг нь сургалтыг холимог бүлгээр зохион байгуулах нэг шалтгаан болдог жишээ ч бий.</p> <p>Холимог бүлгийн сургалтыг зөв зохион байгуулж чадвал олон давуу талтай. Хүмүүст ойрхон, гэр бүлд илүү ойртсон бүлээн дулаан орчин бүрддэг. Учир нь цөөн хүн амтай газар нутагт амьдрагчид бие биенээ мэддэг, суралцагчдын амьдралын хэв шинж ч ямагт хамт байдаг. Жишээ нь: манай багийн төвийн сургуульд суралцагчид, Финландын загасчны тосгоны сургуулийн суралцагчдын аль аль нь том хотынхныг бодвол хоорондоо нэн ойр. Нэг ангид байх хүүхдийн тоо цөөн учир сахилгагүйдэх явдал ч бараг гардаггүй, сургалтын үйл явцад хүүхэд төвт хэлбэр давамгайлна. Энэ нь оролцооны дээд түвшинд сургалт явагдах нөхцөл бүрдсэнээр суралцагчдын бие даан ажиллах ур чадварыг сайн хөгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, жинхэнэ шавь-төвт сургалт энд л явагддаг гэж хэлж болно.</p> |
|--|---|

Өөр өөр насныхан нэг дор хамт хичээллэдэг учир хөгжил хурдтай явагддаг.

Сургалтын явц ихээхэн уян хатан, шинэлэг зүйл, өөрчлөлтийг амархан тусгаж болдог. Асуудал шийдвэрлэх, аливаа зүйлд шүүмжлэлтэй хандаж сурахад дөхөмтэй, хүүхдэд ээлтэй, багшид ээлтэй, суралцахад ээлтэй орчин чухам энд л бүрддэг гэж үздэг аж. Ингэснээр “сурахад суралцах” гэсэн шаардлага биелэлээ олдог.

Гэвч насны хувьд ялгаатай хүүхдүүдэд нэг дор хичээл заах нь амар биш. Суралцагчдыг хичнээн зөв бүлэг болгон ажиллуулсан ч багш өөр өөр түвшний хооронд цаг их зарцуулдаг, сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг ялгавартайгаар хэрэглэхэд тохиромжгүй байх нь бий (Kalaoja, 1990, Korpinen, 1996; 1998). Ялангуяа ангид байх хүүхдийн тоо олон, нөөц хүрэлцээгүй, сургалтын орчин муу, хичээлийн бэлтгэл хангалтгүй, бүлгийн зохион байгуулалт замбараагүй байх нь сургалтын чанарт муугаар нөлөөлнө.



Холимог бүлгээр сургалт явуулж буй багш ямар ч тохиолдолд хоёроос дээш ангийн киррикулимийг боловсруулах шаардлагатай болдог төдийгүй нэг багштай бол тав, зургаан ч ангийн киррикулимийг боловсруулах хэрэгтэй болдог аж9. Иймд киррикулим боловсруулахад суралцах нь холимог бүлгийн багшийн ажлын нэг үндсэн зорилго болно.

Гурав. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН СЭТГЭЛ ЗҮЙН ҮНДЭС

- Бүлэг болгон ангилах
- Бүлгүүд хамтран ажиллах
- Өөр өөр насны бүлгүүд бие биедээ туслах
- Багш бүлэг бүрт туслах
- Ж.Пиаже-ийн танин мэдэхүйн онол
- Эриксоны сэтгэл зүйн онол
- Л.Выготскийн оюун ухааны хөгжлийн онол
- Хүүхэд болгон өөр өөр
- Ямар ч анги "холимог" буюу суралцагчдын чадвар, сэтгэхүйн түвшин ямагт ялгаатай

Суралцагчдыг бүлэг болгон ангилах, бүлгүүд хамтран ажиллах, багш бүлэг бүрт туслах зэрэг нь холимог бүлгийн зохион байгуулалтын гол хэлбэр юм. Ялангуяа өөр өөр насны бүлгүүд бие биедээ туслах үйл явц бол холимог бүлгийн сургалтын хамгийн гол, төрөлх элемент билээ. Суралцагчдыг бүлэг болгон ангилах, бүлгүүд хамтран ажиллах, багш бүлэг бүрт туслах зэрэг нь холимог бүлгийн зохион байгуулалтын гол хэлбэр юм. Ялангуяа өөр өөр насны бүлгүүд бие биедээ туслах үйл явц бол холимог бүлгийн сургалтын хамгийн гол, төрөлх элемент билээ.

Холимог ангид хүүхдийн хөгжил их ялгавартай явагддаг тул үүнийг харгалзан унших, бичих, тоо бодох зэрэг хичээлүүдийг хамтран ажиллах бүлэг болгон зохион байгуулах, харин дүрслэх урлаг, хөдөлмөр, биеийн тамир зэрэг бусад хичээлийн хувьд бүх хүүхэд хамтдаа оролцох боломжтой(Koskenniemi, 1982).

Нас, сэтгэхүй, мэдлэг чадварын түвшингээр өөр өөр суралцагчдыг бүлэгт хуваан сургалтыг нэг дор зохион байгуулах үзэл санаа нь шинжлэх ухааны судалгаа ба нийгмийн практикийн хослолд тулгуурлаж байсан 19-р зууны хоёрдугаар хагасад Европд эхлэн хөгжжээ. Тухайлбал, Германд Петер Петерсены дэвшүүлсэн сургуулийн шинэ загвар болох боловсрол олгох үйл явцыг тухайн нутгийн оршин суугчдад хүрч, тэдэнтэй хамтарч явагдах ёстой гэсэн үзлээс үүдэн сургалтыг бүлгээр зохион байгуулах хэлбэр үүссэн хэмээн үздэг.

Холимог насны хүүхдүүдийг ийнхүү бүлэглэн сургах тухай асуудлын онолын үндэс нь Пиаже-ийн танин мэдэхүйн онол, Бандарусын нийгмийн сургалтын онол, Л.Выгодскийн нийгэм соёлын, Бронфенбреннерийн экологийн, Эриксоны сэтгэл зүйн онол зэрэг болно (Bacharach, Hasslen Anderson, 1995).



Ялангуяа хүүхдийн сурах үйл явцад нийгмийн хэрэгцээг тооцсон Л.Выготскийн онол нь холимог бүлгийн сургалтанд их чухал бөгөөд сургалтаас өмнө ч хүүхдийн хөгжил явагддаг, хүүхдийн өсөж торниж буй орчин нь түүний хөгжлийн гол хүчин зүйл гэж үзсэнийг бодолцохгүй байхын аргагүй (Vygotsky 1978, p.90).

Л.Выготскийн үзсэнээр хүүхдийн оюун ухааны хөгжилд наад зах нь хоёр түвшин байдгийн нэг дэх нь, хөгжлийн хамгийн чухал үе буюу сургалтын үр дүнд илэрдэг “хувийн чадвар”, хоёр дахь нь, багш болон бусадтай хамтран ажилласаны хүчинд илэрдэг “боломжит түвшин” юм. Товчоор хэлбэл, ямар ч үед хүүхэд оюун ухааны хөгжлийн хоёр үеийг заавал туулдаг. Тэдгээрийн хоорондох зай болох “ойрын хөгжлийн бүс”-ийн нөлөө холимог насны ангид тод илэрдэг.

Холимог насны бүлэг нь хүүхдийн нийгмийн болон танин мэдэхүйн хөгжилд маш тустай. Учир нь тэнд насаар ах хүүхдүүдийн ороцоотойгоор нийгэмших, хамтрах үйл явц хурдан “бүтээгдэнэ”. Кристи, Стоун нарын үзсэнээр холимог ангид “ойрын хөгжлийн бүс”-ийн үйл явц эрчтэй илэрдэг тул холимог бүлгийн сургалт нь багш төвт сургалтаас ямагт ялгаатай. Энд хамтран суралцах үйл явц хамгийн эрчимтэй явагдана. Өөр хүүхдээс туслалцаа авсан хүүхэд дараагийн хүүхдэддээ туслалх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭС

- Багш зөвхөн мэдлэг, мэдээлэл дамжуулагч биш
- Хүүхэд идэвхгүй суралцагч биш
- Сургалт нь мэдлэг бүтээх үйл явц
- Асуудал шийдвэрлэх, аливаа зүйлд шүүмжлэлтэй хандаж сурахад хэрэгтэй. Ингэснээр “сурахад суралцах” гэсэн шаардлага биелэлээ олоход дөхөм болно

Боловсролын даяаршлалын өнөө үед гарч буй сургалтын шинэ хандлагууд нь холимог бүлгийн сургалтын арга зүйн нэг гол шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл 1960-аад онд танин мэдэхүйн сэтгэл зүй буюу Веховирист уламжлал нь хүний оюун ухааны үйл ажиллагаа ба бүтцэд голлож голлож байснаас багшийн үүрэг зөвхөн мэдлэг, мэдээлэл дамжуулагч, хүүхэд идэвхгүй суралцагч байсан бол конструктивизмын онол хүчээ авсан өнөө үед багшийн ч, сурагчийн ч байр суурь өөрчлөгдөж байна. Энэ нь “жирийн анги”-д ч холимог бүлгийн сургалтын арга зүй хэрэглэхийн аяндаа шаардаж байна.



- Гурван үндсэн хэлбэр:
 - Түвшин өөр бүлэгт нэг хичээл дээр ижил сэдэв судлах
 - Нэг цаг дээр өөр өөр сэдвийг заах
 - Бүгд ижил сэдэв судлах
- Конструктивизм дахь хоёр гол аспект байгаагийн нэгдэх нь, сургалт бол мэдлэг бүтээх үйл явц юм. Хүн бүр өөр өөрөөр сэтгэн, өөр өөрийн мэдлэгийг бий болгодог энэ нь багшаас хүүхдэд болон нэгээс нөгөөд дамжих боломжгүй юм. Иймд суралцагч тэрхүү бүтээх үйл явцад идэвхтэй оролцож, өөрөө өөрийнхөө мэдлэг бүтээх үед л сургалт явагдаж байна гэж үзнэ. Хоёрт, мэдлэг нь түүний бүтээгдэж буй суралцагчийн орчинтой ихээхэн холбоотой (von Glaserfeld, 1996) болно.

Энэ үүднээс “жирийн” буюу албан сургуулийн хувьд ч ямар ч анги нь “холимог” юм. Учир нь нэг ангид ижил хичээл үзэж адилхан агуулгаар суралцаж буй хүүхэд бүрийн түвшин, чадвар өөр өөр учир “хичээлдээ сайн”, “тааруу” гэхчлэн “ангилагддаг” билээ.

Иймд холимог бүлгийн сургалтын арга зүй нь зөвхөн холимог бүлэг бүхий газар төдийгүй, жирийн сургуульд ч хэрэгтэй гэсэн логик гарч байна. Холимог бүлгийн сургалтын гурван үндсэн хэлбэр бий бөгөө энэ нь 1) хичээл дээр ижил сэдэв судлах боловч бүлэг болгонд түвшин өөр байх, 2) нэг цаг дээр өөр өөр сэдвийг заах, 3) бүгд ижил сэдэв судлах (зураг, дуу хөгжим, биеийн тамир г.м)

Тав. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Хөтөлбөрийн зорилго нь албан болон албан бус сургалтын холимог бүлгийн хэлбэрээр бага боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн агуулга, арга зүйг тодорхойлоход оршино.

Зургаа. ХОЛИМОГ БҮЛГИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Хөтөлбөрийн агуулга нь албан болон албан бус сургалтын холимог бүлгийн хэлбэрээр бага боловсрол эзэмшиж буй суралцагчид “Монгол хэл”, “Математик”, “Зураг, урлан бүтээх хөдөлмөр”, “Хүн ба байгаль, эрүүл мэнд” гэсэн 4 багц хичээлийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвараас бүрдэж байна.

6.1. ЦОГЦ ЧАДАМЖ

Холимог бүлгийн суралцагчид бага боловсролын стандартад нийцсэн дараах цогц чадамж эзэмшинэ.



Монгол хэлний хичээлээр:

- Утга зохиолын хэлний яриа, бичигт тавих шаардлагын дагуу ярьж, бичих
- Эхийг бүтээлчээр унших аргад суралцах, эхийн гол ба нэмэлт санааг ялгах
- Өөрийн санаагаа оновчтой илэрхийлэн ярьж, бичихэд суралцах
- Хэлний нэгжүүдийн онцлог шинжийг мэдэх, тэдгээрийн ойролцоо ба эсрэг утгын харьцааг олох, ялгаж сурах
- Хэлний нэгжүүдийн бүтэц, холбоо, бүтэх арга, хэлбэр, үүргийг задлан шинжлэх, тодорхойлох
- Хэлний бүтэц, зүй тогтлыг мэдэх, тайлбарлах

Математикийн хичээлээр:

- Үзэгдэл юмсын тоо хэмжээ, натурал ба бутархай тооны үйлдлийн нэр томъёо, үг хэллэг, зураг, бичиглэл, тэмдэглэлийг ухаарах, хэрэглэх
- Амьдрал, ахуйн асуудлын агуулгыг илэрхийлэл, тэгшитгэл, тэнцэтгэл бишээр илэрхийлэх, асуудал шийдвэрлэхэд ашиглах
- Геометрийн дүрс ба биеэр загварчлан тооцоолох аргууд (урт, өргөн, талбай, эзэлхүүн олох, өнцөг хэмжих гэх мэт)-тай танилцан амьдрал ахуйд бүтээлчээр хэрэглэх
- Ажиглалт, туршилт хийх, боломж тоолох хялбар аргатай танилцах, үр дүнг хүснэгт, диаграммаар илэрхийлэх, зүй тогтлыг хайж таамаг дэвшүүлэн тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх

Дүрслэх урлаг, технологийн хичээлээр:

- Юмсын үндсэн хэлбэр дүрсээр тайлбарлах
- Объект, бодит юмс түүний шинжийг мэдэх
- Материаллаг болон хийсвэр объектыг ялган, ангилах
- Хүрээлэн байгаа юмсын хэлбэрийг геометрийн биетээр тайлбарлах, зураг дүрслэлээр бодол санаагаа илэрхийлэх.
- Хамтарч хөдөлмөрлөх соёлд суралцах

Хүн ба байгаль, эрүүл мэнд хичээлээр:

- Амьдарч буй орчноо ажиглан, юмс үзэгдлийг ялгах
- Амьгүй ба амьд байгалийн хоорондох холбоо хамаарлыг танин мэдэх, тайлбарлах
- Амьдрал ахуйдаа малын ашиг шим, амьд, амьгүй байгалийн үр



шимийг ашиглах

- Байгаль орчноо хамгаалах, ариг гамтай хэрэглэхийг ухаарах
- Бие ба бодисыг ялгах хэрэглэх
- Нар, сар, од, гариг, агаар, ус, хөрсний шинж чанаруудыг танин мэдэж амьдрал ахуйдаа хэрэглэх

6.2. ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХҮРЭЭНД ЭЗЭМШИХ ЧАДВАР

А. МОНГОЛ ХЭЛ

Монгол хэлний хичээлээр дор дурдсан чадварыг эзэмшинэ.

Эх:

- Эх нь цогцолбороос бүтдэгийг ойлгох
- Цогцолборыг догол мөрөөр ялгаж бичих
- Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж сурах
- Эхийн хэв маяг (тоочимж, хүүрнэмж, тайлбарламж)-ийг өөрчлөн бичих
- Эхийг хурааж, дэлгэрүүлж бичих
- Утгаараа ойролцоо ба эсрэг цогцолборыг таних
- Цогцолбор, утгаар нь зүйлчлэх
- Тодорхой сэдвээр эх зохион найруулж бичих
- Өөрийн болоод бусдын зохиосон эхийг засаж сайжруулах

Өгүүлбэр:

- Асуух, хүүрнэх, захирах, анхааруулах өгүүлбэрийг таних, ялган бичих,
- зөв унших, утгыг тайлбарлах
- Өгүүлбэрийн хэлэх зорилгыг өөрчлөн бичиж найруулах
- Өгүүлбэрийг утгаар нь зүйлчлэх
- Утгаараа ойролцоо ба эсрэг өгүүлбэрийг таних
- Хураангуй ба дэлгэрэнгүй өгүүлбэрийг ялгах
- Өгүүлбэрийг хурааж, дэлгэрүүлж бичих
- Зөв бүтэцтэй, найруулгын алдаагүй өгүүлбэр зохиох
- Өгүүлбэр дэх үгсийн холбоог олох
- Цэг, тэмдгийг зөв бичих, зөв унших



Үг:

- Нэрлэх, асуух, заах, төлөөлөх үгийг ялгах, тайлбарлах
- Үгсийг утгаар нь зүйлчлэх
- Харь үг ба уугуул үгийг ялгах, зөв бичих, зөв унших
- Энгийн ба нийлмэл үгийг таних, тайлбарлах
- Үгээс холбоо үг бүтээх, холбоо үгийг үг болгон задлах
- Үгээс төрөл үг, төрөл үгийн үүр үүсгэх
- Үгийн салаа утгыг таних, тайлбарлах
- Нийлмэл үгийн байрыг тонгоргох, товчлон хураах
- Ярьж бичихдээ этгээд, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байх

Бүтээвэр:

- Нэр ба үйл үгийн түгээмэл хэрэглэгддэг нөхцөлийг нэрлэх, утгыг тайлбарлах
- Язгуур, задгавар бүтээрийн байр, утга, үүргийг тодорхойлох
- Бүтээврийн тоо цөөн, зааг нь тодорхой үгсийг задалж, тайлбарлах
- Үг бүтээврийн бүтцэд байгаа авиа, үгсийн харьцааг тодорхойлох, тайлбарлах
- Эгшиг ба гийгүүлэгч авианы нийтлэг ба ялгарах шинжийг тайлбарлах
- Зөв бичих дүрмийн алдаагүй бичих
- Үгсийн бүтээврийн нийлцийг зөв бичих, холбогдох дүрмийг жишээгээр тайлбарлах

Б. МАТЕМАТИК

Математикийн хичээлээр дор дурдсан чадварыг эзэмшинэ.

- Тоог унших, бичих, тоймлох, жиших
- Нэмэх, хасах, үржих ба хуваах үйлдлийн тусламжтайгаар ахуйн хялбар тооцооллыг гүйцэтгэх
- Илэрхийлэл, тэгшитгэл, тэнцэтгэл бишээр загварчлан асуудлыг шийдвэрлэх
- Геометрийн хялбар бие ба дүрсийг ялгаж таних, дүрслэх
- Дүрсийн периметр ба талбайг хэмжих, биеийн эзэлхүүнийг олох
- Хүндийг хэмжих
- Цаг хугацааг хэмжих, тооцоолох
- Тоон мэдээллийг хүснэгт, диаграммаар илэрхийлэх
- Хүснэгт, диаграммаар илэрхийлсэн мэдээллийг уншиж ойлгох, өгөгдлийг ашиглан холбогдох тооцоо хийх



- Замын урт олох, хурд, хугацааг тооцоолох гэх мэт хөдөлгөөний энгийн бодлого бодох
- Ажиглалт, туршилт хийх, боломж тоолох, үр дүнг урьдчилан таамаглах, шалгах
- Юмсын хэмжээг хэсэглэн хуваах, хэсгийн хэмжээг тооцоолох, тэмдэглэх
- Хэсэг, процентийн бодлого бодох, ахуйн хялбар асуудлыг шийдвэрлэхэд ашиглах

В. ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

Дүрслэх урлаг, технологийн хичээлээр дор дурдсан чадварыг эзэмшинэ.

- Материалын гадаад байдлыг ажиглах, харьцуулж ялгах
- Байгалийн материалыг боловсруулах, загварчлах, ахуй амьдралдаа хэрэгтэй эд зүйлс зохион бүтээх
- Загварын ангилалыг мэдэх
- Хялбар хийцтэй загвар зохион бүтээх
- Зарим техникийн зориулалтыг тайлбарлах
- Зохиосон загварынхаа тусламжтайгаар түгээмэл хэрэглэгдэг техникийн төрөл, тэдгээрийн бүрдэл хэсгийг нэрлэн тайлбарлах
- Геометрийн биетүүдийг нэрлэх
- Геометрийн биетүүдийг янз бүрийн аргаар бүтээх, загварчлах
- Геометрийн биетүүдээр хүрээлэн байгаа орчны юмсын хэлбэрийг тайлбарлах
- Хялбар дүрсийг зурах, загварчлах
- Дугуйн талбайг хэмжих

Г. ХҮН БА БАЙГАЛЬ, ЭРҮҮЛ МЭНД

Хүн ба байгаль, эрүүл мэнд хичээлээр дор дурдсан чадварыг эзэмшинэ.

I Түвшин

- Сургууль, гэр орчны байгалийг нэрлэх, зүг чигийг нэрлэх
- Амьгүй ба амьд байгалийг ялгах, нэрлэх
- Орчиндоо түгээмэл тархсан амьтдыг нэрлэх, зурах
- Орчиндоо түгээмэл тархсан ургамлыг нэрлэх, онцлогийг тайлбарлах
- Таван хошуу малын маллагаа, ашиг шимийг тайлбарлах, өдөр тутамдаа ашиглах



II Түвшин

- Амьд байгалийн онцлогийг тайлбарлах, зургийн өнгийг тохируулан зурах
- Ургамал ургахад нөлөөлөх зүйлийг нэрлэх, бичих, зурах
- Амьд бие амьсгалах, хөдлөх, ургах үзэгдлийг жишээгээр нэрлэх
- Ургамлыг зурж бүтцийг нь тайлбарлах
- Тэжээвэр ба зэрлэг амьтдын нэрийг бичих, зурах, эдгээр амьтдын хоол тэжээл, орон
- Байрны онцлогийг жишээгээр тайлбарлах
- Шавьж шувуудын нэрлэх, бичих, зурах
- Амьтан ургамлыг хамгаалах ажилд оролцох

III Түвшин

- Ой тайгийн ургамал амьтдыг нэрлэх, бичих, зурах, орон
- Нутгийн жишээгээр тайлбарлах
- Хээр талын ургамал амьтдын нэрийг бичих, онцлогийг тайлбарлах, ашиг шим, арчилгааг жишээгээр нэрлэх
- Говь цөл нутагт ургадаг ургамал, амьдардаг амьтдын онцлогийг зургаар тайлбарлах, тайлбарыг бичих

IV Түвшин

- Бие, бодисыг ялгах, туршилтаар батлах
- Нар, сар, од гариг зурах, байршлыг нь зурах, нэрийг бичих
- Агаарын шинж чанарыг туршилтаар харуулах, тайлбарлах
- Усны гурван төлөвийг туршилтаар харуулах, тайлбарлан бичих
- Хөрсний шинж чанарыг туршилтаар харуулах, хөрс хамгаалах ажилд хамтран оролцох

V Түвшин

- Амьд биеийн хөдөлгөөний онцлогийг зурах, хүснэгт загвараар тайлбарлах
- Амьгүй ба амьд биеийн харилцан холбоог зургаар тайлбарлах, бичих
- Хоол тэжээлийн холбоог зургаар харуулах, орон нутгийн жишээн дээр тайлбарлан ярих



ХАВСРАЛТ 2

БАТЛАВ:

ЗАХИРАЛ/

БОЛОВСРОЛ НӨХӨН ОЛГОХ СУРГАЛТАД ГЭРЭЭР СУРАХ СУРАЛЦАГЧИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧТАЙ БАЙГУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ГЭРЭЭ №...

Энэхүү хамтын гэрээг нэг талаас аймгийн сумын НТБТ-ийг төлөөлж ажилтай
....., нөгөө талаас дүйцсэн хөтөлбөрийн сургалтын түвшинд суралцагч-ны эцэг эх, асран хамгаалагчийг төлөөлж /аав, ээж, ах, эгч, эмээ, өвөө, бусад/
.....овогтой нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Гэрээнд оролцогч талууд Монгол улсын Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүүхдийн эрхийн конвенц, Боловсролын, соёл, шинжлэх, ухаан, спортын, сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого" болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Нэг. Ерөнхий зүйл:

1.1. Энэхүү гэрээний зорилго нь гэрийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч хүүхэддээ тавих анхаарал халамж, хараа хяналтыг сайжруулж, хүүхдийн сурах эрхийг хангах, боловсрол нөхөн эзэмших сургалтыг багшийн тусламжтай удирдан чиглүүлэхэд талууд хамтран ажиллахад оршино.

Хоёр. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг:

2.1. Хүүхдийнхээ нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг танин мэдэж, хүүхдээ ойлгож, дэмжин туслах замаар гэрээр боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;



- 2.2. Гэрт эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх;
- 2.3. Хүүхдийн эрүүл мэндэд анхаарах, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, эрүүл мэндийг сахин хамгаалах;
- 2.4. Хүүхдэдээ зайнаас сурах боломжийг бүрдүүлэх: шаардлагатай техник тоног төхөөрөмж, сурах бичиг, хичээлийн хэрэглэлээр хангах;
- 2.5. Гэрээр сурах үеийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг багштай хамтран гаргах, өдөр тутам мөрдөх;
- 2.6. Хүүхдээ гэрээр хичээллүүлэх үед багштай байнга холбоотой хамтран ажиллах, шаардлагатай үед багшийн зөвлөгөө, тусламжийг авах;
- 2.7. НТБ-ын төвөөс зохион байгуулах эцэг эхийн цаг, сургалт болон бусад арга хэмжээнд цаг тухай бүрд оролцох;
- 2.7. Хүүхдийнхээ хичээл сургалтыг тасалдуулахгүй, хуваарийн дагуу хичээллүүлэх;
- 2.8. Графикийн дагуу гэрээр ирж сургалт явуулах, үйлчилгээ үзүүлэх багш, ажилтны аюулгүй байдлыг хангах;
- 2.9. Багш, ажилтны нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүйбайх, тэдэнтэй хүндэтгэлтэй харилцах;
- 2.10. Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн тохиолдолд багшид даруй мэдэгдэх;
- 2.11. Гэрээр сурах үед гарах санал хүсэлт, гомдлыг баримт нотолгоонд үндэслэн НТБТ-ийн удирдлагад тавих.

Гурав. Насан туршийн боловсролын төвийн эрх, үүрэг:

- 3.1. НТБТ нь хүүхдийн ар гэр, эцэг эх, асран хамгаалагчийн талаарх үнэн зөв мэдээлэл, судалгааг авах;
- 3.2. Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн хувийн мэдээллийн нууцыг чанд хадгалах;



- 3.3. Гэрээр сургалт зохион байгуулахад оролцох эцэг эх, асран хамгаалагчдыг бэлтгэл сургалтад хамруулах, сургалтын явцад зөвлөгөөгөөр хангах, хамтран ажиллах;
- 3.4. Суралцагч эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувийн мэдээллийн нууцыг чанд хадгалах;
- 3.5. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийг боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчдын саналыг тусгах;
- 3.6. Өөрийн хүчээр гэрээр сургалт зохион байгуулах боломжгүй ар гэрт сайн дурын туслагчдын багийг санал болгон ажиллуулах;
- 3.7. Гэрээр сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцөл, бололцоогоор хангах: багш, сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн зэрэг;
- 3.8. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийн дагуу хичээл сургалтыг гэрээр зохион байгуулах, хичээл сургалтын явцад хяналт тавих;
- 3.9. Багш, суралцагч болон түүний эцэг эх, асран хамгаалагчдад шаардлага тавих, хамтран ажиллах, зөвлөгөө өгөх;
- 3.10. Багш, суралцагчийг гэмт хэрэг, хүчирхийлэл, хорт зуршил, болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, санамж өгөх, зохих арга хэмжээг урьчилан авах;
- 3.11. Хуваарийн дагуу суралцагчидтай гэрээр ажиллах үеийн унаа тэрэг, тос шатахууны асуудлыг шийдвэрлэж өгөх;
- 3.12. Багш, ажилтан нь суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийг мэдлэг боловсрол, хэл соёл, яс үндэс, ажил эрхлэлт, албан тушаал, амьжиргааны түвшин, эрүүл мэндийн асуудал зэргээр ялгаварлан гадуурхахгүй, адил тэгш хүндлэлтэй, соёлтой харилцах;
- 3.13. Гэр сургалтхариуцаж буй багш хүүхдийн эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон эцэг эх, асран хамгаалагчийн талаар насанд хүрээгүй суралцагчаа төлөөлөн зохих байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

Дөрөв. Бусад

- 4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцогдоно.
- 4.2. Гэрээ нь 2020 оны ... дүгээр сарын ... –ний өдрөөс 2020 оны ... дугаар сарын ... -ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.



- 4.3. Гэрээг сургалтын эхэнд байгуулж, сургалтын эцэст дүгнэнэ.
- 4.4. Гэрээг дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй төв, багш, эцэг эх, асран хамгаалагчийг Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НТБТ-ийг төлөөлж

ЭЦЭГ ЭХИЙГ ТӨЛӨӨЛЖ

Нийгмийн ажилтан: / / овогтой

Багш: /

Холбоо барих утас:

Холбоо барих утас:

.....

.....

оны дүгээр сарын-ний өдөр



ХАВСРАЛТ 3

СУРГУУЛИЙН ГАДНА БУЙ СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙГ ИЛРҮҮЛЭХ СУДАЛГАА

№: 	Аймаг/дүүрэг	
	Сум/хороо	
	Баг/хэсгийн дугаар	

Судалгааны зорилго: Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдүүдийг илрүүлэн зохих шатны боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах.

Судалгаа авахад анхаарах зүйлс:

- Сургуулийн гадна буй (сургуульд огт ороогүй болон зохих ангиас завсардсан) 6-18 насны хүүхдийг хамруулна.
- Судалгааг бүрэн гүйцэд 2 хэлбэрээр бөглөнө:
 - Нөхөж бичих шаардлагатай нүдийг гаргацтай бичнэ.
 - Хариултыг сонгон арын нүдэнд буй харгалзах тоог дугуйлна.

Жишээлбэл:

2	Хүйс	Эрэгтэй	1
		Эмэгтэй	2

- “Тийм, үгүй” гэсэн хариултын ард бичигдсэн дугаарын асуултад заавал хариулна.

Жишээлбэл:

1	Сургуульд сурч байсан эсэх:	Тийм /1а/	1
	(аль нэгийг сонгоно уу)	Үгүй /1б/	2

- “Бусад” гэсэн хариултыг сонгосон тохиолдолд арын нүдэнд буй харгалзах тоог дугуйлахаас гадна цэгийн оронд тодорхой хариултыг нөхөн бичнэ.

Жишээлбэл:

3б	Үгүй бол, хамрагдаагүй шалтгаан	Гэр сургуулиас хол	1
		Мэдээлэл байхгүй	2
	(хэдэн ч хариулт сонгож болно)	Бусад	3



А ХЭСЭГ

№	Асуулт	Хариулт
1	Овог	
2	Нэр	
3	Төрсөн он	
4	Нас	
5	Хүйс	
6	Регистрийн дугаар	
7	Гэрийн хаяг	
8	Холбоо барих утас	

Б ХЭСЭГ

№	Асуулт		Хариултын хувилбар		Сонгох хэсэг
1	Сургуульд сурч байсан эсэх: (аль нэгийг сонгоно уу)		Тийм /1а/		1
			Үгүй /1б/		2
1а	Тийм бол, сургууль завсардсан	Анги (нөхөж бичнэ үү)			
		Он (нөхөж бичнэ үү)			
		Шалтгаан (хэдэн ч хариулт сонгож болно)	Хөгжлийн бэрхшээл	1	
			Эрүүл мэнд /өвчний улмаас тодорхой хугацаанд завсардсан/	2	
			Ар гэрийн гачигдал	3	
			Шилжилт хөдөлгөөн, бичиг баримтын бүрэн бус байдал	4	
			Хөдөлмөр эрхлэлт	5	
			Багш нарын таагүй харилцаа, гадуурхалт	6	
			Үе тэнгийнхний дарамт, ялгаварлал	7	
			Сурах сонирхолгүй	8	
			Бусад	9	



16	Үгүй бол, сургуульд огт ороогүй шалтгаан (хэдэн ч хариулт сонгож болно)	Хөгжлийн бэрхшээл	1
		Эрүүл мэнд /өвчний улмаас тодорхой хугацаанд завсардсан/	2
		Эцэг эхийн хариуцлагагүй байдал	3
		Ар гэрийн гачигдал	4
		Бичиг баримтын бүрэн бус байдал	5
		Сурах дургүй	6
		Бусад	7
2	Хөгжлийн бэрхшээлийн улмаас сургууль завсардсан бол, бэрхшээлийн төрлийг сонгоно уу. <i>(хавсарсан бэрхшээлтэй бол тухайн бэрхшээл тус бүрийг сонгоно)</i>	Харааны	1
		Сонсголын	2
		Хэл ярианы	3
		Тулгуур эрхтний	4
		Оюун ухааны	5
		Бусад	6
3	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байсан эсэх <i>(аль нэгийг сонгоно уу)</i>	Тийм /3а/	1
		Үгүй /3б/	2
3а	Тийм бол, суралцаагүй шалтгаан (хэдэн ч хариулт сонгож болно)	Хөгжлийн бэрхшээл	1
		Эрүүл мэнд /өвчний улмаас тодорхой хугацаанд завсардсан/	2
		Ар гэрийн гачигдал	3
		Шилжилт хөдөлгөөн	4
		Хөдөлмөр эрхлэлт	5
		Багш нарын таагүй харилцаа, гадуурхалт	6
		Үе тэнгийнхний дарамт, ялгаварлал	7
		Сурах сонирхолгүй	8
		Гэр сургуулиас хол	9
		Бусад	10
3б	Үгүй бол, хамрагдаагүй шалтгаан (хэдэн ч хариулт сонгож болно)	Гэр сургуулиас хол	1
		Мэдээлэл байхгүй	2
		Бусад	3

Судалгааг үнэн, зөв бөглөсөн Танд баярлалаа



ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Сурагчийн бодит байдлын судалгаа		Сургуулийн эмнэлэг, сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ дүгнэлт: <table border="1"> <tr> <td>2</td><td>0</td><td>1</td><td>9</td><td>1</td><td>1</td><td>3</td><td>0</td> </tr> </table> огноо:2019-11-30 Эмнэлгийн оноштой бол эмнэлгийн оношийг бичнэ Онош: ☐ Оюун ухааны хөгжлийн бэрхшээл ☐ Харааны бэрхшээл ☐ Тулгуур эрхтний бэрхшээл ☐ Сонсголын бэрхшээл ☐ Аутизмын хүрээний эмгэг ☐ Дауны синдром ☐ Хэл ярианы бэрхшээл ☐ Суралцах бэрхшээл ☐ Сэтгэл хөдөлгөөний эмгэг ☐ Бусад - Хавсарсан эмгэг/өвчний тухай мэдээлэл:		2	0	1	9	1	1	3	0		
2	0	1	9	1	1	3	0						
Сургуулийн комиссын хуралдааны огноо <table border="1"> <tr> <td>2</td><td>0</td><td>1</td><td>8</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>5</td> </tr> </table> Сурагчийн овог, нэр: А.Э		2	0	1	8	1	1	1	5	Сургуульд элсэн орсон огноо, (нас) 2018-11-15 Тухайн суралцагчийн бичиг баримтыг үндэслэн бичнэ.			
2	0	1	8	1	1	1	5						
Регистрийн дугаар: <table border="1"> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td> </tr> </table>												Хүйс: эмэгтэй	
Амгийн бүлэг: 4		Төрсөн огноо: 2008-11-30											
Ам бүлийн тоо: 2		Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд: Ээж											
Гэр бүлийн харилцааны төлөв байдал: Бичиг баримтыг үндэслэл болгоно.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр:											



Цэцэрлэгт явсан эсэх (тийм/үгүй)	Эцэг эх асран хамгаалагч/-ийн нэр: Ээж А нь амьдралын баталгаат түвшингээс нэн доогуур тул хүүхдээ асран халамжлах боломжгүйн улмаас ХЗСХТЦ-т өгсөн болно. Холбоо барих утас: 88..... И-мэйл хаяг:@uahnoo.com гэх мэт	Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх: (тийм/үгүй) Хэрэв тийм бол, Онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр: Онош: Тухайн үзлэг оношилгоо хийсэн эмчийн оношийг хавсаргана.	Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх: (тийм/үгүй) Хэрвээ тийм бол, сорилын нэр: Үнэлгээ хийсэн байгууллагын нэр: ХЗСХТЦ-ын эмч У үзлэг хийж Э-г чихний нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай гэсэн байв. Үнэлгээний үр дүн: Дүгнэлтийг бичнэ.
Оршин суугаа хаяг: УБ хот, БЗД, 8 хороо, тоот		Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: (тийм/үгүй) Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан онош, хяналтын давтамж: Давтан үзлэг огт хийгдээгүй болно.	
Төрсний дараах /0-24 сар хүртэл/ үеийн хөгжлийн түвшингийн онцлог байдал)	Хэвийн: Эрүүл мэндийн цагаан дэвтэр нь ээж дээрээ байдаг. Асрах төвд ирэхдээ эрүүл мэндийн дэвтэргүй ирсэн.		
Сургуульд бэлтгэсэн байдал (0-5 нас)	Цэцэрлэгт огт явж байгаагүй		Сонсгол сулавтар, чангаар ярьж ойлголцдог. Анги нийтийн дунд хичээл тайлбарлахад бүрэн гүйцэд сонсдоггүй. Өөрийнх нь ойролцоо сууж хичээлийг тайлбарлан өгөх шаардлагатай. 3 дугаар анги төгссөн хэдий ч 1 дүгээр ангийн түвшингтэй. Унших, бичих чадвар дунд зэрэг болно. Цаашид ганцаарчлан ажиллах шаардлагатай байв.



ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал	Өөртөө үйлчлэх энгийн чадварууд	Хувцсаа сольж өмсөх чадвар сайн. Ариун цэвэр сахиx тал дээр бусдын туслалцааг байнга авдаг. Сургуульдаа ирж очихдоо харгалзах хүнгүйгээр явах боломжгүй тул заавал багш болон асран хамгаалагчтай явдаг. Бие даан нийтийн тээврээр үйлчлүүлэх, дэлгүүр явах, бусдад туслах чадваргүй.
	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Өнгө, хэлбэр дүрс, тоо, хэмжээг ойлгох чадвартай хэдий ч их удаан. Унших чадвар үелдэг. 3-аас дээш үетэй үгийг огт уншдаггүй. Ц, Ж, З авиаг ялгахгүй, авиаг дуудах ялгаж сул. Хэл яриа болон авианд өөрчлөлт орсон. Аливаа зүйлийг ялгах төстэй зүйлээр орлуулах чадамж сул байгаа нь танил бус орчинд дасаагүй болно.
	Нийгэмшил	Найз нөхөдтэйгээ тоглохдоо дургүйцдэг. Ганцаараа байх дуртай. Тоглоомоор хамтран тоглох, дараалал хүлээх, хариуцлага хүлээх чадварт суралцах шаардлагатай. Сэтгэлзүйн байдал нь эмээг, өөртөө итгэлгүй, аймхай.
	Бие бялдар, хөдөлгөөн	Биеийн хөдөлгөөн удирдах байдал хэвийн. Орон зайн баримжаа бага зэрэг алддаг. Алхах гүйх, нүд гарын хөдөлгөөнөө удирдах чадвартай. Зураг зурах, шүр хэлхэх, товч товчлохдоо болхидуу. Үдээс үдэх, тайлах чадвартай.
	Сурагч	- Хүссэн үлгэрийн номоо хурдан уншдаг болох - Олон найзуудтай болж хамтдаа тоглох - Хүүхдүүдэд шоолуулахгүй байх
Оролцогч талуудын хүсэл зорилго:	Эцэг эх /асран хамгаалагч/	- Үе тэнгийн хүүхдүүдийн адил унших, бичих, тоо бодох чадвартай болох - Авьяас чадварыг нээн хөгжүүлэх - Бие даан өөрөө өөртөө үйлчлэх чадварт сурах
	Багш	- Унших бичих чадварыг ахиулах /3-4 үетэй үгийг уншиж, зөв бичих чадварт сургах/ - 2-3 оронтой тооны нэмэх, хасах, үржих, хуваах, үйлдлийн дарааллыг зөв олох - Өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх - Бусадтай харилцах бие даан өөртөө үйлчлэх энгийн чадварт сургах

Тэмдэглэл хөтөлсөн багшийн нэр гарын үсэг: /Б.Оюун-Эрдэнэ/ огноо:

Танилцсан эцэг (эх асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг: /ХЭСХТЦ-ын багш / огноо:

Урт хугацааны зорилт:

Эцэг эхтэй ярилцсаны дагуу 3 жилийн дараа хүрч болох үр дүнгийн жагсаалтыг гаргана. Өөрөөр хэлбэл, эцэг эхтэй ярилцан тэдний хүсэлтийг сонсож бичнэ. Тухайлбал хүүхэд маань хөгжсөн байгаасай одоо

..... бэрхшээлүүд байна гэх мэт/

		Дэмжлэгийн орчин			
Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулсан үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг	
Өөртөө нийлчлэх зорилт	- Бусдын тусалцаагүйгээр ариун цэврээ сахихад болох - Сургуульдаа ирж очихдоо харгалзах хүнгүйгээр явж сурах - Бие даан нийтийн тээврээр үйлчлүүлэх, дэлгүүр явах, бусдад туслах	- Сургууль ангид, завсарлагааны цаг болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар - Амьдралын турш	 тэмдэг тэмдэглэгээг ашиглан өөртөө үйлчлэх чадварт бэлтгэх	Эрүүл мэнд Иргэний боловсрол Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	
	- Өнгө, хэлбэр дүрс, тоо, хэмжээг ойлгох - Богино эхийг уншиж агуулгыг өөрийн үгээр бусдад ярьж сурах - Ахуйн хялбар тооцоолол хийх, 100 дотор нэмэх, хасах, үржих, хувааж сурах - Аливаа зүйлийг ялгах төстэй зүйлээр орлуулах чадамжийг сайжруулж танил бус орчинд дасах	- Олон дүрсээс бүтсэн зураглалыг өнгө ялгуулан будуулах - Богино эх, бяцхан ном уншуулах цагтай болох - Эх дээр ажиллуулах	Өнгө дүрсийг ялгуулж, дүрсүүдийг эвлүүлэх тал дээр анхаарч ажиллах Танграмм ашиглах  Бяцхан ном бэлтгэн уншуулах, уншсан эхийг өөрийн үгээр яриулах	Монгол хэл Математик Дүрслэх урлаг Өөрт нь тохирсон жишиг даалгаврын сантай болох	
Нийгэмшил	- Үе тэнгийн найз нөхөдтэйгээ зөв харилцах, өөрийгөө илэрхийлэх чадвартай болох - Сэтгэлзүйн байдал нь тогтвортой, өөртөө итгэлтэй, зоригтой болох	- Өдөр бүр багш, анги хамт олны дунд зохиогдсон ажилд татан оролцуулах - Уралдаан тэмцээн	Бяцхан ном хийлгэх	Хүн нийгэм Иргэний боловсрол	

Дунд хугацааны зорилт:

Нэг жилийн хугацаанд хүрч болох үр дүнг багш бичнэ. Өөрөөр хэлбэл: Нэг хичээлийн жилийн туршид хичээллэсний дараа тухайн хүүхэд ямар чадвартай болсон байх вэ? гэдгийг зорилт болгоно.





Богино хугацааны зорилт:

Улирал бүрийн эцэст тухайн хүүхэд ямар чадвартай болсон байх вэ? гэдгийг багш бичнэ. Улирлын зорилтууд нь дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэхүйц байхаар тодорхойлогдсон байна.

Дэмжлэгийн орчин (хэзээ, хаана)	Богино хугацааны зорилт	Сурагчийн хийх үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг, арга зүй	Улирлын үнэлгээ		
				Сурагчийн үнэлгээ	Багшийн үнэлгээ	Үнэлгээ өгсөн хүний нэр
Математик /зөвхөн математикийн хичээлний жишээ дээр/	I улирал	1 дүгээр улиралд огт суугаагүй				
	II улирал	2-р улирлын дундуур ирсэн болно. 1-100-ийн дотор нэмэх, хасах үйлдэл хийх, үйлдлийн дараалал зөв олж сурах	Багш бичиглэл ашиглан нэмэх, хасах үйлдэл хийх Багшийн хэлсэн тоог сонсоод цээжээр бичиж бодох	Өөрийгөө сорих дасгал даалгаврыг ажиглаад зөв хариуг тулган хянах	2 оронтой тооны нэмэх, хасах үйлдлийг 3 үйлдлийн дарааллын дагуу зөв гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлэх /ТТШ/ авах	АУБ
	III улирал	1-10 хүртэлх тооны хүрд таниулах, цээжлүүлэх 1-100-ийн дотор үржих, хуваах, нэмэх, хасах үйлдэл хийх, үйлдлийн дараалал зөв олж сурах	1-10 хүртэлх тооны хүрдийг ижил тооны орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр олж хүрд зохион мэдлэг бүтээх Жишээлбэл: $2+2+2+2+2$ $2 \times 5 = 10$ 5 2 оронтой тоог баганаар бичиглэлээр үржүүлж, хуваах	Тайлбартай дасгалын арга Тарааж өгөх материал ашиглан мэдлэг бүтээлэх 	2 оронтой тооны нэмэх, хасах, үржих, хуваах үйлдлийг баган бичиглэл ашиглан зөв бодох Үржвэрийг хуваах үйлдэл хийж өөрийгөө шалгана. Ногдворыг Үржвэрээр хариуг шалгах	АУБ Асран хамгаалагч
	IV улирал	Өгүүлбэртэй бодлого бодох Үл мэдэгдэх гишүүнийг олох Зүй тогтлыг олох Илэрхийлэл бодох	Богино бичвэртэй өгүүлбэртэй бодлогыг уншиж бичиглэл хийн бодлого бодох Тэгшитгэл бодох Илэрхийлэл бодох, зохиох	Өөрийгөө сорiorой даалгавар ажиллан хариуг тулгах	Хялбар ахуйн тооцоолол хийж чадаж буй эсэх 100 дотор нэмэх, хасах, үржих, хуваах үйлдэл хийж чадсан байдлыг үнэлнэ.	

Төлөвлөгөө гаргасан багш: БЗД-ийн НТБТөвийн багш Б.Оюун-Эрдэнэ /...../



Нэгдсэн үнэлгээ, зөвлөмж

№	Хамрах хугацаа	Дүгнэлт			Үнэлгээ бичсэн анги удирдсан багш	Танилцсан эцэг эх, асран хамгаалагч/-ийн нэр
		Ололт амжилт	Алдаа дутагдал	Сайжруулах чиглэл, зөвлөмж		
1	Жилийн эцэс	- Богино эх буюу 30-35 үгтэй эхийн гол санааг ойлгон бүтэн өгүүлбэрээр ярих чадвартай болсон. - Өөртөө итгэх итгэл нэмэгдэж, хичээлдээ оролцдог боллоо. - Гэрийн даалгавраа бие даан гүйцэтгэдэг чадварт суралцаж байгаа - Олон нийтийн газрын тэмдэг тэмдэглэгээг ялгаж таньдаг болов.	- Төсөөлөн бодох чадварт суралцах чадвар сулавтар, цаашид хөгжүүлэх шаардлагатай. - Зарим нэг эхэд байгаа хүнд үгийн утгыг ойлгоогүйгээс болгоод даалгавраа буруу хийж байна. - Сонсоод цээжээр бичихдээ ганцаарчлан хэлүүлж бичдэг бөгөөд зарим дүрмийн алдаа гаргаж байгаа.	- Дараагийн жилд аливаа зүйлийг төсөөлөн бодох, сэтгэх, хийсвэр утгатай үгийг ойлгуулах даалгавруудыг бэлтгэн ажиллах - Хүүхдийн унших бичих эхүүдийг хялбаршуулан жишиг даалгавар боловсруулан ажиллах - Харилцан ярилцах нийгмийн идэвхийг сайруулан дугуйланд хамруулан сургах - Бие даан сурах бичигтэй ажиллуулж сургах	Б.Оюун-Эрдэнэ	Охины ээж А..... гэж бичүүлж гарын үсэг зуруулна.



ХАВСРАЛТ 5

ГЭРЭЭР СУРАЛЦАГЧ ХҮҮХДИЙН АХИЦ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ, СУДАЛГАА

(Нийслэлийн Баянзүрх дүүргийн АБ-НТБТ-ийн
багш Б.Оюун-Эрдэнийн туршлагаас)

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын мэргэжлийн эмчийн үзлэгийн бие даах чадварын үнэлгээ:

1. Хооллох – 0,
2. Хөдөлгөөн – 0,
3. Усанд орох – 0,
4. Хувцаслах – 0,
5. Бие засах – 0,
6. Өтгөн шингэн -2.

Хүүхдэд сэргээн засах эмчилгээ байнга хийгдэх шаардлагатай.

Хоёр. Хүүхдийн эрүүл мэнд, биеийн байдлын талаар багшийн хийсэн сургалтын өмнөх үнэлгээ (мэдээллийг О.Д-ийн эцэг эхтэй ярилцлагын хэлбэрээр авсан болно).

а. Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл:

1. Овог нэр: О... Д...
2. Төрсөн он, сар, өдөр: 2010 оны 03 сарын 11-ний өдөр.
3. Нас, хүйс: 9, эр
4. РД: УА
5. Төрсөн газар: Улаанбаатар хот
6. Гэрийн хаяг: БЗД-ийн 5-р хороо ...
7. Холбоо барих утас: 99...
8. Сургуульд орж байсан эсэх: огт орж байгаагүй
9. Сургуульд ороогүй шалтгаан: хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн байдаг.

б. Хүүхдийн эрүүл мэнд, биеийн байдал:

Д нь 4-н мөчний чангаралтай (дээд, доод мөч хоёулаа саажилттай: хоёр гар нь дотогшоо эргэж, сарвуугаараа нугарсан, гар хөл нь хатингиршсан),



толгой болон биеэ даадаггүй, сууж чаддаггүй, өөрийн биеийн хэсгүүдийг мэдэрдэггүй (булчингийн чангарал ихтэй, байнга хэвтэрт байдаг, гар хөлөө өөрийн хүссэнээр хөдөлгөж чаддаггүй, бусдын дэмжлэгтэйгээр хөдөлгөөнд ордог, их биеийн араг ясны хөгжил өөрчлөлттэй), нүдний харааны мэдрэмж болон сонсгол хэвийн, гэвч ярих чадвар сул, авиа гаргахдаа гацаж, өөрийгөө хүчилж дутуу гаргадаг, булчин чангарсан үед ярьж чаддаггүй. Хэл ярианы бэрхшээлтэй хэдий ч өөрийгөө ойлгуулж чаддаг, хүний хэлснийг ойлгодог. Биеийн өсөлт, хөгжил хоцрогдолтой, өөртөө үйлчлэх боломжгүй.

Гурав. Ахуй амьдралын байдалд багшийн хийсэн дүгнэлт:

1. Ам бүл: 5-лаа: аав, ээж, 2 дүүгийн хамт амьдардаг.
2. Эцэг эхийн эрхэлдэг ажил: Аав нь зах дээр, хувиараа бизнес эрхэлдэг.
Ээж нь хүүхдээ хардаг. Хааяа цагийн ажил хийдэг.
3. Өрхийн орлого: Хүүхдийн асаргааны 70000 төгрөг, аав нь өдөрт 10000 төгрөг олдог хэдий ч тогтмол биш.
5. Амьжиргааны түвшин: Нэн ядуу
6. Амьдралын нөхцөл байдал: Дунджаас доогуур
7. Өргөмөл, өнчин, хойд аав, ээжтэй эсэх: Үгүй
8. Хүүхдэд хандах гэр бүлийн гишүүдийн харьцаа (хэт эрхлүүлэх, шоовдорлох, аашлах, ад үзэх гэм мэт) Ээж, аав эрхлүүлдэггүй, шоовдорлодоггүй, ад үздэггүй, байнгын хажууд нь байж асарч тойлдог. Ээж нь хүүхдийг өргөж босгох, хооллох, бие засуулах, массаж хийх, эм өгөх, тариа хийх, эмчид үзүүлэх зэрэг асаргааны гол ажлыг гүйцэтгэдэг. 4-н мөчний саажилттай тул эцэг эх, асран хамгаалагчдын тусламжийг байнга авдаг.

Дөрөв. Хүүхдийн бие эрхтний байдлын судалгаа:

1. Биеийн ерөнхий төрх, байдал: 4-н мөчний таталттай.
2. Сэтгэл мэдрэлийн байдал: тогтворгүй
3. Тулах, хөдөлгөөний эрхтний байдал : маш муу
4. Өгүүлэх эрхтний байдал: дуу авиа гаргадаг, бага зэрэг дутуу авиагаар ярьдаг.



5. Хараа, харах эрхтний байдал: хэвийн
6. Сонсголын эрхтэн, сонсох байдал: хэвийн.
7. Хөдөлгөөний эвсэл: бие даан хөдөлгөөн хийх чадвартгүй. Гарыг нь барьж байгаад хөдөлгөөнийг хамтран хийхэд дуртай.

Тав. Хүүхдийн сэтгэл зүйн байдлын судалгаа:

1. Орчинтой харьцах чадвар: Хөдөлгөөн хийж чаддаггүй. Хүний хэлж ярьж байгаа зүйлийг маш сайн ойлгодог.
2. Өөрийн эцэг эх, орчин тойрныхоо тухай мэдэж буй эсэх: Ээж, аавыгаа таньдаг.

Зургаа. Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн байдал:

Сэтгэхүйн хөгжил: Сайн

- а. Гол зүйлийг ялгах чадвар: Сайн
- б. Дүгнэлт хийх чадвар: Дунд зэрэг
- в. Дүрс, өнгийг зөв ялгаж, дүрсийг дуурайлгах чадвар: Өнгө мэдэхгүй.
- г. Сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар: Дунд зэрэг
- д. Эвлүүлэх чадвар: Муу
- е. Төстэй ба төсөөгүй дүрсийг ялгах чадвар: Сайн
- ё. Сэтгэн бодох чадвар: Бодит зүйлсийн зургийг танина, нэрлэнэ, дуу аваг дуурайна.
- ж. Хэсгийг зөв олох чадвар: Дунд зэрэг
- з. Дутуу зүйлийг олох чадвар: Дунд зэрэг
- й. Өнгө дүрс ялгах чадвар: Сул
- к. Үйл явдлыг зөв ойлгож, зөв байрлуулах чадвар: Хэвийн сайн.

Долоо. Хүүхдийн ой тогтоолтын байдал:

Ой тогтоолт: Сайн

Найм. Хөдөлгөөний эвсэл:

Хөдөлгөөний эвсэл: Маш муу, гар, хөл таталттай. Бариа заслын эмчилгээ шаардлагатай.

Нарийн эвсэл: Маш муу

Энгийн эвсэл: Маш муу, гартаа юм барих чадваргүй. Таталт ихтэй, барьсан зүйлээрээ өөрийгөө цохих магадлал өндөр тул одоохондоо юм барих боломжгүй болно.



Ес. Тоолох чадвар:

Нэг нэгээр нь тоолох чадварт сургах шаардлагатай.

а. 1-10 хүртэл тоолох чадвар: 1-3 хүртэл тоолдог, цифр таньдаггүй.

б. Урвуу тоолох чадвар: Чадахгүй

в. Цифр таних чадвар: Таниулах шаардлагатай.

Арав. Зурах чадвар :

4-н мөчний таталттай тул үзэг, харандаа барих боломжгүй.

Арван нэг. Бичих чадвар:

Огт байхгүй.

Арван хоёр. Өгүүлэх эрхтний дуурайх чадвар: Авиа дуурайж чаддаг, авиаг дуудахдаа бэрхшээлтэй байдаг хэдий ч дотроо ялгаж чаддаг болно.

Арван гурав. Ажиллах чадвар: нямбай, 1-2 минут төвлөрч, тогтвортой байж чаддаг. Сонирхолтой зүйлээ хэдэн минут ч хамаагүй үздэг.

Арван дөрөв. Харилцааны гол арга: Хүний хэлж байгааг анхааралтай сонсож маш сайн ойлгодог. Нүдний харц, хөдөлгөөн, дуу авиа зэргээр өөрийгөө илэрхийлдэг.

Дүгнэлт: Хэл ярианы бэрхшээлтэй ч асуултанд хариулж чаддаг, танин мэдэх үйлийн явцад анхаарал сарнидаг, мэдрэхүйн сул хөгжилтэй, өөрийн биеийн хэсгүүдийг мэдэрдэггүй. Иймд хүүхдийн биед нь хүрэх болон биендээ хүргүүлэх зэрэг бодит мэдрэмжийг өгч ажиллахад багш, эцэг эх, асран хамгаалагчид анхаарах ёстой. Бодит зүйлсийг даган дуурайж хийх, барих, мэдрэх дасгалуудыг хүүхэдтэй хамтран хийх, гарын жижиг булчинг сайжруулах болон хийсвэр сэтгэлгээг нь хөгжүүлэх дасгал тогтмол хийлгэх шаардлагатай. Хүний ярьж, хэлж байгааг маш сайн ойлгож байгаа тул үсэг зааж, цээжээр тоо бодох чадварт сургах боломжтой. Иймд аливаа зүйлийг зааж сургахдаа давталтын тоог их байлгаж, үлгэрлэн хийлгэх замаар эцэг эхээр нь дамжуулан хамтран сургах боломжтой хэмээн үзэж сургалтыг эхлүүлсэн болно.



Юуны өмнө хүүхдийн эцэг эхийг богино хугацааны сургалтад хамруулж, тухайн хүүхдэд хичээлийг ямар давтамжтай, хэдэн өдөр, хэдэн цагаар хэн, яаж, ямар аргаар явуулах талаар эцэг эхтэй нь тохиролцон зохион байгуулсан болно. Хүүхдийн эрүүл мэнд, биеийн байдлыг харгалзан суралцагч О.Д-ийн хувьд 7 хоногт 2 удаа, 2 цагаар, 1 хичээлийг 20-25 минут үргэлжилхээр сургалтыг зохион байгуулж, сард нийт 24-32 цагийн хичээлийг зохион явуулж байсан ба хичээлийн цагийн хуваарийг хүүхдийн биеийн байдал, эрүүл мэндээс хамаарч өөрчилөн сар сараар гарган дараах байдлаар хийж байсан болно.

2019 он

№	Овог нэр	12 дугаар сар															
		I долоо хоног				II долоо хоног				III долоо хоног				IV долоо хоног			
		Мя	Лх	Пү	Ба	Мя	Лх	Пү	Ба	Мя	Лх	Пү	Ба	Мя	Лх	Пү	Ба
		3	4	5	6	10	11	12	13	17	18	19	20	24	25	26	27
1.	Д																
2.	Э																
Хичээлэх хугацаа		13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00	13.00-15.00	14.00-16.00

Суралцагч О.Д-д гарсан ахиц, өөрчлөлтийг багш дараах байдлаар тэмдэглэж явсан байна:

Хичээл	Өмнөх	Дараах
Тоо тоолол	Өмнөх 2 удаагийн хичээлээр 1-10 хүртэлх тоог тоолох, өгсүүлж, уруудуулж тоолох чадвартай болсон. Бодит үзүүлэн ашиглан тоо тоолж сурсан. Дараа нь бодит тоолсон зүйлсээ цифр лүү шилжүүлж чаддаг болов. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 өгсөх 10, 9, 8, 7, 6, 5, 4, 3, 2, 1 бууруулах	Үргэлжлүүлэн 10-100 хүртэлх цифр таниулах 10, 10-аар нэмэгдүүлэх хичээлийг орсон болно. Тэгш тоо: 2, 4, 6, 8, 10 Сондгой тоо: 1, 3, 5, 7, 9 гэх мэт. Тоог жиших <, >, = давтсан. 10-100 хүртэлх тоог 10, 10-аар нэмэгдүүлэх чадвартай болсон. 50 хүртэлх тоог мэддэг болсон. “Манжин” үлгэрээр нэмэх, хасах үйлдлийг заасан нь үр дүнтэй, мөн хүүхэд өөрөө илүү сонирхон хичээлээ сайн хийсэн. Мөн тоон даарааллыг маш сайн ойлгож чадсан. Тэгш, сондгой тоо яаж үүсдэгийг үлгэрийн үйл явдлаар ойлгосон. Цаашид аль болох тоглоомын аргыг ашиглах нь үр дүнтэй юм байна гэсэн дүгнэлтэд багш хүрсэн.



Дүгнэлт	Өмнөх хичээлээр 0-10 хүртэлх тоог өгсөж уруудуулж тоолох, цифр хараад тоог нэрлэж сурсан байлаа. Дараагийн шатны сургалтаар тэгш ба сондгой тоог ялгах, хөрш тоог нэрлэн олж чаддаг болсон. Мөн нэмэх хасах үйлдлийн чанарыг "Манжин" орос ардын үлгэрээр дамжуулан тоглоомын аргаар бодож сургаж. Цифрээр бичсэн тоон илэрхийллийг шууд цээжээр боддог болсон. Багшийн зохиосон өгүүлбэртэй бодлогыг төсөөлөн, цээжээр бодож чаддаг болсон. Цаашид 10, 20, 30, 40, 50, 60, 70, 80, 90, 100 хүртэлх тоог 10, 10-аар цээжээр нэмэгдүүлэн тоолох, 100 дотор нэмж, хасах үйлдлийг ээж аавынхаа тусламжтайгаар бие даан сурах боломжтой болсон гэж үзэж байна.	
Авиа таниулах	Өмнөх хичээлээр: Цагаан толгойн эгшиг үсгийг таниулж эхэлсэн. Харааны ойгоор дамжуулан амны хайрцгаар авиаг дуудах дасгал ажиллуулсан. а А Аа аа, э Э Ээ ээ, и И Ии ии, о О Оо оо, ой у У Уу уу уй, ай, эй, ой авиаг даган дуудах, давтах дасгалуудыг хийсэн. Хүүхэд амархан ядардаг тул давталттай зөв дуудах, өөр бусад ном сэтгүүл дээрээс үзсэн үсгээ нэрлээд багшийн зүгээс нэрлэсэн үгийг улаан өнгөөр будаж өгч нүдлүүлж байв. Өмнөх хичээлээр А, Э, И, О, У нийт 5-н эгшиг авиаг нэрлэж чаддаг болсон.	Ахиц сайн байлаа. Эгшиг болон 1-р шатны гийгүүлэгчийг үзэж дуусав. Дараах үеүүдийг уншиж холбодог болсон. Ы ы, ө Ө Өө өө, ү Ү Үү үү Аа, ээ, ий, оо, уу, өө, үү Ай, эй, ой, уй, үй, иа, ио, иу Гийгүүлэгч үсэг: м М Ма, мэ, ми, мо, му, мө, мү, ам, эм, им, ом, ум, өм, үм маа- м, а- мaa, э-мээ, а-муу, с С Са, сэ, си, со, су, сө, сү, ас, эс, ис, ос, ус, өс, үс саа- м, а- саа, а-суу, у- саа р Р Ра, рэ, ри, ро, ру, рө, рү, ар, эр, ир, ор, ур, өр, үр са-р, сэ-р, со-р, сө-р, сү-р сар - саар - сайр, сэр - сээр, х Х ха, хэ, хи, хо, х, хө, хү ах, эх, их, ох, ух, өх, үх хар, хэр, хор, хөр, хүр а-раа, э-рээ, о-роо, ө-рөө, у-руу ха- раа, хэ-рээ, хо-роо, ху-руу, хө-рөө, хариу гэх мэт үеийг унших дасгал хийж үелж уншдаг болсон. Жижиг бичвэр унших дасгал: Эмээ эм уу. Амаа эм уу. Эмээ эм амс. Амаа суу. Эмээ сэр.
Дүгнэлт	Өмнө нь үзсэн эгшиг үсэг дээрээ Ө,Ү эгшиг авиа, М,С, Р, Х гийгүүлэгч авиаг нэмж үзэж дууссан. Авиаг холбон үелэж унших дасгал ажлыг хийж бие даан үелэж уншдаг болсон ахиц гарсан. Хаяа Ө,Ү эгшиг үсгээ хэлэхдээ ялгамжгүй дуудах, бага зэрэг саатдаг хэдий ч нэрлэж чаддаг болсон. Мөн үелэн унших давтлага хичээлийг РР хэлбэрт оруулан бэлтгэж унших дасгал хийлгэв. Унших дасгалын хичээлийг цахим хэлбэрээр бэлтгэн уншуулах дасгал хийлгэх нь хүүхдийн сонирхолыг татаж, идэвхжүүлж байсан тул дараа дараагийн хичээлийг цахим хэлбэрт оруулан бэлтгэж сургалтад ашигласан нь үр дүнтэй байв.	



Суралцагчийг нийгэмшүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

- Суралцагчийн өөрийн хийх хүсэлтэй байгаа зүйлээ зөв илэрхийлдэг болгохын тулд багш асуулт - хариултын аргаар ярилцлага зохион байгуулдаг байв. Асуултыг цөөн үгээр, товч асуух, хариулах зарчмыг баримтлан ажилласнаар хүүхэд өөрөө сонирхосон зүйлийн талаар асуудаг болсон.
- 
- Д-г өөрийгөө танилцуулах, бусадтай мэндлэх, харилцах чадварт сургах зорилгоор хичээл эхлэхийн өмнө мэндлэн, юу хийсэн, юу хийхийг хүсэж байгаа талаар чөлөөтэй ярилцаж байсан нь хүүхдийн харилцах чадварыг сайжруулж, үр дүнгээ үзүүлж байв.
 - Д нь дуу сонсох, дуулах дуртай тул шинээр дуу зааж өгсөн. “Гурван тоорой” дууг 3-н удаа сонсгож эхний бадгийг 2 удаа багштайгаа давтан дуулаад үгээ цээжилсэн тул үргэлжлүүлэн сүүлийн 2 бадгийг заасан. Дууны фонограмм буюу хөгжмийг дагаад дуртай дуулж байв. Цэцэрлэгийн насны дүү нь хамтдаа дуулж хүүд урам өгч, сонирхолтой байгаа нь ажиглагдаж, хурдан сурахад нөлөөлсөн юм.
 - Гар хурууны жижиг булчингийн ажиллагааг сайжруулах зорилгоор цахилгаан татах, товч товчлох, цүнхний түгжээ тайлах гэх мэт дасгал хийлгэхийн тулд багш аяганы алчуур ашиглан цахилгаантай, товчтой, уяатай гурван цамц хийж хүүхэдтэй хамтран дасгал ажлыг хийж байна. Товч товчлох, тайлах, цахилгаан татах, уяа уях дасгалыг багш, эцэг эх хүүхдийн гарыг барьж хийлгэж байна. Одоохондоо үр дүн харагдахгүй байгаа ч олон удаагийн давталттай хийлгэсээр байгаа болно. Энэхүү дасгалыг хийлгэснээр гарын хурууны булчингийн үйл ажиллагаа, цусны эргэлт сайжирч болох тул өдөр болгон гэрийх нь гишүүд хийлгэж байна.

Хүүхдэд гарсан өөрчлөлт:

- Багшийгаа ирэх өдөр, цагийг маш сайн мэддэг.
- Хичээл орохыг хүлээдэг.
- Багшийг ирэхэд хичээлээ эхлэхэд өөрийгөө бэлдүүлэн бэлэн болсон байдаг.



- Д нь сурах хүсэл эрмэлзэлтэй, өөрийгөө маш сайн дайчилдаг. Ээж О нь идэвхтэй, сайн гүйцэтгүүлэгч, туслах багш тул хүүхдийн гэрийн даалгаварыг сайн давтуулдаг. Ийм учираас хүүхэд шинээр үзсэн хичээлээ сэргээн санахад төвөггүй, цаг алдадгүй байлаа.
- Эцэг, эхийн дэмжлэг сайн, дээр нь 1-р ангид сурч байгаа дүү нь үзсэн үсгийг бататган зааж өгч, хамтран сурч байгаа нь сургалтыг үр дүнтэй болгоход ач холбогдолтой байсан.

Багшид гарсан өөрчлөлт:

- Багшийн зүгээс хөгжлийн хүнд хэлбэрийн онцлог бүхий, хэвтрийн хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмшин, өөрөө хөгжин, цаашид сургалтын арга барилаа сайжруулж болох гарц боломжийг эрэлхийлж байна.
- Хүүхдийн хичээлд хэрэглэгдэх сургалтын материалыг Насан туршийн боловсролын төвийн багш нар баг, хамт олноороо хамтран хийж хэрэглэж байсан нь нэг талаас хугацаа хэмнэх, нөгөө талаас ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн дагуу хоорондоо зөвлөлдөн тухайн хүүхдийн хэрэгцээг хангах чанартай хэрэглэгдэхүүн бэлтгэж, сургалтын материалын нөөцтэй болох эхлэл тавигдсан.
- Багш нар гэрийн сургалтад ашиглах хичээлийн хэрэглэгдэхүүний сантай болж, дэвтэр гарган ашиглалтыг хөтөлж заншсан.
- Хичээлд ашиглаж буй сургалтын материал таалагдсан тохиолдолд хүүхэд “дахиад давтъя, би өөрөө” гэх мэт идэвхитэй хандлагыг үзүүлж байгаа нь багш нар хэрэглэгдэхүүнийг өнгөлөг, хүүхдийн сонирхол татахуйц хийж байхыг дахин сануулж байв.

Дүгнэлт:

Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн хүүхдийн сурах эрхийг хангаж гэрээр боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулснаар:

- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ суралцах чадваргүй гэсэн бодол нь өөрчлөгдөж, цаашид үргэлжлүүлэн сургах хүсэл, сонирхолтой болсон.
- Хүүхэд өөрөө сурч боловсрох, ихийг мэдэх хүсэл, сонирхол, эрмэлзэлтэй болсон.



- Багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан.
- Эцэг эх нь тусгай хэрэгцээт хүүхэдтэйгээ ажиллах арга зүйгээс суралцсан.
- НТБТ-ийн багш нар гэрээр боловсрол нөхөн олгох сургалтаар тусгай хэрэгцээтэй хүүхдэд боловсролын үйлчилгээг үзүүлж чаддаг болсон.
- Тойргийн ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төв, харьяа эрүүл мэндийн төв, баг, хороодын Засаг дарга, нийгмийн ажилтны болон бусад байгууллага, хувь хүмүүсийн хоорондын хамтын ажиллагаа сайжирч эхэлсэн.

Багшийн санал:

1. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сурах эрхийг хангах бодлогын баримт бичиг, түүнийг дагасан санхүүжилтийн асуудлыг улсын хэмжээнд бодитой шийдвэрлэх
2. Хөгжлийн онцлог бүхий болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн хүүхдүүдийг гэрээр сурах боломжоор хангах
3. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийг сурах орчин, сургалтын материал, унаа тэрэг, сайн дурын идэвхтэн багш нараар хангах
4. Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын боловсролд болон хүүхдийн онцлогт хандах сөрөг хандлага, ойлголтыг өөрчлөх төрөл бүрийн ажлыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан системтэй явуулдаг болох зэрэг.

Жич: хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн хүүхдүүдийг гэрээр сургахад төслийн хүрээнд багш нарыг системтэй бэлтгэх, чадавхжуулах, санхүүжилтээр дэмжих, унааны мөнгө зэргийг олгож байсан нь дээрх сургалтыг зохион байгуулах, тусгай хэрэгцээт хүүхдэд боловсролын үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг болсон болно.



ХАВСРАЛТ 6

ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР


(Гэрээр боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдаж буй
суралцагч О.Д-ийн хичээлд хэрэглэсэн)

а. Математикийн ээлжит хичээлийн хөтөлбөр

Сэдэв: “ Арав” -ын тоо

Зорилго: “ 10”-ын тоог таниулах

Зорилт: 1-10 хүртэлх тоог бичиж, унших, тооны бүтцийг гүйцээх, тэмдэглэх, жишиж харьцуулах

№	Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Арга зүй	Хэрэглэг дэхүүн																																	
1.	Сэргээн санах	Зургаас 10 ширхэгтэй зүйлсийг тоолуулан нэрлэнэ. Гарын хуруу, шагай, чулуу, бөглөө, сампин зэрэг бодит юмс ашиглан 10-ын тооны бүтцийг гаргана. Багш гарыг давхар барьж хамтран хийж мэдлэг бүтээх дасгал хийх. Арван нэгж нийлж арвын багц үүсгэдэг бөгөөд арав нь мөн 2 таваас бүтдэг гэдгийг ярилцан шоогоор дүрсэлж үзүүлнэ. Дасгал: 10-ын тооны сампинд хийх хоёр аргыг сурах бичигт үзүүлснээр, мөн өөрөөр нь хийлгэн тайлбарлан ойлгуулна. Дасгал: 10-ын тооны бүтцийг үзүүлсэн “гэр” загварыг нөхөх дасгал хийлгэснээр тооны бүтцийн олон янзын загвар байж болохыг ойлгуулна.			Зураг зургийг үзэх, харах ажиглах, ярилцах боломж олгохын зэрэгцээ тодорхой үйллэг биечлэн үзүүлэх, арил, бүтээх, хэрэглэх, тоглох үйл ажиллагаануудыг дэс дараатай төлөвлөн ганцаарчилан ажиглах хэлбэрийг сонгоно.																																	
2.	Шинэ мэдлэг олгох	Дасгал: Тодорхой тооны юмсыг тоолж, будах, цифрээр нэрлэх даалгавар өгч идэвхийг өрнүүлнэ. Мөн гүйцээн тоолох дасгал хийлгэнэ. Шоон загвар ашиглан тоог дүрслэх тавт аравтын загвараар тоог бүтээх, түүнийгээ дүрсээр илэрхийлэх, геометрийн дүрсэд оруулах зэрэг үйлдлүүдийг хийлгэнэ. Дасгал: 6-ын тооны бүтцийн дасгалыг зурганд үзүүлснээр тайлбарлуулна.	<table border="1"><tr><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td></tr><tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr><tr><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td><td></td><td>1</td><td>0</td></tr></table> 10 –ын цифрийг ажиллах 	1	0		1	0		1	0		1	0												1	0		1	0		1	0		1	0		Зураг зургийг үзэх, харах ажиглах, ярилцах боломж олгохын зэрэгцээ тодорхой үйллэг биечлэн үзүүлэх, арил, бүтээх, хэрэглэх, тоглох үйл ажиллагаануудыг дэс дараатай төлөвлөн ганцаарчилан ажиглах хэлбэрийг сонгоно.
1	0		1	0		1	0		1	0																												
1	0		1	0		1	0		1	0																												
3.	Багагтал	1-10 хүртэлх тоог таних болсон тул арав гэж юу вэ? гэдэг дууг бүтцээр нь хамтран дуулж 1-10 хүртэлх тоог өгсүүлж, уруудуулж хурдан тоолуулна. Гэрийн даалгаварт: Цээжээр тоог нэрлэнэ. Цифр хараад шууд нэрлэдэг болгох.																																				
4.	Дүгнэлт	Арав гэж юу вэ? Хүн бүхэн арван хуруутай Хүссэн бүхнээ бүтээх чадалтай дууг дуулна. Мөн 10-ын цифрийг хаанаас эхэлж, хаана төгсөж байгааг ажиглан хичээнгүй бичих алхмуудыг хийж гүйцэтгэнэ.			Сурах бичиг, 1-10 хүртэлх тооны бичмэл ба дармал картууд, хувирттай шугам, зурагт үзүүлэн, тооны бүтцийг нөхөх байшинг үзүүлэн, өнгийн харандаа гэх мэт																																	



б. Математикийн ээлжит хичээлийг бататгах хөтөлбөр | нэмэх ба хасах үйлдэл |

Сэдэв: “Нэгээр нэмэгдүүлэх” (давтах)

Зорилго: Нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулах, дугаарлаж сургах

Зорилт: Нэгээр нэмэгдүүлэх ба хорогдуулах аргад суралцах

№	Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Суралцагчийн үйл ажиллагаа	Арга зүй	Хэрэглэг дэхүүн
1.	Сэргээн санах	Нэг нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулахыг дугаарлал, дараалал гэх ойлголт дээр тулгуурлан олгоно. Нэгээр нэмэгдүүлэхийг таниулахдаа эхлээд бодит юмсыг 1-ээр нэмэгдүүлэх үйлийг үзүүлсэн эх зураг, хөдөлгөөнт зургуудыг харуулж асууж ярилцана. Дүрсийн загвар дээр энэ үйлийг олон удаа хийлгэнэ. Хүүхдээр дүгнэлтийг гаргуулна. $1 + 1$ гэсэн үйлийг [хоёр юмыг нийлүүлсэн бол тэдгээрийн хооронд “+” тэмдэг тавина. Харин үр дүнг тооцохгүйг харуулж байна. $4 + 1 = 5$ [байгаа юман дээр нэмэгдсэн тул үйлийг гүйцэтгэхэд сургана. Уншихдаа: “дөрөв нэмэх нэг, тэнцүү тав”, эсвэл “4 ба 1-ийн нийлбэр 5” гэж багш үлгэрлэн хэлж суралцагч дагаж уншина.	 Нэг нэгээр нэмэгдүүлэх Нэгээр нэмэгдүүлэх болон хорогдуулах үйлийг манжингийн үлгэрээр төлөөлүүлэн ярилцана. Ихэсгэх, багасгах гэдгийг суралцагч өөрөө дүгнэлт гарган ойлгоно. $1 + 1 = 2$ $2 + 1 = 3$ $3 + 1 = 4$ $4 + 1 = 5$ $5 + 1 = 6$ $6 + 1 = 7$ $7 + 1 = 8$ $8 + 1 = 9$ $1 - 1 = 0$ $2 - 1 = 1$ $3 - 1 = 2$ $4 - 1 = 3$	Нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулахыг дугаарлал, дараалал гэх ойлголт дээр тулгуурлан олгоно. Нэгээр нэмэгдүүлэхийг таниулахдаа эхлээд бодит юмсыг 1-ээр нэмэгдүүлэх үйлийг үзүүлсэн эх зураг, хөдөлгөөнт зургуудыг харуулж асууж ярилцана. Дүрсийн загвар дээр энэ үйлийг олон удаа хийлгэнэ. Хүүхдээр дүгнэлтийг гаргуулна.	Нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулахыг дугаарлал, дараалал гэх ойлголт дээр тулгуурлан олгоно. Нэгээр нэмэгдүүлэхийг таниулахдаа эхлээд бодит юмсыг 1-ээр нэмэгдүүлэх үйлийг үзүүлсэн эх зураг, хөдөлгөөнт зургуудыг харуулж асууж ярилцана. Дүрсийн загвар дээр энэ үйлийг олон удаа хийлгэнэ. Хүүхдээр дүгнэлтийг гаргуулна.
2.	Шинэ мэдлэг олгох	Дээрх үйлийг хуваарьтай шугам дээр гүйцэтгэж ярилцана. Мөн тоглоомон даалуу буюу домино дээрх нүдний тоог тоолуулж нэмэх үйлийг гүйцэтгүүлнэ. Дасгал: Мөчир дээр хэдэн болжмор сууж байна вэ? Тэдэн дээр хэдэн болжмор нисэн ирж нэмэгдсэн бэ? гэх мэтээр хүүхдийн хэл яриаг хөгжүүлнэ. Мөн сурах бичиг дээрх зурган бичвэрийг ийм маягаар өгүүлбэртэй бодлого зохиож бодохоор, бүтээлч байдлаар оруулна.	$5 - 1 = 4$ $6 - 1 = 5$ $7 - 1 = 6$ $8 - 1 = 7$ $9 - 1 = 8$ $10 - 1 = 9$ гэх мэтчилэн. Дасгал: Хэд дээр 1-ийг нэмбэл тус бүр 4, 5, 6, 7, 8, 9, 10 болох вэ? гэсэн зураглалыг ажиглан хоосон нүдийг нөхөж хэлнэ. Энэ нь алгебрийн тэгштгэлийн тухай ойлголтын суурийг тавьж буй дасгал ажил болно. Мөн янз бүрийн дүрс, биет, тоглоом ашиглан нэгээр нэмэгдүүлж буй үйлийг олон удаа хийлгэж ярилцаад хүүхдээр өөрөөр нь дүгнэлт гаргуулна. Нэмэх үйлийг таниулсан аргаар хасах үйлийг мөн адил таниулна.	Нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулахыг дугаарлал, дараалал гэх ойлголт дээр тулгуурлан олгоно. Нэгээр нэмэгдүүлэхийг таниулахдаа эхлээд бодит юмсыг 1-ээр нэмэгдүүлэх үйлийг үзүүлсэн эх зураг, хөдөлгөөнт зургуудыг харуулж асууж ярилцана. Дүрсийн загвар дээр энэ үйлийг олон удаа хийлгэнэ. Хүүхдээр дүгнэлтийг гаргуулна.	Нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулахыг дугаарлал, дараалал гэх ойлголт дээр тулгуурлан олгоно. Нэгээр нэмэгдүүлэхийг таниулахдаа эхлээд бодит юмсыг 1-ээр нэмэгдүүлэх үйлийг үзүүлсэн эх зураг, хөдөлгөөнт зургуудыг харуулж асууж ярилцана. Дүрсийн загвар дээр энэ үйлийг олон удаа хийлгэнэ. Хүүхдээр дүгнэлтийг гаргуулна.
3.	Бататгал	Сурах бичиг дээрх дасгал ажлыг гүйцэтгэнэ: $1 > 0$ $1 + 1 = 2 < 2 + 1 = 3$, $6 - 1 = 5 < 7 - 1 = 6$, $10 - 1 = 9 > 9 - 1 = 8$ цээжээр бодох дасгал ажил			
4.	Дүгнэлт	Тоог нэгээр нэмэгдүүлэхэд дараагийн тоо гарна. Тоог нэгээр хорогдуулахад өмнөх тоо гарна гэсэн дүгнэлтийг тоон цуваан дээр ажиглалт хийж гаргана.			



ХАВСРАЛТ 7

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ХУУДАС

НТБТ/сургууль:

Багшийн нэр:

Хүүхдийн нэр:

Хичээлийн сэдэв:

Он ... сар ... өдөр

Ажиглах/хянах зүйл	Шалгуур үзүүлэлт	Засан сайжруулах	Дэмжлэг үзүүлэх	Тайлбар зөвлөмж
Хичээлийн эхлэл удиртгал	Сэдэл төрж, сонирхож байгаа эсэх			
	Хичээлийн зорилгыг ойлгосон эсэх			
Хичээлийн агуулга	Хичээлийн сэдэв болон залгамж холбоо			
	Амьдрал ахуйдаа хэрэглэх чадвар			
	Агуулгын оновчтой байдал /нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байдал/			
Арга зүй	Суралцагчид дэмжлэг үзүүлсэн байдал			
	Суралцагчид зөв ойлгомжтой тайлбар, зааварчилгаа өгсөн эсэх			
	Хүүхэд хичээлээ ойлгож буй эсэх			
Багшийн харилцаа	Суралцагчийн гүйцэтгэсэн ажилд дэмжлэг үзүүлсэн байдал			
	Хүүхдийн сурах арга барилд хүндэтгэлтэй хандсан байдал			
Сургалтын хэрэглэгдэхүүн	Сургалтын хэрэглэгдэхүүн тохирсон байдал			
	Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах чадвар			
	Бие даан бүтээлчээр ажиллах чадвар			
	Хэрэглээ болгон ашиглах чадвар			
Орчин	Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж чадсан эсэх			
	Хичээл сургалтын орчинг бүрдүүлсэн эсэх			
Үнэлгээ	Суралцагчийн хийсэн зүйл, гүйцэтгэсэн даалгаврыг үнэлж, урам өгсөн эсэх			
	Үнэлгээний олон хэлбэрийг ашиглаж чадсан эсэх			
Дүгнэлт	Суралцагчийн сэтгэл хангалуун байдал			



ХАВСРАЛТ 8

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ АЖИГЛАЛТЫН ХУУДАС

Тайлбар:

Хүүхэд тус бүрийн чадвараас хамааран “Чаддаггүй” бол 1, “Дэмжлэгтэй” бол 2, “Чаддаг” бол 3 гэсэн үнэлгээг хүснэгтэд тэмдэглэнэ. Нийт онооны дүнг тухайн хэсгийн чадварын тоонд хувааж “Гүйцэтгэлийн дундаж” гарна.

1. Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар

№	Чадвар	Чаддаг-гүй	Дэмж-лэгтэй	Чаддаг
1.1	Шалан дээр байгаа зүйлийг доош бөхийн барьж авна.			
1.2	Ор болон өндөр сандал дээр гарч, бууж чадна.			
1.3	Том хайрцагт юмсыг зөөж хийнэ.			
1.4	Хөтөвч, суултуурт бие засахдаа өөрөө сууж, босно.			
1.5	Шатаар өгсөж, уруудна.			
1.6	Аяга, халбагаа зөв барьж хэрэглэнэ.			
1.7	Зузаан (картонон) хуудастай номын хуудсыг нэг нэгээр нь эргүүлнэ.			
1.8	Бүдүүн харандаа, тосон харандаа ашиглаж, цаасан дээр зураас татна.			
1.9	Хувцсаа өөрөө тайлна.			
1.10	Гараа угааж, арчина.			
1.11	Цэвэрхэн хооллоно.			
1.12	“Болно”, “Болохгүй” гэсэн энгийн зааврыг ойлгож биелүүлнэ.			



2. Нийгэмшихүйн чадвар

№	Чадвар	Чаддаг-гүй	Дэмж-лэгтэй	Чаддаг
2.1	Өөрийн эд юмсыг бусдынхаас ялгана.			
2.2	“Би өөрөө” гэж үйл хийхийг эрхэмлэнэ.			
2.3	Өөрийн хэрэгцээг дуу авиа, нүүрний хувирал, үгээр илэрхийлнэ.			
2.4	Ойр орчныхоо хүнтэй дотносно.			
2.5	Тааламжтай байгаагаа илэрхийлнэ. (Жишээ нь: Хөгжим сонсоод инээмсэглэх, биеэрээ найгах)			
2.6	Өөртөө тааламжгүй байдлыг дуу авиа, үг, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлж, насанд хүрэгчдээс тусламж, чиглэл хүлээнэ.			
2.7	Юмсыг зориулалтаар нь хэрэглэнэ. (Жишээ нь: Харандаагаар зурах, халбагаар хоол идэх, хөтөвч хэрэглэх)			
2.8	Бусдын үйлдлийг ажиглана, дуурайна. (Жишээ нь: Хүүхэлдэй бүүвэйлнэ, хооллоно)			

3. Оюун ухааны чадвар

№	Чадвар	Чаддаг-гүй	Дэмж-лэгтэй	Чаддаг
3.1	Хүн, амьтан, юмсыг зургаас таньж, асуухад зааж нэрлэнэ.			
3.2	Амьтдын дуу авиаг дуурайж дуугарна.			
3.3	Юмсыг төрлөөр нь ялгана. (Жишээ нь: Бөмбөг, машиныг тус тусад нь)			
3.4	Янз бүрийн хэмжээ, хэлбэртэй тоглоомоор тоглоно, асуухад “том”, “жижиг”-ийг заана, хэлнэ.			



3.5	“Нэг”, “Олон”-г ялгаж хэлнэ.			
3.6	Гэр болон цэцэрлэгт байгаа дуртай зүйлийнхээ байрлалыг мэднэ.			
3.7	Хогийг саванд нь хийнэ.			
3.8	Нэг үйлдэлт зааврыг дагана. (Жишээ нь: “Надад бөмбөг аваад ир” гэхэд авчрах)			
3.9	Богино өгүүлбэрээр ярина. (Жишээ нь: “Би явна”, “Ээждээ өгнө”)			



ЗАРИМ ҮГСИЙН ТОВЧ ТАЙЛБАР

Албан боловсрол – сургуулиар олгож буй боловсрол

Албан бус боловсрол - боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа

Амьдралаас суралцах боловсрол – амьдрах, аж төрөх явцдаа олж авах боловсрол

Боловсрол нөхөн олгох сургалт - тухайн түвшний боловсролыг албан бус хэлбэрээр олгох сургалт

Ерөнхий чадвар – бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд суралцагчийн бүх хичээлээр эзэмших нэгдмэл чадвар

Залгамж холбоо – хичээлийн агуулга, түүнийг эзэмших арга зүй, суралцагчийн өмнө нь эзэмшсэн болон эзэмших чадвар, ахиц өөрчлөлтийн уялдаа холбоо

Дүйцсэн хөтөлбөр - бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшээгүй сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгчдэд албан бус боловсролын хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролыг нөхөн олгоход чиглэсэн албан бус боловсролын сургалтын хөтөлбөр

Модуль - бүхэл тогтолцооны нэгэн чухал хэсэг, түүнгүйгээр дидактик тогтолцоо бүрдэхгүй. Модулийн үндсэн шинж-түүнийг хичнээн салгаж, бас нийлүүлэвч модуль хэвээр үлддэг явдал юм.

Модуль сургалт - агуулга нь зорилгоо бүрэн хангах бие даасан иж бүрдлээр суралцах явцад сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээнд суралцагч дээд зэргээр бие даан оролцох боломж бүрдүүлдэг сургалт.

Модуль сургалтын технологийн мөн чанар - сургалтын объект, субъектын үндсийг өөрчилж суралцагчийн сэдлийн хүрээ, оюун ухаан, бие даасан байдал хөгжих, танин мэдэх үйл ажиллагаагаа өөрөө удирдах чадвар эзэмшүүлэхэд оршино, өөрөөр хэлбэл, суралцагч сурах үйлийн субъект, объектын үүргийг зэрэг гүйцэтгэнэ

Насан туршийн боловсрол - бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагаа



Сургууль завсардагч - ерөнхий боловсролын сургуульд суралцаж байсан боловч сургалтын хөтөлбөрөө дуусгалгүйгээр сургуулиа орхисон сургуулийн насны хүүхэд

Сургуулийн гадна байгаа хүүхэд - сургуулийн насны хүүхдийн ангилалд багтаж байгаа боловч сургуульд огт суралцаж байгаагүй хүүхэд

Тусгай хэрэгцээт боловсрол - боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц

Тусгай чадвар – тухайн хичээлээр суралцагчийн эзэмших чадвар

Тэгш хамруулах боловсрол - ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн тасралтгүй үйл явц

Холимог бүлгийн сургалт - цаг хугацаа болон орон зайн хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш түвшинд суралцагчид хамт хичээллэх сургалтын хэлбэр

Хөгжлийн бэрхшээлтэй хүн - бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн согогтой нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Холимог бүлгийн сургалтын арга зүй. УБ., 2009
2. Холимог бүлгийн сургалтыг зохион байгуулах аргачлал. УБ., 2004
3. Холимог бүлгийн сургалт Монголд. УБ., 2004
4. Холимог бүлгийн сургалтын модуль. УБ., 2005
5. Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр. УБ., 2007
6. Албан бус боловсролын салбарын судалгаа. УБ., 2009
7. Суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хийсэн дүн шинжилгээ. УБ., 2010
8. Статистикийн жилийн эмхэтгэл. УБ., 2017
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. УБ., 2017
10. Ш.Шагдар. Монголын боловсролын түүхэн товчоон., УБ
11. Д.Одгэрэл нар. Тэгш хамруулах боловсрол. УБ., 2016
12. Бага насны хүүхдэд тусгай боловсролын үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гарын авлага. УБ., 2008
13. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийг судлах арга зүйн зөвлөмж. УБ., 2011
14. “Сургууль-Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй” сургалтын модуль. УБ., 2017
15. “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” сургалтын модуль. УБ., 2018
16. ЮНЕСКО-ийн гишүүн орнуудын Тусгай боловсролын хурлаас батлагдсан Саламанкагийн тунхаглал. 3-р бүлэг.
17. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга ба дүн шинжилгээ” судалгаа. УБ., 2011
18. “Насан туршийн боловсролын төв, нэгжийн дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй суралцагчид” үндэсний хэмжээнд хийсэн судалгаа 2016-2017. УБ., 2017